Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2012. 11 сар. №21 (031) www.mongolianeconomy.mn

Эрсдэлд ээрүүлсэн санхүүгийн зах зээл

Тэвч, итгэ, хүлээ



ХӨРӨНГИЙН УРСГАЛЫГ ДОТООДДОО АРГАМЖЪЯ

НОМИН КОНСТРАКШН

ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ

RIVER GARDEN
Ever green





PENTHOUSE 161.4m2 - 395.5m2

APARTMENT 106m2 - 282m2



EVER GREEN

МОНГОЛЫН №1 НОГООН ХОТХОН

НОГООН ОРЧНЫГ ЭРХЭМЛЭГЧ ХҮН БҮРТ ЗОРИУЛАВ



Захиалга авах хаяг:
УИД-ийн 1 давхарт баруун жигүүр
RIVER GARDEN хотхон - ЗАГВАРЫН БАЙР

өдөр бүр 09^{00} - 18^{00}

Утас: 9901-3893 9903-3893 English Russian
9910-3893 9905-3893 English
9595-3893 9907-3893 Korean

www.rivergarden.mn

COAL MONGOLIA 2013

3 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН НҮҮРСНИЙ САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

2013 оны 2 сарын 21-22

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS CONVENTION CENTER

Чуулга уулзалт, үзэсгэлэн нь Монгол Улсад хэрэгжүүлж буй нүүрсний хайгуул, олборлолт, боловсруулалтын төслүүдэд хөрөнгө оруулалт татах, нүүрсний салбарт төрөөс баримтлах бодлогыг танилцуулах, байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, олон улсын харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж Монгол Улсын нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой.

БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ

Хуралд **нэгдүгээр** сарын **15**-наас өмнө бүртгүүлвэл **20%** хөнгөлөлттэй

Үзэсгэлэнд **арванхоёрдугаар** сарын **15**-наас өмнө бүртгүүлвэл **5%** хөнгөлөлттэй

Platinum sponsor: MONGOLIAN MINING CORPORATION

Diamond sponsor: HUNNU COAL

Gold sponsor: XacBank Right Bank; ASPIRE MINING LTD

Event sponsor: KHAN BANK YOUR TRUSTED FRIEND; WAGNER CAT; MINES UP; MobiNet

Bank of the event: TDB TRADE & DEVELOPMENT BANK

Supporting organizations: THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA; Mongolian Mining Club; ZAZA CORPORATE COUNSEL LLC; NAMBC

International media partners: Bloomberg TV MONGOLIA; InfoMine Mining Intelligence & Technology; MINING LEADERS; The ASIA Miner; COAL SPOT.COM; WORLD COAL; Mining Journal; commodity; excoal.com 中国煤炭资源网

Local media partners: MONGOLIAN ECONOMY; ӨГЛӨӨНИЙ СОНИН; MINING & MONEY УУЛ УУРХАЙ БА МӨНГӨ СЭТГҮҮЛ; Өдрийн Шүдан

Дэлгэрэнгүй мэдээллийг:
www.coalmongolia.mn, +976-70115590

Зохион байгуулагч: MINING.MN

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.Энхмарт /8801-0361

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: Б.Үүрийнтуяа
СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Б.Уганбаяр
Х.Хулан

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР: Ш.Оюундарь
ПРОГРАММИСТ: Н.Түвшинбаяр

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барианжав /8880-0825/
Д.Баттулга /9902-2279/
Б.Энхцэцэг /9901-5476/
БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш

“ECONOMY” ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ: Ц.Буянбат /8811-2885/
ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон
ГРАФИК ДИЗАЙН Г.Буянбаатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

MONGOLIAN ECONOMY

СЭТГҮҮЛ

ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ТАНЫ ОЮУНД

Ядуурал “цус дамждаг”



Уг нь төр, засаг ядуу иргэдээ хөдөлмөрлүүлж, хөрөнгөжүүлэх ёстой баймаар. Гэтэл өнөөдөр Монгол улс ядуу иргэдэд чиглэсэн халамжийн бодлого явуулна гэж яриад байдаг. Уг чанартаа ядуу иргэдэд халамжийн мөнгө олгох нь тэднийг сэтгэлгээний ядууралд түлхдэг аж...10

Хятад мөрөөдөл буюу урвуулах урлаг

Хагас зууны тэртээ 400 саяулаа байсан хятадууд өнөөдөр дэлхийн нийт хүн амын 19.12 хувь буюу 1.3 тэрбумыг бүрдүүлж байна. Тэдний 72.1 хувь нь 15-64 насныхан бөгөөд урд хөршийн хөдөлмөрийн чадвартай иргэд. Гэтэл тэдний ердөө 3.6 хувь нь л дунд буюу түүнээс дээш боловсролтой байдаг...22



Ногоон Олимп

Лондоны Олимпийн хотхоныг нийслэлийн зүүн хэсэгт байрлах Стратфорд дүүрэгт бүтээн байгуулсан билээ... 24





Тэрбээр бизнесийг уран барилгатай зүйрлэдэг

Түүний үндсэн хөрөнгө 2.3 тэрбум ам.доллар. Улсын “халаасанд” оруулсан татвар хийгээд дансан дахь мөнгөнийхөө хэмжээгээр Монголдоо тэргүүлэгч. Зарим нь түүнийг маш завгүй, үргэлж л шинийг эрэлхийлж, нэгээс нөгөө бизнесийг “ургуулахаар” гүйж явдаг хэмээн үнэлдэг. Харин зарим нь “Эх орноо хятадуудад худалдсан. Одоо эзэмшиж байгаа MCS группынх нь 75 хувь нь Хятадын мэдлийнх” гэдэг... 34

ЭДИЙН ЗАСАГ

8 Эдийн засгийн өсөлт сайхан, эрдэм боловсрол бүр сайхан

10 Ядуурал “цус дамждаг”

12 Хууль төвтэй төсөв

15 Эрсдэлд ээрүүлсэн санхүүгийн зах зээл

18 Хөрөнгийн урсгалыг дотооддоо аргамжъя

20 Тэвч, итгэ, хүлээ

22 Хятад мөрөөдөл буюу урвуулах урлаг

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

24 Ногоон олимп

26 Мөнх ногоон

28 Ирээдүйн хадгаламж

УУЛ УУРХАЙ

28 Ирээдүйн хадгаламж

30 “Малгай” хуулийн эрс шинэчлэл

32 Бид микрофоноо нээлттэй тавьдаг

БИЗНЕС

34 Тэрбээр бизнесийг уран барилгатай зүйрлэдэг

38 Бизнесийнхний чөлөөт индэр таван нас хүрлээ

40 Ашиг, нэр хүнд, үнэ цэнэ

42 Хамтын хүч

44 Ухаалаг хэрэглээ

БИЗНЕС



ОУСК болон Дэлхийн банкнаас Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд Монгол улс бизнес эрхлэлтийг хялбарчлах аргаараа тэргүүлэх орнуудын нэг боллоо гэжээ. Энэ талаар Дэлхийн банкны группын Дэлхийн үзүүлэлт, дүн шинжилгээний захирал Аугусто Лопез Кларос “Бизнес эрхлэлтийг хялбарчлахад хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн хувьд Монгол улс дэлхийн топ 10 орны жагсаалтад орлоо” гэсэн байна. Энэ төрөлд БНСУ долоо дахь жилдээ тэргүүлж, Хонконг, БНХАУ дараагийн байруудад оржээ.

ХҮНИЙ ХӨГЖИЛ

Дэлхийн эдийн засгийн форумаас эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн “The Global Gender Gap Report 2012” илтгэл номыг гаргалаа. Тэгш эрхийн жагсаалтад Исланд тэргүүлж, Норвеги, Финланд, Швед, Ирланд эхний байруудыг эзэлжээ. Харин Монгол улс энэ жил 135 орноос 44 дүгээр байрт орсон нь урд жилүүдээс ухарсан үзүүлэлт юм. Тухайлбал, 2011 онд 36, 2010 онд 27, 2009 онд 22 дугаар байрт шалгарч байсан аж. Монголын үзүүлэлтийг тусад нь авч үзвэл:

Эдийн засгийн оролцоо, боломж	1 байр	0.839
Боловсролын түвшин	50 байр	0.994
Эрүүл мэнд (дээд оноо 0.980)	1 байр	0.980
Улс төрийн эрх	127 байр	0.032

ДЭД БҮТЭЦ



Засгийн газрын хуралдаанаар төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгож, төслийн санхүүжилтийг төрийн өмч давамгайлсан байдлаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран зохион байгуулах үүргийг “Монголын төмөр зам” ТӨХК-д хүлээлгэлээ. Ийнхүү Төмөр замын I буюу Даланзадгад-Тавантолгой-Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан чиглэлийн 1100 км төмөр зам барих ажил ирэх оноос эхлэхээр боллоо.

ҮНЭ ХАНШ

“Мастер Проперти” судалгааны байгууллагын гаргасан III улирлын судалгаагаар орон сууцны үнэ өмнөх үеийн мөн үетэй харьцуулахад 21.3 хувь, өмнөх улиралтай харьцуулахад 3.9 хувиар өссөн байна. Тухайлбал, Сүхбаатар дүүрэгт орон сууцны үнэ 41 хувиар өссөн бол Хан-Уул дүүрэгт 15 хувиар өссөн үзүүлэлтэй байгаа юм. Харин Баянзүрх дүүрэгт үнийн өсөлт хамгийн бага буюу долоон хувьтай байна. Үнэ болон арилжааны банкуудын зээлийн хүү өсөж, буйтай холбоотойгоор орон сууцны худалдан авалт эрс багассан байна. Ялангуяа тансаг зэрэглэлийн байрны борлуулалт буурч буйг тус судалгааны төвийн мэргэжилтэн Д.Моломжамц онцолсон.

Орон сууцны зээлийн хүү/хувиар/

Банк	Хугацаа /жил/	Зээлийн хүү хувиар /сарын/	Зээлийн хүү хувиар /жил/	Урьдчилгаа
ХХБ	15	1,5-1,6	19,20	100
Голомт банк	15-20	1,65-1,7	20,40	120
Хаан банк	10	1,9-2,1	25,20	100
Улаанбаатар банк	15	1,9-2,1	25,20	100
Хас банк	20	1,5-1,7	20,40	Үнийн дүнгийн 60 хувь хүртэл
Төрийн банк	15	1,7	20,40	100
Хадгаламж банк	10	2,2-2,5	30	100

АЛТ

Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас 2013 оны алтны үнийн төсөөллиийг зарлажээ. Зургаан банкны шинжээчдийн үзсэнээр ирэх онд унци алтны дундаж үнэ 1809.3 ам.доллар байх аж. Харин одоогийн байдлаар /2012. XI.04/ унци алт 1725 ам.долларын үнэтэй байгааг BBC мэдээлж байна.

ЗЭС

Дэлхийн эдийн засгийн таагүй байдлаас шалтгаалж дэлхийн зах зээлд зэсийн үнэ 18 хувиар, нүүрснийх 38 хувиар буурах магадлалтай байна. Гэхдээ энэ онд Хятадын эдийн засаг зургаан хувиар өснө гэж тооцвол зэсийн эрэлт 2.9 хувь, нийлүүлэлт 2.8 хувиар өсөх аж. Мөн Евро бүсийн өсөлт ирэх оноос сэргэж эхэлнэ гэвэл зэсийн эрэлт 4.7 хувь нэмэгдэх аж. Ингэснээр зах зээлд 56 мянган тонн зэсийн дутахын зэрэгцээ тонн зэсийг 8456 ам.доллартхүртэл өсгөх боломжтой хэмээн таамаглаж байна.

НҮҮРС

АНУ тэргүүтэй орнууд байгалийн хий, усан цахилгаан станц зэрэг байгальд ээлтэй эрчим хүч хэрэглэхийг илүүд үзэх болсон нь нүүрсний үнэ буурахад нэрмээс болжээ. Энэтхэг болон бусад орны нүүрсний хэрэглээ буурснаар түүхий эдийн эрэлт оны эцэст хоёр хувьд хүрнэ хэмээн судлаачид таамагласан. Харин энэ онд нүүрсний хэрэглээгээ нэмэгдүүлэх гол бүс нь Евро бүс болоод байна. Эрчим хүчний нүүрсний үнэ хамгийн ихдээ энэ онд тонн нь 93 ам.доллар хүрэх аж. Харин “Bloomberg”-ийн судлаачид 2013-2014 онд нэг тонн нь 97 ам.доллар хүрнэ хэмээн таамаглаж байна.

ЕРТӨНЦ

ХЯТАД

Хятадын үйлдвэрлэл өнгөрсөн гурван сарын хугацаан дахь хамгийн өндөр үзүүлэлтдээ хүрчээ. Үүнийг зарим шинжээч тус улсын эдийн засаг сэргэж буйн дохио гэж байна. Тухайлбал, Хятадын үйлдвэрлэлийн захиалгын индекс энэ оны есдүгээр сард 49.8 хувь байсан аравдугаар сард 50.2 хувь болж өсчээ. Энэ тухай мэдээллийг тус улсын Засгийн газраас өгөв.

Хятадын "Dagong Global", ОХУ-ын "RusRating" болон АНУ-ын "Egan-Jones" үнэлгээний агентлагууд хамтран "Universal Credit Rating Group" үнэлгээний агентлаг байгуулахаар болсон тухай ОХУ-ын "Правда" цахим хуудаст мэдээллээ. Дээрх байгууллагууд дэлхийн "Гурван том" гэгдэх "Fitch", "Standard & Poorы" болон "Moody's"-ын зэрэглэл тогтоох системийг олон улсын жишгээс хоцрогдсон, үйлчлүүлэгч байгууллагуудын үнэлгээг хэт өндөр тогтоож, бодит мэдээллийг гуйвуулдаг гэж үзсэн тул ийнхүү нэгдэхээр шийджээ. Ирэх онд үйл ажиллагаагаа эхлүүлэх Universal Credit Rating Group үнэлгээний агентлагийг санаачлагчид үйлчлүүлэгч байгууллагуудаас санхүүжилт авахгүй гэдгээрээ бие даасан статусаа хадгалж, улмаар бодит үнэлгээ, зэрэглэл тогтоож чадна хэмээн мэдээлжээ.

ОРОС

ОХУ энэ онд 300 тэрбум рубль буюу 19.4 тэрбум ам.доллартай тэнцэх өмч хувьчлал явуулжээ. Тус улсын Ерөнхий Шадар сайд Игорь Шувалов "Засгийн газар төрийн өмчит Роснефть-ийг хувьчлах асуудлыг хэлэлцэж байна. Роснефть бол эрчим хүчтэй холбоотой хөрөнгө учраас томоохон хөрөнгө оруулагчид хувьчлахад бэлэн" гэсэн байна. Түүнчлэн "ОХУ-ын төрийн өмчид байдаг гол хөрөнгүүдийг 2016 он гэхэд бүрэн хувьчилж дуусгах төлөвлөгөөтэй байна" гэжээ. Тус улсын Эдийн засгийн хөгжлийн яамны мэдээгээр 75.5 хувь нь төрийн мэдэлд байдаг "VTB" банк, "Россельхобанк", "Росагролизинг", "Совкомфлот", "Шереметево" нисэх онгоцны буудал, "Аэрофлот" "United Grain Company", "Алроса", зэрэг төрийн өмчит компанийг хувьчлахаар болоод байгаа ажээ. ■



Шог зургийг А.Амарсайхан

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ САЙХАН, ЭРДЭМ БОЛОВСРОЛ БҮР САЙХАН

И.ОТГОН

барууны их, дээд сургуульд суралцаж, эрдмийн зэрэг, цол хамгаалсан мундаг залуус 2010 оноос эх орондоо буцаж ирэх болсон. Их мөрөн дөлгөөн гэгчээр тэдний ихэнх нь их, дээд суургуульд багшилж, даруухан амьдарч байна.

Монгол улс дэлхийн тавцанд од болон гялалзсаар. Энэ оны эхний улиралд манай эдийн засаг 16.7 хувь буюу хамгийн өндөр өсөлт үзүүлж, дэлхийн анхаарлыг дахин татсан. Монголын эдийн засгийн луу жилийн гараа сайн байсан бол бариандч энэ эрчээ тэдийлэн алдахгүй орох нь тодорхой байна. Холбогдох байгууллагууд ирэх онд манай эдийн засгийн өсөлт дунджаар 12-14 хувьтай байна гэсэн таамаг ч гаргаад буй. Түүнчлэн Олон улсын санхүүгийн корпораци болон Дэлхийн банкнаас хийсэн судалгаанд Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд Монгол бизнес эрхлэлтийг хялбарчлах аргаараа тэргүүлэх 10 орны жагсаалтад багтсан таатай мэдээ байна. Мөн 2030 он хүртэл Монгол дэлхийн хамгийн эрчимтэй хөгжлийн төв байна гэж Дэлхийн эдийн засгийн тоймд онцолжээ. Монголын эдийн засгийн худацтай хөгжилтэй холбоотой таатай мэдээ дотоод, гадаад зах зээлд ийн цуурайтсаар. Сайхан л хэрэг. Гэхдээ дотооддоо ялангуяа бодлого тодорхойлж, шийдвэр гаргах түвшний хүмүүс, улстөрчид энэ мэт сайхан мэдээнд хий хөөрцөглөж, цээжээ дэлдэх биш, юу нь болж байна, болохгүй байна гэдгийг ул суурьтай тунгаан бодох цаг болсон. “Mongolian Economy” сэтгүүл энэ удаагийн дугаарынхаа гол нийтлэлүүдийг үүнд чиглүүллээ. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарын түүхий эдийн экспортын орлогод суурилсан Монголын эдийн засгийн огцом өсөлт хэр урт настай вэ. Байгалийн баялгийн орлогын тэгш хуваарилалт, тогтвортой хөгжил бий болгохын тулд юу хийх ёстой вэ гэдэгт төрийн бодлого, зохицуулалт зөв чиглэх учиртай.

Өнөөдрийн бидний сайрхаад буй эдийн засгийн өндөр өсөлт үнэндээ уул уурхайн салбарын түүхий эдийн экспорт, Засгийн газрын зардлаас шалтгаалсан гэдгийг санахад илүүдэхгүй.

“Монголын эдийн засагт уул уурхайн салбар хүссэн ч эс хүссэн ч тэргүүлэх байр сууриа ойрын 30 жилд хадгална” гэж Монгол улсын анхны Ерөнхийлөгч асан П.Очирбат “Discover Mongolia -2012” –ын үеэр хэлсэн удаатай. Тиймээс уул уурхайн салбарын үсрэнгүй хөгжлийг дагаад Монголын төр уул уурхайн орлогын менежмент, “Голланд өвчин”-өөс сэргийлэх арга замууд, уул уурхайтай холбоотой макро эдийн засгийн эрсдэлүүд, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, үр ашигтай нийгмийн халамжийн үйлчилгээг бэхжүүлэх гэх мэт олон асуудалтай тулгарч буй.

Ийм тохиолдолд бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчид асуудалд нухацтай хандаж, мэдлэг оюунаа зузаатгах учиртай. Тийм шаардлага тэдэнд бий.

Учир нь, тогтвортой хөгжлийг дэмжихийн тулд өдгөөгийн макро эдийн засгийн бодлогуудын эдийн засгийн ашиг, зардлын шинжилгээг хийх хэрэгтэй болж байгаа тухай эдийн засагчид тэмдэглэж байна. Бодлого тодорхойлогчид болон судлаачид энэ тал дээр хамтран ажиллах шаардлага ч бий. Иймээс өнгөрсөн сарын 12-нд Эдийн засгийн судалгаа, эрдэм шижилгээний хүрээлэн /ERI/-гээс “Монголын эдийн засгийн бодлогын асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг салбарын мэргэжилтнүүдийн хүрээнд зохион байгуулсныг манай сэтгүүл энэ удаагийн дугаартаа онцолж байна.

Ялангуяа улстөрчдөд хэрэгтэй эдийн засгийн бодлогын судалгаанууд хийгдсэн байв. Энэ үеэр МУИС-ийн Эдийн засгийн сургууль, СЭЗДС, Дэлхийн банк, АХБ-ны судлаач- эдийн засагч нарын нийт 13 судалгааны бүтээлийг олон нийтэд танилцуулсан. ERI нь бодлогын судалгаа хийх, бодлогын талаар төрөл бүрийн хэлэлцүүлгүүдийг дэмжих, чанартай судалгаанд суурилсан хэлэлцүүлгийг бий болгох зорилготой. Тиймээс манай сэтгүүл нэлээд хүч хөдөлмөр, оюун бодлоо чилээн байж хийсэн уг бодлогын илтгэлүүдийг цувралаар олон нийтэд тэр дундаа шийдвэр гаргагчдын анхааралд хүргэхийг г зорилоо. Энэ удаа МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш доктор С.Даваасүрэнгийн “Эдийн засгийн өсөлт ба ядуурал”, мөн



тус сургуулийн багш доктор, дэд профессор Б.Эрдэнэбатын “Макро эдийн засгийн эрсдэлүүд ба тэдгээрээс зайлсхийх арга замууд”, СЭЗДС-ийн Эдийн засгийн онолын тэнхимийн эрхлэгч доктор, профессор Ц.Батсүх “Хүлээгдэж буй их хэмжээний хөрөнгийн урсгал болоод хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уул уурхай, аж үйлдвэрийн томоохон төслүүдээс үүдэлтэй “Голланд өвчинд” нэрвэгдэх эрсдэлийн үнэлгээ” гэсэн судалгааны бүтээлүүдийг ашиглан манай сэтгүүлчид гол нийтлэлүүдээ бичлээ. ERI нь 2010 онд байгуулагдсан цагаасаа Дэлхийн банкны Засаглалын түншлэл арга хэмжээний хүрээнд бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа аж. Эхний үр дүн нь бидний онцолж буй “Монголын эдийн засгийн бодлогын асуудлууд” хэлэлцүүлэг юм. ERI-ийн судалгааны ажил нь “Сохор шүүгч” буюу гаднын орны мэргэжлийн шүүгчдийн гараар орж, үнэлэлт дүгнэлт авсан байдаг аж.

Монгол улсад бараг бүх түвшинд судалгаа орхигдсон. Гэтэл дэлхийн өндөр хөгжилтэй болон манайхтай адил хөгжиж буй орнууд ямар ч үед судалгааг эрхэмлэдэгийг гадаадад явж, туршлага судлахаараа нэг болдог улстөрчид гадарладаг байх. Ялангуяа улстөрчид судалгааг онцгойлон авч үзэх учиртай хүмүүс. Өнөөдрийн манай төрийн бодлого, шийдвэр ямар ч судалгаагүй гарч байгаа нь ихээхэн гай тарьж байгаа юм. Бүх шийдвэрт улс төрийн тоглолт явагдаж, бүхэл бүтэн улсын асуудал улс төрийн хүрээний хоёр, гуравхан хүний эрх мэдлийн хүрээнд шийдэгддэг нь өнөөгийн Монголын нийгмийн гүн эмгэнэл гэж хэлж болно. Гэтэл улстөрчид болоод тэдний ах дүү, хамаатан садан, найз нөхөд, татаас түлхээс, нөхөөсний гэгдэх хүмүүс төрийн албанд шургалж, өөрсдийгөө ухаантайд тооцох нь бүр ч инээдтэй. Ийм зүйл үе үеийн төр, засагт байсаар ирсэн. Өдгөө бүр ч гаарах хандлагатай байгаа нь харамсалтай. Миний таних нэг бус хүн шинэчлэлийн Засгийн газрын төрийн байгууллагын удирдах албан тушаалд очжээ. Өмнө нь гудамжинд тааралд мэндэлдэг, Монголын эдийн засгийн талаар яриа хөөрөө өрнүүлдэг, авлига, хүнд суртал, төрийн шударга бус үйлдлийн талаар ярьж, зүрхээ өвтгөдөг байсан тэр хүн өөр болжээ. Ямар их аархаж онгирч байна аа. Өрөөлийг битгий хэл, өөрийгөө ч танихгүй болсон шинэхэн төрийн албаныхныг харахаар үнэн өрөвдөлтэй. Харин тэд өөрийгөө хамгаас ухаантай, мундаг тулдаа төрийн албанд очсон гэж хамраа сөхөж яваа нь энэ байх. Нэгэнт төрд шургалсан ийм хүмүүсийг яалтай. Харин тэд мэргэжлийн эдийн засагч-судлаачдын гаргаж тавьсан бодлогын судалгаануудтай сайтар танилцан, өөрт хэрэгтэй мэдлэг, мэдээллийг шүүрдэж, зөв ярьж, зөв шийдвэр гаргаж байгаасай гэж хэлэх байна. Ялангуяа сүүлийн үеийн эдийн засгийн бодлогын судалгаанууд харахад даацтай бүтээлүүд байх болжээ. Учир нь судалгаа хийж байгаа эрдэмтдийн дотор гадаад, дотоодын их, дээд сургуульд PhD зэрэг хамгаалсан, дэлхийн томоохон их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж үзсэн туршлагатай шинэ үеийн судлаачид бий. Манай төрийн албанд чадваргүй дарга, цэрэг олширч байгаа нь хэн бүхэнд илт. Эдийн засгийн хөгжлийн яам, Хөгжлийн банк гээд Монголын шинэ хөгжлийг тодорхойлоход оролцох төрийн байгууллагууд нийгмийн шаардлагаар шинээр бий болж байгаа. Тэдэнд чухам ямар хүмүүс ажиллаж байгаа нь одоогоор тийм ч тодорхой бус байна. Мэдээж ажлын туршлага, мэдлэг арвинтай хүмүүс бий л байх. Гэхдээ хуруу дарам цөөн байгаа болов уу.

Гэтэл барууны их, дээд сургуульд суралцаж, эрдмийн зэрэг, цол хамгаалсан мундаг залуус 2010 оноос эх орондоо буцаж ирэх болсон. Их мөрөн дөлгөөн гэгчээр тэдний ихэнх нь их, дээд суургуульд багшилж, даруухан амьдарч байна. Ийм хүмүүс өнөөдөр төрд шургалах гэж улайрах биш, мэргэжлийн түвшний бодлогын судалгаа, чанартай хэлэлцүүлгүүдийг бий болгож, төрийн урагшгүй үйл ажиллагааг чанаржуулах зорилго өвөртөлжээ. Мөн сайн эдийн засагч салбарынхаа шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах ёстой гэсэн үүднээс чансаатай бүтээлүүд хийж, тэр нь дэлхийн мэргэжлийн сэтгүүлүүдэд нийтлэгдэж, эрдэм боловсролынх нь зиндааг тодорхойлж байх жишээтэй. Бид ийм шинэ үеийн эдийн засагчдын тухай дараа дараагийн дугаартаа дэлгэрэнгүй бичих болно. Тэдний зарим нь сарын дунджаар 4000 ам.долларын цалинтай ажлаасаа эх орноо бодон татгалзаж ирчихээд, бидний дунд амьдарч байна.

Энэ удаа манай сэтгүүл судалгааг хаана хаанаа чухалчлах хэрэгтэй байгааг Монголын төрд уриалж байна.

АСУУДАЛ

ЯДУУРАЛ “ЦУС ДАМЖДАГ”

Э.ЗОРИГТ

...Уг нь төр, засаг ядуу иргэдээ хөдөлмөрлүүлж, хөрөнгөжүүлэх ёстой баймаар. Гэтэл өнөөдөр Монгол улс ядуу иргэдэд чиглэсэн халамжийн бодлого явуулна гэж яриад байдаг. Уг чанартаа ядуу иргэдэд халамжийн мөнгө олгох нь тэднийг сэтгэлгээний ядууралд түлхдэг аж...

Нэг хотын хоёр ертөнц

Сүхбаатарын талбайн эргэн тойронд тэнгэр баганадсан өндөр барилгууд сүндэрлэнэ. Сүхбаатар жанжны талбайн зүүн захад орших “Сэнтрал Тауэр”-т “Louis Vuitton”, “Emporio Armani”, “Burberry” зэрэг брэндийн дэлгүүр хэдийнэ төвхнөсөн. Тус барилгын 17 давхарт байрлах ресторанд хэзнцэр хувцас, хэрэглэлээр гангарсан бизнесмэнүүд амталж шарсан үхрийн махыг Roquefort бяслагаар хачирлан хооллох бөгөөд зарим нэг нь Францын алдарт Mouton Cadet Reserve Sauternes цагаан дарс шимэн сууна. Их хотын төв хэсэгт амьдрал энэ мэт өрнөж байхад нөгөө захад нохойн хоол гэх 650 төгрөгийн үнэтэй махны өвдөл цөвдөл, 350 төгрөгийн үнэтэй “жижиглэн” буюу малын дотор эрхтний цуглуулга, шулсан ясны шөлөөр өл зогоож, зарим нь бүр хоосон хонож байна. Одоогоос жилийн өмнө нийслэлийн Чингэлтэй дүүргийн XII хорооны 60 гаруй настай өрх толгойлсон эмэгтэй Л.Баянжаргал өөрийн долоон хүүхэд, хүргэн, бэр, ач зээ нийлсэн 17-уулаа, жижиг таван ханатай гэрт өдөр хоногийг дээрх мэт өлмөн зэлмүүн өнгөрүүлж байгаа тухай манай сэтгүүл бичиж байсан. Харин жилийн дараа тэдний амьдрал хэрхэн өөрчлөгдсөнийг эргэн сонирхлоо. Жижиг таван ханатай гэрт багталцаж ядах ам бүлийнх нь тоо хоёроор нэмэгджээ. Үсчин хийдэг байсан охин нь ажлаасаа халагдсан гэнэ. Тогтсон орлого, тухтай амьдралгүй тэд улам л ядуурсаар байгаа талаар Баянжаргал ярьсан юм.

Гүнзгий ядуурлын гүн дэх нууц

Манай улсын эдийн засгийн өсөлт дэлхий нийтийг алмайруулж, улстөрчид энэ өсөлтийн талаар ам хуурайгүй ярьж байна. Гэтэл Монголын ядуурал улам гүнзгийрсээр байгааг дараах судалгаа харуулж байна. Ядуурлын талаар судалдаг цөөхөн эдийн засагчийн нэг МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор С.Даваасүрэн “Хамгийн сүүлийн судалгаагаар манай улсын ядуурлын гүнзгийрэл 29 хувьтай байна. Энэ нь нийт ядуу иргэдийг 100 хувь гэж үзвэл түүний 30 орчим хувь нь нэн ядуу гэсэн үг. Эдгээр иргэний орлого ядуу иргэдийн сарын орлогоос дунджаар 25.6 мянган төгрөгөөр доогуур байдаг” гэсэн юм. Тун хүнд сонсогдож байгаа биз. Өөрөөр хэлбэл, Монголын ядуу гэж нэрлэгддэг хэсгийн 30 орчим хувь нь ядуугийн ядуу буюу тартагтаа тулсан амьдралаар амьдарч байна гэсэн үг. Манай үе үеийн шийдвэр гаргагч, бодлого тодорхойлогчид ядуурлыг бууруулна гэдэг ч тэр нь лоозон төдий байдаг. Өөрөөр хэлбэл, ядуурлыг яаж бууруулах талаар бодитой бодлогогүй явж ирсэн хэрэг. Дотоод, гадаадын мэргэжлийн хүмүүсийн яриагаар боловсрол, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт хийх нь хөгжилд тустай төдийгүй ядуурлыг бууруулах хамгийн зөв арга гэх. Гаднын өндөр хөгжилтэй орнууд ч ядуурлыг бууруулахын тулд дээрх хоёр салбарт оруулах хөрөнгөдөө гар татдаггүй аж. Ядуу буюу амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн эрүүл мэнд дундаж амьдралтай хүнийхээс хоёр дахин муу гэх судалгаа бий. Тиймээс ядуу иргэдийн хүүхдийн ихэнх нь эрүүл мэндийн шалтгааны улмаас сургуулиас завсарддаг байна. Ингээд эрүүл мэнд дорой, боловсролын хоцрогдолтой хүүхдүүдийн ирээдүй ямар байх нь ойлгомжтой. Энэ байдал нь нэг талаар ядуурал удам дамжих нөхцөл болдог байна. УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ “Ядуурал удамшихаас айх юм. Өнөөдөр ядуу байгаа хүмүүс хойшид ч ядуу явах тийм л нийгэмтэй болчихож Монгол улс” гэж халаглаж байсан удаатай. Товчхондоо олон улсад ч эрүүл мэнд болон боловсролд оруулж байгаа анхны хөрөнгө оруулалт ирээдүйн өндөр орлогыг бий болгоно гэж үздэг байна. Тиймээс улс төрийн бодлого

нь ч энэ зүгт чиглэдэг аж. Норвеги улс гэхэд л ядуурлыг бууруулахын тулд ард иргэдийнхээ эрүүл мэндэд ихээхэн анхаардаг. Тухайлбал, тус улсад бие болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ бүх насныханд үнэ төлбөргүй байх жишээтэй. Шүдний эмнэлгийн үйлчилгээ гэхэд 16 хүртэлх насныханд үнэ төлбөргүй бөгөөд эм, эмийн бүтээгдэхүүнийг нэг жилд гурван сараас дээш хугацаанд хэрэглэх үед хөнгөлөлттэй үнээр олгодог аж. Түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээний зардал ДНБ-ий есөн хувийг эзэлдэг бөгөөд Засгийн газраас 84 хувийг нэмж санхүүжүүлдэг байна. Тиймээс ч тухайн улсын ядуурлын түвшин ердөө гуравхан хувь байдаг аж. Эндээс харахад, ядуурлыг бууруулахад эрүүл мэндийн салбар ямар чухал нөлөөтэй нь тодорхой байна. Хэрвээ эрүүл мэнд, боловсролын асуудлыг үл анхаарч, цаг тухайд нь шийдэж чадахгүй бол ядуу иргэдийн ажиллах чадамж буурсаар нэн ядуугийн ангал руу гулсдаг аж. Ядуурал уламжлагдах буюу “цус дамждаг” гэдгийг учир мэдэх хүмүүс хэлж байсан юм. Даваасүрэн “Ядуу айлын жишээн дээр харахад, циклийн нөлөө их байдаг. Энэ нь тухайн өрхөд бий болсон нэг хүндрэлтэй асуудал өөр нэгэн бэрхшээлийг араасаа дагуулдаг гэсэн үг юм. Тухайлбал, тухайн өрхийн орлогын эх үүсвэр болсон хэн нэгэн нь хүнд өвчин тусах. Цаашлаад амь насаа алдах хүртэл эрсдэл учирч болно. Ингэснээр өрх улам л ядуу болдог. Үүнийг “ядуурлын гүнзгийрэл” гэж нэрлэдэг” гэв.



Фотог Б.Уганбаяр

Хот, хөдөөгийн ялгаа

Хот, хөдөөд болон алслагдсан бүсэд ялгавартай бодлого явуулах хэрэгтэй. Тэгж чадвал энэ нь ядуурлыг бууруулах томоохон хүчин зүйл болох талаар Даваасүрэн багшийн судалгаанд тусчээ. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар орон нутгийн хоёр иргэний нэг нь ядуу амьдралтай байсан бол хотод гурван хүн тутмын нэг нь ядуу байсан аж. Түүнчлэн газар нутгийн хувьд төв суурин газраас алслагдмал байх тусмаа орлогын тэгш хуваарилалт алдагддаг байна. Ядууралд хүний амьдрах орчны нөхцөл онцгой нөлөөлдөг гэнэ. Тухайлбал, алслагдмал газрын иргэдэд ажил амьдралын сонголт байдаггүй гэж хэлж болно. Ажиллах болоод амьдрах орчны сонголт багасах тусам шилжилт хөдөлгөөн ихэсдэг байна.

Хувь хүний хичээл зүтгэл хамгийн хүчтэй

Төр, засаг ядуу иргэдээ хөдөлмөрлүүлж, хөрөнгөжүүлэх хэрэгтэй. Гэтэл манайд эсэргээрээ байх шиг. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар хүн амын 47 хувийг 15-40 насныхан эзэлдэг байна. Гэтэл эдгээр эдийн засгийн идэвхтэй, хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоо өдөр ирэх тусам багасаж, ажиллах идэвхгүй хүн амын тоо жилээс жилд өсөж байгаа талаар дурджээ. Даваасүрэн “Нийгмийн халамжийн мөнгө тарааж эхэлснээс хойш хүмүүсийн ажиллах сонирхол буурсан гэдгийг графикаас харж болно. Төрөөс тараасан бэлэн мөнгө тухайн өрхийн орлогын ихэнх хувийг эзлэх буюу хүмүүс зүгээр сууж байгаад мөнгөтэй болоод ирэхээр хөдөлмөрлөх сонирхолгүй болдгийн тод илрэл” гэв. “FSCO Mongolia” компанийн захирал Д.Жаргалсайхан “Өнөөдөр манайд өөрсдийгөө эмзэг гэзэг нэрлэчихсэн хэсэг байна. Тэр эмзэг хэсэг нь амаа ангайгаад хэвтчихдэг. Бусад нь эвий, хөөрхий гээд л аманд нь хоол хийж өгөөд л. Сүүлдээ улам давраад одоо бүр хоолоо зажлуулж амандаа хийлгэх янзтай. Үүнийг нь улстөрчид ашиглаж, бэлэн мөнгө тараагаад л” гэж нэгэн ярилцлагадаа дурджээ. Өдгөө Скандиновын хойгийн орнууд халамжийн бодлогыг амжилттай явуулж байна. Гэхдээ тэдний нууц нь ядуу иргэд гэхээсээ илүү нийгмийн дундаж давхаргад хөрөнгийн хуримтлал үүсгэх үүднээс бэлэн мөнгө тараадаг байна. Үүнээс гадна ядуу иргэдээ ажилтай болгохыг чухалчилдаг. Манай урд хөрш ч энэ мэт бодлого явуулдаг. Хятадад тухайн хүн улсдаа ямар нэг байдлаар хөдөлмөрлөж л байвал улс таны хүүхдийн живхний мөнгөнөөс эхлээд сурах хүртэлх бүх зардлыг даана.

Цалинг чинь хангалттай өгнө. Харин ажил хийх үгүй нь таны дур. Хийхгүй бол өлсөнө. Иймл учраас манай урд хөршид ядуурал бага байдаг гэх. Олон улсын хэмжээнд ядуурлын түвшинг тогтоохдоо хоногт 1.25 ам.долларааc бага орлоготой бол ядуу гэж үздэг байна. Дэлхийн нийт хүн амын 22 хувь нь энэ ангилалд шууд оржээ. Гэтэл Хятад улсыг энэ тооцооноос хасвал ядуурлын түвшин 25 хувь болтлоо өссөн байна. 1981 оны үед Хятад улсад өдөрт 1.25 ам.долларааc бага орлоготой иргэдийн тоо 662 сая байсан бол 2008 онд 173 сая болж буурсан байна. 2010 оны байдлаар Хятад улсын нийт хүн амын 13 хувь нь 1.25 ам.долларааc бага орлоготой бөгөөд уг үзүүлэлт жил бүр буурч байгаа гэсэн судалгаа гарчээ. Эндээс дэлхийн ядуурлыг бууруулахад тус улсын нөлөө ямар жин дарж байгааг харж болох юм. БНХАУ-ын цөөхөн жилд ядуурлыг “номхруулсаны” нууц нь бүх ард түмнээ хөдөлмөрлүүлж чаддагт оршдог гэх. Харин хөдөлмөрлөж байгаа иргэдээ тэд нийгмийн дундаж давхарга гэж нэрлэдэг байна. Улстөрчдийнх нь зорилго товчхондоо улс даяараа баян, хүчирхэг болох.

Монгол ч гэсэн ядуу хүмүүс ядуу гэх нэрээрээ хоол олж иддэг биш, нийгмийн дундаж давхаргад шилжихийг эрмэлзэж, амьдралынхаа чанарыг сайжруулж, нийтээрээ баян байхыг эрмэлзэх хэрэгтэй юм. Үүний төлөө зөвхөн Засгийн газар ч бус ард нийтээрээ зүтгэвэл амжилт ойрхон байна. ■

“ТӨСӨВ-2013”

ХУУЛЬ ТӨВТЭЙ ТӨСӨВ

Б.ТОГТОХ

...2013 оны төсвийн төслийн УИХ болон Байнгын хорооны хэлэлцүүлгээс ажиглахад “ол, тараа, үр” гэсэн зарчим дахиад л үйлчилж мэдэхээр байна. Уг нь ирэх оны төсвийг эрсдэлийн хавцлаас гаргах арга нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэж ярьж буй. Гэтэл улстөрчид уг хуулийг хэрэгжүүлэх тал дээр идэвх сул, итгэл үнэмшил багатай сууна...

Батлагдаад бүтэн хоёр жил хүлээсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хууль ирэх нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжинэ.Төрийн хууль учраас түүний өмнө хөндөлсөх төсөв гэж үгүй. Тиймээс ирэх оны улсын төсөв улсын данс улайсан, гадаад орчин нөхцөл таагүй байлаа гээд “захирах” хуулийнхаа хүрээнд л “аж төрөх” ёстой. Угтаа бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн данхайсан байдалд хязгаарын эцсийн цэгийг тогтоосон учраас ирэх оны төсвийг ухаантай батлах учиртай.

Дэлхийд төсвийн хариуцлага, ёс зүйтэй холбоотой хууль баталж, түүнийгээ мөрдөж буй 60 гаруй улс бий аж. Түүний нэг нь Монгол. Эдгээр улсын ихэнх нь эдийн засгийн дэд бүтэц султай, хөгжиж буй эдийн засагтай гэдгээрээ манайхтай төстэй. Тиймээс ашигт малтмалын олборлолтоосоо эдийн засаг нь хараат, үүнээс шалтгаалан төсвийн тогтвортой байдал, төрийн засаглал нь хэлбэлзэх хандлага түлхүү байдаг аж. Мөн эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжил /OECD/-ийн орнууд болох Англи, Австрали, Шинэ Зеланд манайхтай ижил хуулийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, уул уурхайн орон болох Австрали Төсвийн шударга байдлын тухай хуулийг батлан, төсвөө журамтай болгожээ. Мөн эдийн засаг нь хавцлын ирмэгт буй Европын холбооны улсууд ч Маастрихтийн гэрээ /Maastricht treaty/-ний хүрээнд бодлого тодорхойлогчид нь төсөвтөө болгоомжтой, хариуцлагатай хандахад чиглэсэн хууль эрх зүйн орчинг мөрдөж байна. Гэхдээ хариуцлагагүй төсөв хямралд хөтөлдөг болохыг Европын холбооны гишүүн орнуудаас харж болохоор байна. Өөрөөр хэлбэл, тэд төсвийн хариуцлагын тухай хууль зөрчсөн гэсэн үг. Тиймээс шийтгэл нь эдийн засгийн хямрал, доройтол.

Эрдэс, баялгаас хамааралтай эдийн засагтай Африк, Латин америкийн орнууд 1980-аад оны сүүлчээс, бага орлоготой болон шилжилтийн эдийн засагтай Зүүн европын орнууд ерээд оны сүүлч, шинэ мянганы эхэн үеэс Төсвийн хариуцлагын тухай хуулийг хэрэгжүүлэх болжээ. Ийм хуулийг зөвхөн эрдэс, баялгаас хараат эдийн засагтай, бага орлоготой ▸▸



Фотог Б.Бямба-Очир

орнуудаас гадна дундаж болон өндөр орлоготой баян орнууд ч хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, ашигт малтмалын олборлолт ихтэй, орлого багатай орнууд гэвэл Гана, Зүүн Тимор, Габон Нигер, Чад, Конго, Алжир, Индонезийг нэрлэж болно. Дундаж орлоготой орноос Чили, Намиби, ӨАБНУ Тринадо/Тобаго, Малайз, Азербайжан, Казахстан Чех, Ботсван, Бразил, Колумб, Венесуэль багтана. Мөн өндөр орлоготой орон болох Кувейт, Саудын Араб Төсвийн шударга байдлын тухай хуулийг мөрдөж байна. Эдгээр орон нь төсвийн алдагдал, өрийн дээд хязгаар, зарлагын зохистой байдлыг баримталж байгаа нь энэ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. Тус хуулийг улсын төсвийн тогтвортой байдлын удирдлага, зохистой хязгаарлалтуудыг баримтлах, хэрэгжүүлэх, хяналт тавих харилцааг зохицуулах, төсвийн тогтвортой байдлыг хангах зориулалт бүхий хуримтлал бий болгох зорилгоор баталсан. Үүндээ УИХ хүрч ажиллах цаг ирээд байна. Улстөрчид өөрсдийн баталсан хуульдаа хэр үнэнч ханддаг болохыг “Төсөв-2013” илэрхийлнэ гэсэн үг. Өнөөдөр Монгол улс төсөв зохиох, батлах, санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хангах асуудлыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар хэрэгжүүлж байна. Төсвийн орлого, зарлагын ангилал, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, төсвийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой харилцааг Нэгдсэн төсвийн тухай хуулиар зохицуулж ирсэн. Тэгвэл ирэх оноос хэрэгжих Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үр дүнд Монгол улс анх удаа хариуцлагатай, хэм хэмжээтэй, төсвийн төслийг батална гэсэн найдлага, хүлээлт бий. Товчхондоо, өнгөрсөн хугацаанд төсөвт гаргасан алдаагаа төр ухаарч, түүнийгээ баллуурдахаар тус хуулийг баталсан гэж хэлж болно.

2009 он. Төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол улсын Засгийн газраас мөн онд гаргасан Тогтворжуулалтын хөтөлбөрийн хүрээнд төсвийн удирдлагын хууль эрх зүйн шинэчлэл хийх, үүний дотор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, батлахаар шийдвэрлэсэн байдаг. Тиймээс 2010 оны төсвийг УИХ-аар батлахдаа төсвийн орлогыг тэнцвэржүүлэн тооцох горимд шилжүүлэх тухай УИХ-ын 85 дугаар тогтоолыг баталж, төсвийн тогтворжилтийг хангахад чиглэсэн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

2010 он. “Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг батлан мөрдүүлснээр төсвийн бодлого стратегийг тодорхойлоход төсвийн удирдлагын зарчим ба төсвийн тусгай шаардлагыг тогтоож, дунд, урт хугацааны төсвийн тогтвортой байдлыг хангахад хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагын үүрэг хариуцлага өндөрсөж, төсвийн тусгай шаардлагад суурилсан төсвийн удирдлагын эрх зүйн шинэ орчин бүрдэх юм” гэж Сангийн сайд асан С.Баярцогт УИХ-ын чуулганы танхимд хэлж байв.

2010.06.24. Монгол улсын Парламент эл өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж, 2013 оныг хүлээхээр шийдэв. Хуулийн зорилт нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс, баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө

оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино хэмээн тус хуулийн нэгдүгээр зүйлд онцолжээ.

2011 он. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тунхаг болсон дараах дөрвөн тулгуур заалт бий. Төсөв үүнээс хазайж болохгүй. Өөрөөр хэлбэл, тус дөрвөн тусгай шаардлагыг 100 хувь хангасан тохиолдолд Монгол улсын 2013 оны төсвийг батлахдаа төр холбогдох хуулиа мөрдөж, хэрэгжүүлсэн гэж ойлгож болох юм. Тусгай шаардлагыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөв, төсвийн тодотгол, төсвийн гүйцэтгэл биелүүлэх учиртай.

Хуулийн 6.1.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

6.1.2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;

6.1.3. Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс, баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх;

6.1.4. Уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамаарууллахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байх.

Монгол улсын ирэх оны төсөв өмнөх жилүүдийнхээс онцгойрч харагдаад байх онцлог зүйл бараг л үгүй. Харин ганцхан зүйлээрээ ялгаатай. Тэр нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх. Тус хуулийн тусгай шаардлагыг мөрдсөн төсөвтэй болох. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хэр дагаж мөрдөх нь УИХ болоод Монгол улсын хууль, дүрмийн утга учрыг тодотгож өгөх юм. Ирэх оны Төсвийн төслийн талаар Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Б.Түвшинтөгсөөс сонирхоход “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хэрэгжсэнээр Засгийн газрын зардлаас хамаарсан инфляцийн дарамт саарах болов уу гэсэн хүлээлт байгаа. Төсвийн төслийн танилцуулгаас харахад орлого талдаа нүүрсний экспортын дүн нэлээд өндөр тавигдсан байна лээ. Ерөнхийдөө эрдэс, баялгаас хэт хамааралтай байдал хэвээр байгаа үед ашигт малтмалын бүтээгдэхүүний үнэ огцом буурахад төсөв нэлээд хүндрэлтэй болох төлөвтэй байна” гэлээ. Харин Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг ирэх оны төсвийн төсөл 100 хувь хангасан гэж Сангийн сайд Ч.Улаан мэдэгдсэн. Тэрбээр Төсвийн төсөл анх УИХ-д өргөн барих үеэр ч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох зүйл заалтад нийцүүлэн боловсруулсан тухайгаа онцлон тэмдэглэж байсан.

Донорууд итгэл муу байна

Хууль төвтэй ирэх оны төсвийн төслийн хэлэлцүүлгийг донор байгууллагынхан ч анхааралтай ажиглаж сууна. Асуудал хариуцсан албаны хүмүүсийн хэлж байгаачлан шинэ төсөв Тогтвортой байдлын тухай хуульд нийцэж байгаа мэт боловч Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг донор байгууллагын эдийн засагчдын таамаг, дүгнэлт улстөрчдийнхөөс өөр байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, Дэлхийн банкны эдийн засагч Ш.Алтанцэцэг төсвийн хэлэлцүүлгийн үеийн шийдвэр гаргалтын нөлөөллийн улмаас зарим үр дүнгийн үзүүлэлт зохистой түвшингээс муудах магадлал өндөр байна. Өөрөөр хэлбэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль зорилгоосоо ухрах эрсдэл байгааг тэмдэглэлээ. Тэрбээр “Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлье гэж байгаа бол Хөгжлийн банкаар санхүүжүүлж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг төсөвт оруулж тооцох хэрэгтэй. Хөгжлийн банк бол төсвийн тусгай сан биш” хэмээв. Мөн Хөгжлийн банкны хувьд улсын төсвөөс гадуур их хэмжээний санхүүжилт хийж, дараа төлөх нөхцөлтэй барих, шилжүүлэх төслүүд хэрэгжүүлж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зорилтоос хазайж, мөн чанарыг алдагдуулах эрсдэл дагуулж байгааг Дэлхийн банкнаас анхааруулсан. Иймт өрлийн төсвийн гадуурх хөрөнгө оруулалтын зардал энэ онд ДНБ-ий 4-5 хувьтай тэнцэх тооцоо байгаа нь нэгдсэн төсвийн алдагдлыг есөн хувьд хүргэж өсгөхөөр байгаа юм. Түүнчлэн Азийн хөгжлийн банкны ахлах эдийн засагч Яан Ханзэн “Урт хугацаанд “Голланд өвчин”, баялгийн хараалаас зайлсхийх, эдийн засгийг олон суурьт болгох, өсөлтийг нийтэд хүртээмжтэй, ядуурлыг бууруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тууштай хэрэгжилт чухал” гэв. Тэрбээр урсгал зардлыг бууруулж, төсвөөс хийх хөрөнгө оруулалтыг ажлын байр олноор бий болгох, үр шимийг нь нийтээрээ, урт хугацаанд хүртэх салбар болох дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролд чиглүүлэх шаардлагатай байгааг ч хэлсэн.

Монгол улсын ирэх оны төсөв хавцлын ирмэгт байна. Түүнийг аврах, эс аврах эрх нь УИХ-д бий. Харамсалтай нь төсвийн төслийг хэлэлцэх явцад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх, түүнийг мөрдөх хүсэл сонирхол УИХ-ын гишүүд болон шинэчлэлийн Засгийн газарт бага байх шиг. 2013 оны төсвийн төслийн УИХ-ын болон Байнгын хорооны хэлэлцүүлгээс ажиглахад, зөвхөн “ол, тараа, үр” гэсэн зарчим дахиад л үйлчилж мэдэхээр байна. Уг нь төсвийг эрсдэлийн хавцлаас гаргах арга нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэж ярьж буй. Гэтэл улстөрчид өөрсдийн баталсан хуулиа хэрэгжүүлэх тал дээр нэг л идэвхгүй, итгэл үнэмшил багатай сууна. Хамгийн ойрын жишээ гэхэд л Засгийн газрын таван тэрбум төгрөгийн бондоос харж болно. Мөн УИХ-ын удаа дараагийн төсвийн төслийн тухай хайнгадуухан хэлэлцүүлгээс ч хүмүүс хариуцлагатай асуудалд хариуцлагагүй хандаж буйг харж болохоор ■

СУДАЛГАА

ЭРСДЭЛД ЭЭРҮҮЛСЭН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Б.УУГАНБАЯР

Манайд хадгаламжийн хүү өндөр учраас зээлийн хүү дагаж өссөөр байгаа аж. Дэлхийн банкнаас гаргасан судалгаагаар Монгол хадгаламжийн хүү өндөртэй улсуудаас зургадугаарт эрэмблэгджээ...

Дэлхийн эдийн засаг таагүй байгаа энэ үед ирээдүйд учирч болох санхүү, эдийн засгийн эрсдэлээ тооцож, аливаад учиртай хандах цаг ирснийг эдийн засагчид онцолж байна. Тэгвэл МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, дэд профессор Б.Эрдэнэбат “Макро эдийн засгийн эрсдэлүүд түүнээс зайлсхийх арга замууд” гэсэн судалгаа хийжээ. Манай улсад ойрын хугацаанд тулгарч болох асуудлууд макро эдийн засгийн эрсдэлд институцийн доройтол, хэвийн ажилгүйдлийн түвшин нэмэгдэх хандлага, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, санхүүгийн эрсдэл байгааг тэрбээр онцолжээ.

Анхаарал татсан эдгээр асуудлыг манай сэтгүүл цувралаар бичих тул энэ удаа санхүүгийн зах зээлийн эрсдэлийн талаар хөндье. Хөгжлийн шинэ гараан дээр зогсоо Монголын санхүүгийн зах зээлд гурван асуудал өдгөө санаа зовоох хэмжээнд хүрээд буйг дээрх судалгаа илтгэнэ. Энэ нь зээлийн хэт тэлэлт, инфляци болон бодит ханшийн чангарал, Монгол улсын өр юм.

Үр дүнгүй зээлийн тэлэлт

Манай улсад сүүлийн хоёр жилийн хугацаанд зээлийн хэмжээ хоёр дахин өсчээ. Судалгаанаас харахад ажлын байрыг олноор бий болгож, нэмүү өртөг шингээх учиртай аж үйлдвэрийн салбарт бараг зээл олгогдоогүй гэж болохоор байна. Харин хэрэглээний буюу цалин тэтгэврийн, үл хөдлөх хөрөнгийн, ашиг өндөр олдог жижиглэн, бөөний худалдаа, барилгын салбарт зээлийн ихэнх хувь ногдож байна. Өндөр хөгжилтэй орнуудад аж үйлдвэрийн салбараа хамгийн түрүүнд дэмжиж, жилийн 3-6 хувийн хүүтэй зээл өгдөг байхад манайд бизнесийн зээлийн хүү жилийн бараг 20 хувьд хүрч байна. Ийм байхад эдийн засгаа төрөлжүүлж, хөгжүүлэх талаар ярихад тун хүндрэлтэй хэмээн Эрдэнэбат тэмдэглэжээ. Ийнхүү зээлийн хүү өндөр, хүртээмж бага байгаа нь томоохон эрсдэл дагуулж байна гэсэн үг. Дэлхийн банкны судалгаагаар ихэнх улсад банкны зээлийн хүү дунджаар 12 орчим хувьтай байгаа бол манайд өнгөрсөн оны зээлийн жигнэсэн дундаж хүү 16.6, өнгөрсөн зургадугаар сард 17.9 хувь байжээ.

Барьцаалуулсан хадгаламжийн салбар

Монголын санхүүгийн салбар зээлийн хүү болон хадгаламжийн хүүгийн хэмжээгээрээ ч дэлхийд дээгүүр жагсаж байна. Дэлхийн банкны судалгаагаар Монгол хадгаламжийн хүү өндөртэй орны зургадугаарт эрэмбэлэгджээ. Ангол, Конго, Йемень гэсэн Африкийн гурван улс болон Венесуэль, Турк улсын дараа орсон байна. Хадгаламжийн хүү өндөр байх нь зээлийн хүүгийн өсөлтөд нөлөөлдөг. Дэлхийн ихэнх улсад хадгаламжийн хүү дунджаар дөрөв орчим хувьтай байдаг бол манайд өнгөрсөн оны байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 10.5, өнгөрсөн есдүгээр сард 11.5 хувь байв. Энэ өсөлт ямар нэг арга хэмжээ даруй авах шаардлагатайг харуулж байна. Тухайлбал, хадгаламжийн хүү өндөр улсууд хүүгийн орлогоос татвар авдаг жишигтэй байдаг. Уг нь 1996 оны манай Хүн амын орлогын албан татвар/ХАОАТ/-ын тухай хуульд хадгаламжийн хүүгийн орлогоос татвар авах тухай заалт оруулсан ч хэрэгжилгүй өнөөдрийг хүрчээ. Үүнийг УИХ-д баян хүн олон орчихоороо өөрийн хөрөнгөөсөө татвар авч зориглодоггүй тул хууль өнөө болтол цаасан дээр хэрэгжиж байгаа юм гэх хүн ч байна. Харин шинэчлэлийн Засгийн газар ХАОАТ- »

ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хадгаламжийн хүүгээс татвар авахаар ярилцаж буй. Гэхдээ хуулийн төсөлд заахдаа “Нэг банкинд 100 саяас дээш төгрөг хугацаагүй байршуулсан иргэнээс татвар авна” гэжээ. Энэ заалт нь хүүгийн орлогоос татвар авах биш эсрэгээрээ хөрөнгөтэй хүмүүст банкуудад мөнгөө тараан байршуулж, татвараас зугатах боломж болж буй юм. Түүнчлэн монголчуудын дунд 100 сая төгрөг хугацаагүй байршуулах иргэн хэд байх бол. Тиймээс энэ хуулийг батлахаас нь өмнө сайн хэлэлцэж, зөв шийдвэр гаргах нь зүй юм.

Эдийн засгийн хөгжлийн яамны дэд сайд О.Чулуунбат манай хадгаламж эзэмшигчдийн хоёр хувь нь нийт хадгаламжийн 90 хувийг эзэмшдэг тухай хэлж байсан. Харин Монголбанкны ажилтан нийт хадгаламж эзэмшигчийн таван хувь нь хугацаатай хадгаламжийн 95 хувийг эзэмшдэг гэжээ. Тэгэхээр манай банкны салбар хадгаламжийн 95 хувийг эзэмшиж буй цөөхөн хүний гарт барьцаалагдчихаад буйг судлаач Эрдэнэбат онцолсон. Энэ нь хэрэв ямар нэг татвар авч, дарамт үзүүлж эхэлбэл хүмүүс хөрөнгөө татна гэж айлгах магадлалтай гэсэн үг. Хадгаламжийн хүүгийн орлогоос татвар авахгүй болохоор хүмүүс бизнест хөрөнгө оруулалт хийхээсээ илүү мөнгөө банкинд өндөр хүүтэй хадгалуулж, ашиг хүртэхийг бодно. Тэгэхээр санхүүгийн бусад салбарынхаа хөгжлийг боомилж буй юм.



Шог зургийг А.Амарсайхан

Инфляцийг хазаарлавал зээлийн хүү буурна

Банкны салбарын өөр нэг томоохон эрсдэл нь банкууд эх үүсвэрээ валютаар татаж аваад, зээл олгохдоо мөнгөөр олгож буй явдал юм. Хэрэв дэлхийн зах зээл дээр ам.долларын ханш чангарвал, төгрөгийн ханш суларч, банкууд эрсдэлд орно. Манай нийт хадгаламжийн гуравны нэгийг ам.долларын харилцах хадгаламж эзэлдэг бөгөөд энэ мөнгө богино хугацаанд орж ирээд, гардаг. Энэ байдал нь ам.долларын эрэлтийг богино хугацаанд нэмэгдүүлж, төгрөгийн ханшийг унагах томоохон эрсдэл дагуулж буйг Эрдэнэбатын судалгаанд тэмдэглэжээ. Гэхдээ манай улсын зээлийн тэлэлт дэлхийн зах зээл дээр зээлийн түвшин харьцангуй бага, эерэг үзүүлэлттэй үед таарч буйгаараа онцлог аж. Учир нь Европ, Америк эдийн засгаа дэмжихээр зээлийн хүүгээ хүчээр доогуур барьж буй. Мөн газрын тосны бүтээгдэхүүний үнэ огцом өсөж буйтай холбоотойгоор Арабын орнууд их хэмжээний хадгаламж үүсгэж, зээлийн хүүг барьж байгаа юм. Түүнчлэн дэлхийн II дайны дараа олноороо төрсөн иргэд их хэмжээний хадгаламжийн нөөцийг үүсгэсэн гэж үздэг. Гэтэл одоо энэ хүмүүс тэтгэврийн насанд хүрч, хадгаламжаасаа хэрэглээд эхэлсэн. Тэднийг хуримтлалаасаа хэрэглэж эхлэхээр дэлхийн зах зээл дээр хадгаламжийн хэмжээ буурч эхлэхийг эдийн засагчид онцолж байна. Энэ нь хадгаламжийн зээлийн хүү цаашдаа доогуур байхгүйг баталж байна. Тэгэхээр цаашдаа манай улс гаднаас өндөр үнээр хөрөнгө босгоно гэсэн үг. Одооноос эрсдэлээ тооцож, зөв бодлого явуулах шаардлагатайг эдийн засагчид анхааруулж байна. Түүнчлэн манайх хадгаламжийн болон зээлийн хүүгээ бууруулахын тулд инфляцийг онилох нь боломжит хувилбар аж. Харамсалтай нь

Монголбанк инфляцийг онилсон хэрнээ онож чаддаггүй нь багагүй шүүмжлэлд өртдөг. Өндөр хөгжилтэй орнуудад Төвбанкны инфляцийг хазаарлах бодлогыг хариуцлагын системтэй уясан байдаг юм байна. Тухайлбал, Англид Төвбанк нь инфляцийг барих амлалтдаа хүрч чадаагүй бол шалтгаанаа тайлбарлаж, иргэддээ уучлалт гуйсан захидал бичдэг ажээ. Мөн удаа дараа инфляцийг гааруулбал удирдах албан тушаалтан нь ажлаа хүлээлгэн өгдөг байна. Гэтэл манайд ийм хариуцлагын тогтолцоо байхгүй. Инфляци гаарч иргэдийн амьдралд дарамт учруулсаар.

Инфляци болон бодит ханшийн чангарал

Төгрөгийн ханшийг нэрлэсэн болон бодит гэж хоёр ангилдаг. Хүмүүсийн анхааралд нэрлэсэн ханш хамгийн их өртдөг бол бодит ханшийг тэр бүр хайхардаггүй. Гэхдээ бодит ханшаа аль болох доогуур байлгавал улсын өрсөлдөх чадвар нэмэгддэг сайн талтай. Жишээлбэл, манайд бараа, бүтээгдэхүүний үнэ Хятадтай харьцуулахад өндөр байвал бодит ханш их, инфляци өндөр байна л гэсэн үг. Манай өнөөдрийн инфляцийг 2000 оныхтой харьцуулахад өндөр байгаа тул бодит ханш 50 хувиар чангарсан гэсэн тооцоог Монголбанкнаас гаргажээ. Тэгэхээр энэ нь Монголд ирэх жуулчдын тоог бууруулах цаашлаад гадаад худалдаа саармагжихад хүргэж буй юм. Уг нь дэлхий нийтэд бодит ханшийн чангаралт нь нэрлэсэн ханшийн чангаралтаас үүдэлтэй байдаг бол манайд эсрэгээрээ буюу нэрлэсэн ханшаас бус инфляциас үүдэлтэй байгааг Эрдэнэбат судалгаандаа дурджээ. Энэ нь төгрөгийн ханшаа уян хатан бодлогоор зохицуулалгүй хүчээр барьж ирсэний гай хэмээн тэрбээр онцолсон.

Түүхий эдийн валюттай улс

Канад, Чили, Орос, Өмнөд Африк, Австрали, Монгол зэрэг улс дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнээс валют нь шууд хамааралтай учир “түүхий эдийн валюттай улс” хэмээн нэрлэдэг байна. 2008 оны сүүлчийн хагаст валютын ханш огцом өсөхөд Монголбанкнаас интервенц хийж, хоёр сар гаруйн хугацаанд ханшийг хүчээр барьсан удаатай. Өнөөдөр ч тус банкнаас уг арга хэмжээг авсаар буй.Төвбанк ийнхүү гадаад валютын нөөцөөсөө ам.доллар зарж, “ногоон”-ы ханшийг бууруулж болох ч таван жилийн өмнө дээрх арга хэмжээг авснаараа валютын нөөцийнхөө талыг тавиад тусныгаа умартах ёсгүйг Эрдэнэбат судлаач сануулж байсныг энд онцлон тэмдэглэе. Харин хямралын дараа манай улс дундарсан валютын нөөцөө нэмэгдүүлэхээр ам.доллар худалдан авч, мөнгөний нийлүүлэлтээ өсгөсөн. 2007 онд мөнгөний нийлүүлэлтээ 56, 2010 онд 62.5 хувь хүртэл өсгөж, дэлхийд нэгдүгээрт жагсаж байсан гэвч бусдын хөх инээд хүргэх зүйл Монголын санхүүгийн зах зээл дээр бий. Мөн өнгөрсөн онд Европын өрийн хямрал ид яригдах үед манайх валютын ханшаа царцааж байх жишээтэй. Гэтэл бидний хоч нэгт Канад, Чили, Орос зэрэг улсын эдийн засгийн ямар ч үед ганхалгүй сууж чадаж байна. Иймээс Монголбанкны зүгээс төгрөгийн ханшаа хүчээр барьдаг дэлхийн нийтээс гажсан тогтолцоог халж, уян хатан бодлого явуулах хэрэгтэйг судлаачид сануулсан.

Өр дүүжлэх вий

Ерээд оноос хойш Монгол улсын гадаад өр асар өсөж буйг олон хүн шүүмжилдэг. Тэгвэл Б.Эрдэнэбат аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын зээл өрийг жолоодож, өсгөөд байна хэмээн үзэж байна. Учир нь Оюутолгой, Тавантолгой зэрэг томоохон төсөл хэрэгжиж эхэлсэн, мөн хувийн секторын өрийг 2010 оноос бүртгэдэг болсонтой холбоотой аж. Эдгээр төслийн зээл манайд хөрөнгө оруулалтын зээл гэсэн нэрээр явдаг нь ихээхэн учир дутагдалтай гэнэ. Үүний оронд тухайн төслүүдийн нэр дээр Монголд компани байгуулаад, хөрөнгө оруулалтыг компанийн хөрөнгө гэж бүртгэж явах нь улсад өлзийтэйг судалгаанд дурджээ. Муугаар бодоход улс төрийн болон эдийн засгийн таагүй байдлаас үүдэн дампуурлаа гэхэд хамгийн түрүүнд зээлийг төлж, үлдсэнийг нь эзэмшигчиддээ тараан өгнө гэсэн үг. Тэгэхээр манай улс хамгаа тавиад туучих аюултайг Эрдэнэбат онцолсон юм.

Өөр нэг эрсдэл нь Засгийн газрын өр. Дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ боломжийн, дотоодод байгалийн баялгийн нөөц арвинтай учир Монголд хайр зарлаж, зээл өгөх хүсэлтэй сайхан сэтгэлтнүүд олширч буй. Харин манай улс үүнийг мөнхийн хайр гэж эндүүрч, өгснийх нь зоргоор аваад байвал түүхий эдийн нөөц дундарч, үнэ уруудах үед хамраараа газар хатгах эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл, түүхий эдийн үнэ унавал зээл өгсөн улсууд “хайраа” умартаж, хурдхан шиг л өрөө аваад салахын түүс болно гэсэн үг. Үүний тод жишээ бол Латин Америкийн өрийн хямрал. Дэлхийн хөрөнгө оруулагчид тус улсыг дээрх байдлаар хямраасан гэдэг. Үүнээс зайлсхийх нэг боломж нь Монгол улс гаднаас зээл авахдаа уул уурхайн түүхий эддээ тулгуурлан зээл авч болох талаарх санал Эрдэнэбатын судалгаанд бий. Ингэхдээ жишээ нь, бонд гаргалаа гэхэд зээлийн эсвэл нүүрсний үнээр индексжүүлсэн зээл авах хэрэгтэй. Одоо манайх дотоод, гадаадын бондын хүүг гурав болон таван ам.долларааар төлж байгаа. Тэгвэл үүнийгээ бодит бүтээгдэхүүнтэйгээ холбодог жишиг дэлхий нийтийн практикт байдаг аж. Тухайлбал, 1970 –аад оны сүүлчээр ОХУ Японоос зээл авахдаа нөхөн төлбөрөө улаан буудайгаар хийж байжээ.

Үүнтэй адил зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс үл хамаарч зээлийн хүүнд тонн зэс өгнө гэх мэтээр тохирч болох юм. Ингэснээр дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэл хамаарал багатай болж, эрсдэлээс зайлсхийх боломж бүрдэх юм. “Өрөнд баригдаж, өтөнд идэгдэх”-ээсээ өмнө энэ мэт эдийн засгаа дархлаажуулсан алхам хийх хэрэгтэйг Эрдэнэбат профессор судалжээ. ■

БОДЛОГЫН СУДАЛГАА

ХӨРӨНГИЙН УРСГАЛЫГ ДОТООДДОО АРГАМЖЪЯ

Б.БАЯРТОГТОХ

...Импортын арганд орохгүйн тулд дотоодын үйлдвэрлэлийг өөд нь татах шаардлагатай байгааг бодлогын судалгаа боловсруулсан Ц.Батсүх багш тайлбарласан юм...

Монголын эдийн засагт мөнгөөр бороо цутгасан ч ган арилж, газар дэлхий ногоорсонгүй. Урьдын л хөрөнгө мөнгөний хомсдолтой хэвээр. Эдийн засаг 17 хувиар өсөж дэлхийг алмайруулсан ч иргэдийн амьжиргааны түвшин төдийлөн сайжирсангүй. Ажилгүйдлийн түвшин ч буурсангүй. Ядуурлын түвшин ялимгүй буурсан тоон үзүүлэлт гарсан ч бодит амьдрал дээр Улаанбаатар хотод гурван хүний нэг нь ядуу хэвээр байна. Дундаж давхарга бэхжиж, иргэдийн нуруун дээрх ачаа багассангүй. Нэг үгээр хэлбэл, эдийн засаг өсөж, хөрөнгийн урсгал Монгол руу чиглэсэн ч бодит өсөлт нүдэнд харагдаж, гарт баригдсангүй. Аадар бороо ган тайлдаггүй гэдгийн адил эдийн засагт буй их мөнгөний урсгал олзуурхах зүйл биш, зовлон болж байна. Монгол улс олсон жаахан орлогоо үрсээр сууна. Үүний нэг жишээ нь гадаад худалдааны алдагдал юм. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Нэг орноос худалдан авах бараа, бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална. Түүхий эд, бэлтгэл, бөөний болон жижиглэн худалдаанд үнийн зохиомол хэлбэлзэл, монополь, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулна. Дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно” хэмээн Гадаад худалдааны бодлогыг заасан байдаг.

Манай улсын урсгал дансны алдагдал 3.1 тэрбум ам.долларт хүрээд байгааг Дэлхийн банкнаас өнгөрсөн сард гаргасан эдийн засгийн төлөв онцолжээ. Бараа болон үйлчилгээний алдагдал түүхэнд байгаагүй хэмжээнд хүрээд байгаа нь энэ. Уг нь эдийн засагт уул уурхайн салбар гаднын хөрөнгө оруулалтыг “юүлж” буй боловч урт хугацаандаа алдагдал тэлсээр. Хоног хугацаа өнгөрөх бүрийд алдагдал ихсэж, орлого хумигдсаар. Одоогийн байдлаар урсгал дансны алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нөхөж, балансаа тэнцвэржүүлж яваа аж. Энэ нь алдагдалгүй гэсэн үг биш юм. Экспортын орлого саарч буй өнөө үед импортын хэрэглээг хэт дэмжсэн тохиолдолд эдийн засаг тамираа барах эрсдэлтэйг СЭЗДС-ийн профессор Ц.Батсүх тайлбарлалаа. Тэрбээр “Хүлээгдэж буй их хэмжээний хөрөнгийн урсгал болоод хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уул уурхай, аж үйлдвэрийн томоохон төслүүдээс үүдэлтэй Монгол улсын “Голланд өвчин”-д нэрвэгдэх эрсдэлийн үнэлгээ” сэдэвт бодлогын судалгааг салбарынхандаа танилцуулсан юм. Тус судалгаанд үндэслэн эдийн засгийн өнөөгийн байдлыг өгүүлье. Мэдээж гадаад худалдааны алдагдал 100 хувь алга болохгүй. Гэхдээ зохистой хэмжээнд хадгалж, эдийн засгийн тэнцвэртэй байдлаа хадгалж үлдэхгүй бол Монголын эдийн засаг импортоос улам бүр хамааралтай болж буйг бодлогын судалгаа нотолж байна. Товчхондоо, импортын хэрэглээг зохистой хэмжээнд хадгалж, үндэсний үйлдвэрлэлээ дотоодын хэрэглээгээр дэмжих цаг болжээ.

“Бат суурьтай эдийн засгийг хөгжүүлэхийн тулд үйлдвэрлэлийн том суурьтай эдийн засагтай байх ёстой. Ямар ч нөхцөлд хөдөлгөөн багатай, бодит агуулгатай, тогтсон тодорхой бодлоготой байснаар урт хугацаандаа эдийн засаг тогтвортой хөгжинө. Тиймээс тодорхой хэмжээний үйлдвэржилт явуулах хэрэгтэй. Засгийн газар үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөө энэ зүгт чиглүүлэх нь зүйтэй. Одоогийн байдлаар Монголын эдийн засагт “Голланд өвчин”-ий ерөнхий шинж бүрдээд байна. Эдийн засгийн бүх нөөц зөвхөн уул уурхайн салбарт шингэж байна” хэмээн Батсүх багш хэлсэн. Түүний хэлснээр манайд боловсруулах үйлдвэрийн салбар хоёр хүчин зүйлийн нөлөөгөөр шахагдаж буй аж. Нэгдүгээрт, өнөөдөр зөвхөн уул уурхайн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалт шууд шилжиж байна. Хоёрдугаарт, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гадаад зах зээлтэй өрсөлдөж чадахгүй, импортын барааг шахагдах болсон гэв.



Аргагүй байдлаас хэрхэн мултрах вэ

Манайх байгалийн баялаг ихтэй, жижиг мөртлөө нээлттэй эдийн засаг. Хэн ч хөрөнгө оруулж болох эрх зүйн болон эдийн засгийн эрх чөлөөт талбар. Гэхдээ мэргэжлийн хүний тайлбарласнаар манай эдийн засаг худалдаалагддаг, худалдаалагддаггүй буюу зөөвөрлөгдөхгүй, уул уурхай гэсэн гурван салбараас бүрдэх аж. Зөөвөрлөгдөхгүй салбарт барилга, газар, үйлчилгээ багтдаг. Төсвийн бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөг худалдаалагддаггүй салбарт нэмэгдүүлснээр эдийн засагт илүү их үр ашиг бий болох гэнэ. Мөн төсвийн зарцуулалтаар импортыг дэмжсэнээр төгрөгийн ханшийн чангаралт болон худалдаалагддаг салбарын үйлдвэрлэлийн бууралт багасна гэж судалгаанд тооцжээ.

Төрөөс дотоодод худалдаалагдах салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, эдийн засгаа хамгаалах эрэлт хэрэгцээ үүсээд эхэлснийг бодлогын судалгаанд тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, импортын арганд орохгүйн тулд дотоодын үйлдвэрлэлийг өөд нь татах шаардлагатай байгааг бодлогын судалгаа боловсруулсан Ц.Батсүх багш тайлбарласан юм. Энэ нь уул уурхайн орлогоос үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө шилжүүлэх.

“Энгийнээр тайлбарлахад бид түүхий эд л үйлдвэрлэж экспортолдог, гэтэл машин тоног төхөөрөмж, нефтийн бүтээгдэхүүн, удаан эдэлгээтэй бараа, хүнс, хувцас, хэрэглээний бусад бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэж чадахгүйгээс шалтгаалан гадаад худалдааны алдагдал өссөөр байгааг Төвбанкны ерөнхий эдийн засагч С.Болд хэлсэн.

Худалдах, эс худалдах

Манай улсын эдийн засаг сүүлийн дөрвөн жилд дунжаар есөн хувиар өсчээ. Энэхүү эдийн засгийн огцом өсөлт, гадаад худалдааны эргэлтийн дүнд ашгаас гадна алдагдал “үйлдвэрлэсээр”. Ойрын хоёр жилд манай улсын эдийн засаг дунджаар 15 хувиар өсөхөөр байгаа боловч хөрөнгийн урсгал олз болохын зэрэгцээ гай ч болж мэдэх нь. Өнгөрсөн оны байдлаар уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулалт 83.4 хувь болтлоо нэмэгджээ. Энэ нь эдийн засгийн тэргүүлэх салбарын хувьд амжилт боловч эрсдэл. Өөрөөр хэлбэл, Монголын эдийн засаг ганцхан далавчтай болж байна гэсэн үг. Тиймээс эдийн засгаа төрөлжүүлэх, олон тулгуурт эдийн засгийн бүтэцтэй болохыг цаг үе, амьдрал аль аль нь алхам тутамд шаардсаар. Төрөлжиж чадаагүй эдийн засагт үлэмж орлого тогтохгүй гэж үздэг. Тэгвэл уул уурхайн салбар хэчнээн амжилттай хөгжсөн ч тогтвортой хөгжил биднээс алс хол. Тиймээс өөрийн гэсэн эдийн засгийн “вант” улс байгуулахын төлөө Засгийн газар мэрийх цаг иржээ. Уул уурхайг тойрсон их мөнгөний хаялага зөвхөн тус салбар, түүнийг хүрээлсэн бичил зах зээлийг услахад хязгаарлагдаж байгаа нь учир дутагдалтай хөгжил болохыг бодлогын судалгаанд өгүүлсэн.

Тухайлбал, уул уурхайн салбарын дундаж цалин 2005 оноос эхлэн өндөр болж эхэлсэн нь бусад салбарт хүндрэл учруулж, цалингийн өсөлтийг дагасан хөдөлмөрийн шилжилтийг ихэсгэжээ. Энэхүү “оюуны дайжилт” нь цаашид ч өсөх магадлалтай байгааг тус судалгаанд анхааруулсан.

Өнгөрсөн хугацаанд гаднын хөрөнгө оруулалт өссөн нь үргэлж мөнгөний гачаалтай эдийн засагт гэнэтийн өөрчлөлт болсныг ч онцолсон байна. Энэхүү өөрчлөлтийн дүнд байгалийн баялгийн салбарын үйлдвэрлэлд огцом эргэлт гарч, худалдаалагддаггүй салбарын цалин болон хөдөлмөрийн эрэлт сайжиржээ. Үүнээс үүдэн худалдаалагддаггүй бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн дүнтэй гарчээ. Тухайлбал, барилгын салбарыг нэрлэж болно. Харин аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл багасаж, төгрөгийн бодит ханш чангарснаар худалдаалагддаг салбарын үйлдвэрлэл буурчээ.

Европын өрийн хямрал хүндэрч, дэлхийн эдийн засаг уналтад орвол манай эдийн засаг, гадаад худалдаа, хөрөнгийн урсгалаар дамжин өртөх эрсдэл өндөр байгааг бодлогын судалгаанд тодорхойлжээ. Тухайлбал, муугаар бодоход л манай экспортын барааны үнэ дэлхийн зах зээл дээр огцом буурч, экспортын орлого зогсонги байдалд орох тохиолдолд гадаад валютын цэвэр албан нөөц нь 4.3 сарын импортын хэрэгцээг л хангахаар байна.

Тиймээс уул уурхайн салбараас орох орлогоор сан байгуулж, түүгээрээ хөрөнгө оруулах нь “Голланд өвчнөөс” урьдчилан сэргийлэх шалгарсан арга гэж Монголбанкнаас үзсэн юм. Эдийн засгийн өсөлт нэг хувиар буурахад л ядуурлын түвшин 2.7 нэгж хувиар өсөх буюу 73 мянган иргэн ядуурлын ангилалд шилжих тооцоо бий. Тэгвэл эдийн засгийн өсөлтөө тогтвортой хадгалж үлдэхийн тулд хөрөнгийн урсгалыг дотооддоо аргамжих шаардлагатай болж байна. ■



ТОМИЛОЛТ

ТЭВЧ, ИТГЭ, ХҮЛЭЭ

Монгол сангийн болоод улс төрийн тогтвортой бодлогоо нэгдмэл зарчмаар зангидаж чадахгүй бол хөрөнгө оруулагчид монголчуудыг нэгдэхийг хүлээгээд, суугаад байхгүй.

Өнгө өнгийн гэрэл сүүдэр үгүй сүлэлдэх нь харанхуй гэгч ертөнцийн жам ёс халаагаа өгсөн мэт санагдуулах ажээ. Гэрлийн ертөнц Хонконг руу боломж эрэлхийлэгчид өдөр шөнөгүй цувдаг. Хүний нүднээс бусдыг олж болом энэ газар боломж хэмээх зүйлийн хажуугаар зөрөөд өнгөрөгсөд үл ирнэ. Олны нүдэнд онцгойрох болсон хөх тэнгэрийн оронд хөгжил дэвшил гэрлийн хурдаар давшилж буй сургаар өдөр шөнө нь үл мэдэгдэм завгүй энэ хотод дэлхийн өнцөг булан бүрээс түнтгэр түрийвчтэнгүүд хоёр өдөр чуулахаар иржээ.

Санхүү, эдийн засгийн зангилаа цэгүүдийн нэг Хонконгт аравдугаар сарын 30-31-нд Монголын хөрөнгө оруулалтын дээд хэмжээний уулзалт гурав дахь жилдээ болж өнгөрлөө. Эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй яваа Азийн цээжинд орших Монгол улс хахаж цацсан баялагтайг дуулсан 500 гаруй хөрөнгө оруулагчид алтан боломжноос атгалцах хүсэлдээ дийлдэн хүрэлцэн ирсэн нь энэ ажээ. Эхний өдөр хурлын хөтөлбөр Монголын эдийн засгийн өнөөгийн байдал, уул уурхай болон хөрөнгийн зах зээлийн боломж, сорилтууд дээр түлхүү төвлөрсөн. Харин хоёр дахь өдөр уул уурхайн бус салбар тэр дундаа зам тээвэр, эрчим хүч, үл хөдлөх хөрөнгө, банк, даатгалын салбарт ач холбогдол өгч ярилцсан билээ.

Дэндүү ардчилсан..

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуультай холбогдсон дуулиан намжаагүй байхад Оюутолгойн гэрээг дахин хэлэлцэх асуудал сөхөгдөж, Засгийн газар бонд гаргахаар болсон нь Хонконгийн уулзалтын ерөнхий өнгө аясыг энэ зүгт залсан гэж хэлэхэд хилсдэхгүй. Гэсэн ч Хөрөнгө оруулагчдын сонирхол бууражгүй халуун хэвээрээ байгааг өмнөх хуралд оролцогсод ч хэлж байлаа. “Эм Ай Эйч” группын ерөнхийлөгч Д. Жаргалсайхан “Оюутолгойн гэрээтэй холбоотой асуудал сөргөөр нөлөөлж байгаа нь илт байна. Монголд хөрөнгө оруулалтын том боломжууд байгаатай хэн ч маргахгүй. Гол нь шинэ Засгтийн газрын бодлого, чиглэл ямар байна гэдгийг л ойлгож, мэдье гэсэн уур амьсгал давамгайлж байна” хэмээв. Хуралд оролцож буй манай төр, хувийн хэвшлийнхэн Монголд алдаа дутагдлаа хурдан засаад, цааш хөдлөх зөв тогтолцоо бий гэдгийг хөрөнгө оруулагчдад ойлгуулахыг зорьж буйгаа учирлаж байсан юм. Энэ жил оролцогчдын тоо буруугүйгээр үл барам нэмэгдсэн гэдгийг зохион байгуулагчдын зүгээс мэдээлсэн юм. Танхимд суудал олдохгүй шахам байсан хоёр өдөр илтгэлүүдийн араас залгах хэлэлцүүлэг ч мөн ширүүхэн болж байв. “Хүннү Коал” компанийн ерөнхий захирал Т. Лхагвадорж “Манай улсын гадаадын хөрөнгө оруулалтад баримтлах бодлогод ямар ахиц гарч байгааг олон хөрөнгө оруулагч сонирхож байна. Төрөөс баримтлах хууль тогтоомж, бодлого тодорхой болоогүй энэ үед ажил хэрэг асуудалгүй урагшилж байгаа гэж хариулж чадахгүй байна. Тиймээс ч хөрөнгө оруулагчдыг үргэлжлүүлэн болгоомжлоход хүргэж буй сул тал бий” гэлээ.

Хүний хүү ингэж харжээ

Тухайн улсын эдийн засгийн боломж ба сорилтыг жинлэх нь хөрөнгө оруулагчдын хувьд зүй ёсны хэрэг тул Монгол улсын өнөөгийн бодит нөхцөлд ихээхэн ач холбогдол өгч байсан юм. Тиймээс ч хурлын эхний өдрийн үдээс өмнө тавьсан илтгэлүүд ерөнхий мэдээлэл өгсөн шинжтэй байлаа. Түүн дундаас олны анхаарлыг сорондож, чихийг сортойлгосон нэгэн илтгэл нь M.A.D компанийн захирал Кристофер Ди Грубенийх байв. Тэрбээр олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл сүүлийн үед Монголыг хэрхэн харж байгаа талаар илтгэлийнхээ эхэнд дурдсан юм. Тухайлбал, Trefis цахим хуудсандаа Баялаг дагасан үндсэрхэг үзэл Рио Тинтог заналхийлж эхэллээ хэмээх утга агуулга бүхий нийтлэл гаргасан бол Reuters Олон удаагийн алгуурласан байдал, буруу алхам “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийг урагшгүйг харуулж байна хэмээн бичжээ. Харин The New York Times Эзэмшил, татварын санал Оюутолгой төслийг заналхийлж байна хэмээсэн бол Wall Street Journal Монгол бүтэлгүй ардчилалын бас нэгэн туршилт болоход ойрхон байна хэмээн нийтлэжээ. “Сүүлийн үед олонд цацагдсан энэ мэт нийтлэлүүд Монгол улс олон улсад сөрөг хандлага төрүүлж байгааг онцолж байгаа агаад Монголын цэнхэр тэнгэр сааралтан бүүдийж байна гэж ойлгох уу? Хөрөнгө оруулагчид үнэхээр тус улсаас дайжиж байгаа гэж үү” гэх асуултыг бий болголоо гэж Кристофер хэлж байсан. Тэгвэл түүний дүгнэлтийг



сонирхоё. Ирэх он Монголын хувьд хөрөнгө оруулалт далласан ер бусын жил байх нь илэрхий. Санхүү эдийн засгийн саармагжил нь Монгол улсад саваа бэлдэж, саалиа хураах өөрөөр хэлбэл, асуудлаа цэгцэлж, тогтвортой байдал авчрах боломж өгнө. Магадгүй бид ирэх жил илүү цөөн “ковбой” хөрөнгө оруулагчтай болж, илүү ухаалаг мөнгө салбаруудад цутган орж ирэхийг харж мэдэх юм. Нөгөө талаас Монгол сангийн болоод улс төрийн тогтвортой бодлогоо нэгдмэл зарчмаар зангидаж чадахгүй бол хөрөнгө оруулагчид монголчуудыг нэгдэхийг хүлээгээд, суугаад байхгүй. Нөхцөл байдал хурдан сайжрахгүй аваас энэ бүх үйл явц Улаанбаатарын сүүлийн “Танго” болж ч болохыг сануулж илтгэлээ ширүүхэн төгсгөсөн билээ.

Монголын эдийн засгийн цаашдын боломжид эргэлзэгсэд өнгөрсөн хагас жилд олширсон гэж хэлж болно. Харин олон улсад үйл ажиллагаа явуулдаг “Гаррисон Капитал” компанийн ерөнхий захирал Матью Вүүд хэлэхдээ “Хүн болгон л дэд бүтэц, үйлчилгээ энэ тэр гэж гомдоллож байна. Үнэндээ Монгол шиг бүх үйл явц тийм богино хугацаанд явдаг орныг би лав мэдэхгүй юм байна. Бидний хувьд зөвшөөрлөө аваад үйлдвэрлэгч болох хүртлээ ердөө л 18-хан сарыг зарцуулсан. Энэ бол хөрөнгө оруулагчдад төрөөс үзүүлж буй том дэмжлэг гэж үнэлдэг. “Гаррисон Капитал” Монгол улс дахь үйл ажиллагааныхаа хувьд холыг харж байгаа” хэмээн хурлын үеэр байр сууриа илэрхийлсэн юм.

Тус хурал дээр хөрөнгө оруулагчдын санааг зовоож, шийдэл нь юу байх бол хэмээн чих тавин хүлээсэн асуудал нь дэд бүтэц байсан билээ. Хөрөнгө оруулагчдын зүгээс ч энэ төрлийн асуулт цөөнгүй ирж байв. Гэвч энэ бол хэт их ач холбогдол өгч санаагаа чилээх асуудал биш хэмээн хэлэлцүүлэгт оролцсон Монголын хөрөнгө оруулагчид бусаддаа зөвлөж байв. ‘Firebird Mongolia” сангийн үүсгэн байгуулагчдын нэг, захирал Жеймс Пасин “Засгийн газрын бонд гаргах болсон шалтгааныг аваад үзвэл Монголын засгийн газар тун зөв бодлого баримталж байна гэж бодож байгаа. Мөсөн уулын оргил нь дэд бүтэц учир түүндээ ч хүрэхийг ийнхүү хичээж байна” хэмээн хариулж байсан билээ. Мөн зарим нь уул уурхай дэд бүтцийг бий болгодог болохоос дэд бүтэц уул уурхайг бүтээдэггүй гэж хэлж байсан юм. Монголд ажиллаж амьдарч буй гадаадын хөрөнгө оруулагчид болон холбогдох салбарын мэргэжилтнүүд Монгол улсын эдийн засгийн боломжийг богино хугацаанд бус урт хугацааны тогтвортой өсөлттэй нь жинлэж үзэх хэрэгтэйг зөвлөж байлаа.

Анхны харцаар

Хөрөнгө оруулагчдын хандлага өөрчлөгдсөн үү гэвэл өөрчлөгдсөн. “ResCap”компанийн ерөнхий захирал Эрик Цюрин “Хөрөнгө оруулагчид илүү болгоомжилсон болчихсон нь ажиглагдаж байна. Олон улсын хэвлэл мэдээллээр нийтлэгдсэн мэдээллийг тийм ч тэнцвэртэй, бодит гэж бодохгүй байна. Гарчгийг нь уншаад дүгнэлт хийх амархан. Хэрвээ урт хугацааны хэвийн төлөвийг нь авч үзвэл хөх тэнгэрийн оронд дэлхийн аль ч орноос хайгаад олдохгүй тийм хэмжээний эрсдэл бүхий боломж байгаа” гэв. Тэгвэл анхны харцаар дурласан ч гараас нь барьж зүрхлэхгүй байгаагийн учир юу вэ.

Монголд очиж үзээгүй ч хөрөнгө оруулах сонирхолдаа хөтлөгдөн тус хуралд оролцож явсан Алфа группын захирал Петер Куанг “Эхний өдрийн үдээс өмнөх хэсэг их гайхшруулаа. Монголын одоогийн нөхцөл байдал боломжийг харуулсан тус илтгэлийн 70 хувь сөрөг өнгө аястай байлаа. Хөрөнгө оруулагчийн хувьд эрсдэл дааж чадах ч хэтийдсэн тэнэг эрсдэл үүрнэ гэж бодохгүй байна” гэсэн юм. Монголд хөрөнгө оруулахаар сонирхож буй тэдний хувьд нэг талаас ийм байна, нөгөө талаас тийм байна гэж ярих нь таалагдсангүй бололтой. Хөрөнгө оруулалтын салбарт бүл нэмэн Монгол руу жолоо залж буй үл хөдлөх хөрөнгийн “Максвел Жонсон” компанийн Андрью Жонсон арай өөр бодолтой байлаа. Тэрбээр хэлэхдээ “ Мэдээллийн хувьд тэнцвэртэй байсан. Эртхэн сайн, муугаа мэдэлцэх нь амар байдаг. Мөнгөний асуудалд эрсдэл байж л таарна” гэж хэлсэн юм.

Загтнасан газар маажив гэгчээр олон асуудал дээр санаа оноогоо уралдуулах боломжийг төр, хувийн хэвшил, иргэнд олгосон тус хурал ширүүхэн эхэлсэн ч шийдэл олонтой дууссан. Хэдийгээр Монголын төр засгаас харьцангүй цөөн төлөөлөл оролцлоо гэж шүүмжлэх нэгэн байсан ч томоохон хөрөнгө оруулагч олонтой харьцангүй цар хүрээний хувьд өргөн боллоо, Монгол ч аргагүй ассан гал шиг дүрэлзэж байгаа юм байна даа гэж уулга алдах нөгөө нь ч мөн байлээ. Хурлын явцад Монголд үйл ажиллагаа явуулдаг дотоод гадаадынхан бүгд л түр зуурын асуудлаар нүдээ боолгүй алсад хараагаа бэлчээж, ирээдүйг хараасай гэж хөрөнгө оруулагчдаас хүсч байлаа. Монголоос хоёр онгоцонд багтаж ядан ирсэн тус уулзалтын оролцогчид нутгийн зүг жолоо залсан ч ирэх жилийн дөрөвдүгээр сард Лондон хотноо эргэн уулзана. ■

ЕРТӨНЦ

ХЯТАД МӨРӨӨДӨЛ БУЮУ УРВУУЛАХ УРЛАГ

Б.ҮҮРИЙНТУЯА

... Хагас зууны тэртээ 400 саяулаа байсан хятадууд өнөөдөр дэлхийн нийт хүн амын 19.12 хувь буюу 1.3 тэрбумыг бүрдүүлж байна. Тэдний 72.1 хувь нь 15-64 насныхан бөгөөд урд хөршийн хөдөлмөрийн чадвартай иргэд. Гэтэл тэдний ердөө 3.6 хувь нь л дунд буюу түүнээс дээш боловсролтой байдаг...

Америк мөрөөдөл гэх төсөөлөл дэлхий нийтийг хучиж байсан нь саяхан. Эрх чөлөөний орны түүхийг бичилцэхээр олон сая хүн эх орноороо дэнчин тавин харийг зорино. Харин шинэ мянганы эдийн засгийн хямрал тэрхүү төсөөллийг дорнын соёл руу хөтлөх болжээ.

Сүүлийн жилүүдэд Хятад улс мэдлэг, туршлагатай гаднын мэргэжилтнүүдийг "урвуулах" болсон. Сэтгэл татам ажлын байр, өндөр цалинд нүүр буруулах хүн ховор. Шинжээчид үүнийг Хятад мөрөөдлийн эрин хэмээн нэрийдэх болов.

Урд хөршийн Засгийн газар 11 дэх таван жилийн төлөвлөгөөндөө тусгасан "1000 авьяас" хөтөлбөрөө 12 дахь таван жилийн төлөвлөгөөнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээ мэдэгдсэн. Хятад улс дахь гадаад ажилчдын асуудал хариуцсан газрын дэд дарга Лью Янгуо "China Daily" сонинд өгсөн ярилцлагадаа "Хятад гүрэн гаднын өндөр боловсролтой мэргэжилтнүүдийг дотоодын шинжлэх ухаан, эдийн засгийн салбаруудад ажиллуулж байгаа нь хөдөлмөрийн зах зээлээ олон түмэнд нээж өгч буй хэрэг" хэмээн онцолсон билээ.

Хятадын эрх баригчдын явуулж буй эл бодлогын хоёр дахь хэрэгжилтийг өнгөрсөн жилээс эхлүүлсэн бөгөөд дэлхийн өнцөг, булан бүрээс туршлагатай, чадварлаг 1000 мэргэжилтэнг урин ажиллуулах юм. Гадаадын боловсролоор дотоодоо хөгжүүлэх уг санаа нь тус улсын хувьд шинэ зүйл биш юм. 1990-ээд оны үед ч гаднын эрдэмтдийг таатай ажлын байр санал болгон "урхидаж" байлаа. Барууны орнуудад эрдэмтдийг шинжлэх ухааны төв болж буй орнуудад туршлага хуримтуулахыг шаарддаг. Үүнийг ч Хятад алдалгүй ашиглаж, гадаадынхны мөрөөдлийг биелүүлсээр ирсэн.

Хятадын Засгийн газрын 11 дэх таван жилийн төлөвлөгөөнд оруулсан уг төслийн хүрээнд 1600 орчим гадаадын мэргэжилтэнг холбогдох салбаруудад ажиллуулсан байдаг. Төслийн үндсэн зорилго нь гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдээ эх оронд нь татах байсан юм. Харин энэ удаа урд хөршийн эрх баригчид харийнхныг өөрийн оронд татахаар зориг шулуудсан бололтой.

Гадаадаас хүрэлцэн ирэх боловсон хүчин математик, хими, физик, байгаль орчин, эрчим хүч, инженер болон нийгмийн ухаан, бизнесийн салбарт хүчин зүтгэх ажээ. Түүнчлэн импортын гэж болох 1000 мэргэжилтний талаас доошгүй хувь нь инновацийн чиглэлээр ажиллах юм байна. Лью Янгуо "Манай улсад ажиллах хүсэлтэй гадаадын мэргэжилтнүүд тун өндөр шалгуурыг давах шаардлагатай. Тухайлбал, хүсэлт гаргагч этгээд 65-аас доош насных байх бөгөөд тус улсад гурваас доошгүй жил ажиллах боломжтой байх, ингэхдээ жилд есөн сар Хятад улсын нутаг дэвсгэрт суурин байх шаардлагатай. Мөн тухайн мэргэжилтэн сонгон шалгаруулах коммиссын шаардлагад нийцэх үүрэгтэй" гэв. Хүсэлт гаргагчдын олонх нь АНУ, Япон, Их Британи болон ОХУ, Герман зэрэг урд хөрштэй эдийн засаг, шинжлэх ухааны салбарт түнш улсын иргэд байгаа аж.

Хятад гэх нэрийг брэнд болгохоор тус улсын Засгийн газар 1990 оноос хойш чадварлаг боловсон хүчин бэлтгэх ажилд ханцуй шамлан орсон. Ийнхүү дотоодын боловсролын салбарыг хөгжүүлэхээр АНУ, Их Британиас мэдлэгийн их далай болсон багш, профессоруудыг урин өндөр цалинтай ажиллуулж ирсэн. Өнөөгийн ханшаар Хятадын топ 10 их сургуулийн нэг болох Шэньжэний их сургууль гадаад багшид жилийн 200.000 ам.доллар хүртэлх цалинг олгож, зарим тохиолдолд 100.000 гаруй ам.долларын тэтгэмж өгдөг байна. Хонконгийн Боловсролын их сургуулийн профессор Ли Жун "Хятадын томоохон их, дээд

сургуулиуд Засгийн газраас асар их санхүүжилт авдаг. Энэ утгаараа боловсролын салбарт гадаадын эрдэмтэн, шинжээчдийг авчрах боломжтой байдаг. Энэ нь тус салбар дахь хамгийн том хөрөнгө оруулалт" хэмээн онцолжээ.

"1999 оноос "1000 авьяас" хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнээс хойш эх орондоо суршин ажиллах Хятадын чадварлаг боловсон хүчин нэмэгдсэн. Хөтөлбөрийн эхэн үед 7000 хятад иргэн онолын мэдлэгээ эх орныхоо хөрсөнд дадлага болгохоор ирж байсан бол энэ тоо 2005 он гэхэд 30 000 болж өссөн" хэмээн Хонконгийн их сургуулийн профессор Давид Звайг нэгэн судалгаандаа дурджээ. Түүнчлэн жил ирэх тусам их, дээд сургуульд элсэн орогчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор тэдэнд мэдлэг түгээх чадварлаг, туршлагатай багш, сурган хүмүүжүүлэгч шаардлагатай болсон. Зөвхөн 2012 онд нийт 6.5 сая оюутан ажлын талбарт бэлтгэгдэнэ гэх судалгаа байна. Иймд урд хөршийн Засгийн газар хөгжлийн хурдаа идэвхжүүлэхийн тулд гаднын мэргэжилтнүүдийг боломжит бүхий л аргаар "өөрийн" болгох сонирхолтой байгаа. Тэд нэг сая юань (157,700 ам.доллар) урьдчилгаа хэлбэрээр амлаж, өндөр цалин, таатай нөхцөл санал болгон ажиллах хүч импортлох аж. Харин судалгаа, шинжилгээ хийх тохиолдолд таван сая хүртэлх юанийн мөнгөн тусламж үзүүлнэ хэмээн төсөлд тусгажээ. Энэхүү хөтөлбөр тус улсын эдийн засгийг шинэ түвшинд авчирна хэмээн олон улсын шинжээчид дүгнэсэн удаатай.

Дотоодын стратегийн салбаруудыг "их тархи"-аар чимэх нь дэлхийн эдийн засаг, батлан хамгаалах секторт урд хөршийн эзлэх байр суурь, нөлөөллийг нэмэгдүүлэх аж. Стратегийн салбаруудаа хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлээ нээлттэй болгох нь Хятадын хувьд эдийн засгийн өсөлтийн түлхэц болох юм. Түүнчлэн Хятадыг гадаад орнуудад сурталчилах өөр нэг стратеги ч байж болох. Ийм төрлийн харилцан үйлдэл тус улсын эрх баригчид дэлхийн эдийн засгийн "тоглоом"-ын дүрмийг шинэчлэхээр зорьж буйг илтгэх аж. Харин Их Британийн Ноттингхамийн их сургуулийн профессор Чонг Чау эсрэг бодолтой байгаа аж. Тэрбээр "Богино хугацааны мөрөөдлийн араас хөөцөлдөх хүн төдий л байхгүй болов уу. Хэдийгээр Хятадын боловсролын салбар ахархан хугацаанд шинэчлэгдэж байгаа ч Оксфорд, Харвардын хэмжээнд хүрэхэд дор хаяж хоёр үе элээх шаардлагатай. Хятадын хөрөнгө оруулалт тус улсын ДНБ-ий 2.5 хувийг бүрдүүлдэг гэвэл АНУ, Их Британи зэрэг оронд энэ харьцаа 15 хувьтай байна. Түүнчлэн боловсролын салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ дээрх хоёр улстай харьцуулахад ердөө таван хувь байгаа юм" гэжээ. Түүний хэлснээр, урд хөрш дотооддоо байгаа авьяаслаг залуусаа хөгжүүлээгүй цагт боловсролын супер лидер болох зам нь дардан байхгүй гэнэ.



Хятадад ажиллаж, амьдарч буй гадаадын мэргэжилтнүүдийн тус улсын хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлэх зорилгоор анх 1991 онд "Нөхөрлөлийн шагнал" гардуулах ёслолыг зохион байгуулж байжээ. Энэ нь Хятадын Засгийн газраас гадаадын иргэдэд олгодог хамгийн дээд шагнал юм. Энэ жилийн ёслолын үеэр Хятадын Төрийн зөвлөлийн гишүүн Ма Кай "Та бүхэн манай улсын хувьд чухал нэгэн хэсэг бөгөөд Хятадыг шинэчлэлд хүргэх гүүр юм. Энэ их хичээл, зүтгэлийн хариуд бид, Засгийн газар, улсаа гадаад ертөнцөд илүү нээлттэй болгохыг зорьж, инновацийг дэмжин ажиллах болно" гэв. Эдийн засгийн хямрал, ажилгүйдэл нүүрлээд буй өнөө үед гадаадын мэргэжилтнүүдэд их хэмжээний мөнгө амлах нь хэний ч чихэнд чимэгтэй дуулдана. Энэ үйлсэд Хятадын удирдлагууд өглөгч хандаж байгаа нь бүр ч таатай. Тэд гаднынхнаас суралцаж, туршлага солилцохоос татгалздаггүй. Энэ утгаараа дотоодын оюутнуудыг гадаадын өндөр хөгжилтэй оронд сургах тал дээр хэтэвчээ нимгэлэх нь элбэг. Цаад зорилго нь гэвч гаднын туршлагыг эх орондоо амжилттай хэрэгжүүлэхэд орших аж.

Хятадын эдийн засгийн гялбаа ялимгүй гундаж буй өнөө үед дэлхийн топ мэргэжилтнүүдийн тархийг өнгө, мөнгөөр угааж, урвуулах нь зөвхөн Азийн бус дэлхийн "бар" болох тэмүүллийн нэгээхэн хэсэг гэлтэй. ■

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

НОГООН ОЛИМП



Х.ХУЛАН

...Лондоны Олимпийн хотхоныг нийслэлийн зүүн хэсэгт байрлах Стратфорд дүүрэгт бүтээн байгуулсан билээ...

Арлуудын дунд орших алсын Англи улс дэлхийн тавцанд нэрээ олонтаа цууриатуулсан. Хамгийн сүүлд өнгөрсөн зун Лондон хотноо болсон Зуны Олимпийн XXX наадмыг бүгд тодхон санаж байгаа байх. Таван тивээс хүрэлцэн ирсэн тамирчдын дунд Монголын спортын шилдгүүд улсынхаа тугийг намируулан алхаж явсан үе саяхан. Энэхүү ёслол төгөлдөр, сүр жавхлант Олимпийн тоглолтыг зохион байгуулахтай холбоотой өрнөсөн нөр их ажлыг танилцуулах зорилгоор дараах мэдээллийг бэлтгэлээ. Монгол дахь Британийн Элчин сайдын яамнаас өнгөрсөн есдүгээр сард “Буянт Ухаа “цогцолборт болсон “Mining and Construction Mongolia” олон улсын үзэсгэлэнгийн үеэр сонирхуулсан “Going for Green” баримтат киног эх сурвалжаа болгов.

Аж үйлдвэржилтийн өлгий арал

Тогтвортой хөгжил болон ногоон өсөлт нь сүүлийн жилүүдэд байнга яригдах сэдэв боллоо. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчны доройтолтой шууд холбоотой тул дэлхийн улс, гүрнүүд энэ тал дээр анхаарах шаардлага урган гарсан. Зуны Олимпийн XXX их наадмыг зохион байгуулах тендерийн эрхийг Англи улс 2005 оны долдугаар сард гардан авсан билээ. Харин энэхүү нэр хүнд бүхий том арга хэмжээг зохион байгуулах болсон азтай оронд нэг болзол тавьсан байна. Тэр нь Олимпийг эхнээс нь эцэс хүртэл байгаль орчинд ээлтэй, тогтвортой байдлыг эрхэмлэн ажиллах даалгавар байв.

Их Британид XVII зуунаас гадаад худалдаа, арилжаа наймаа хөгжин цэцэглэж эхэлсэн. Энэ нь дараагийн зууны дунд үед тус оронд аж үйлдвэржилтийн хувьсгал гарахад түлхэц болсон билээ. Тухайн үеийн Английн хүн амын тоо 1780-1900 онд найман саяас 32 сая болж өссөн. Түүнчлэн хүн амын ихэнх нь хөдөө, орон нутгаас хот сууринд шилжин суурьшиж, томоохон үйлдвэр, нүүрсний уурхайд ажиллах болсон түүхтэй. Өөрөөр хэлбэл, шинэ техник, технологийн дэвшил аж үйлдвэржилтийн суурийг тавьсан. Анхны уурын галт тэргийг Английн инженер Жорж Стивенсон 1815 онд зохион бүтээснийг Та дуулж байсан биз ээ.

Стратфорд дүүрэг дэх Олимпийн хотхон

Лондоны Олимпийн хотхоныг нийслэлийн зүүн хэсэгт байрлах Стратфорд дүүрэгт бүтээн байгуулсан билээ. Ашиглахаа болиод удсан аж үйлдвэрийн барилга байгууламж, хортой хог хаягдлаар дүүрсэн газар нутаг, эдийн засгийн хөгжил сул дүүргийн дүр зургийг Та төсөөл дөө. Гэтэл Стратфорд нь цагтаа улсынхаа аж үйлдвэрийн стратегийн ач холбогдол бүхий төв байв. Лондон хотын ихэнх аж үйлдвэрүүд XIX зуунд энд байрладаг байжээ. Жишээ нь, дэлхийн анхны хуванцрын үйлдвэр. Харамсалтай нь аж үйлдвэржилтийн эрин үеэс өнөөг хүртэл химийн хортой бодис газрын гүнд ул мөрөө үлдээсэн аж. Иймд Олимпийн цэнгэлдэх хүрээлэн барьж тохижуулахын тулд талбайг юуны өмнө эдгээр аж үйлдвэрийн балгас болон хордсон хөрсийг хоргүйжүүлэх шаардлага тулгарсан юм.

• Магадгүй Та хуучин байр байшин барилгыг техник ашиглан нураахад асуудал юу байна гэж бодож болох юм. Гэтэл эдгээр хог хаягдлыг экологид ээлтэй аргаар нураана гэдэг өөр хэрэг билээ. Ингээд нийт



Лондоны Олимпийн хотхон, 2012



220 гаруй барилгыг нурааж, хэсэгчлэн зөөсөн аж. Ийнхүү зөөсөн олон мянган тонн тоосго, шавар болон бетонын 90 хувийг шинээр барих барилга байгууламжийн суурь болгож ашигласан байна.

• Талбай цэвэрлэх ажлын дараагийн шатанд хөрсөнд шингэсэн тугалга, мөнгөн ус, цайр, зэс, тос зэрэг бодистой шороог хоргүйжүүлэх ажил ундарсан байна. Нийт хоёр сая тонн шороон хаягдал металл ялгагч соронзонтой шороо хоргүйжүүлэх машинаар ялгаж авчээ. Хөрсний нөхөн сэргээлтийн инженер Клэйр Стэйвли “Бидэнд хөрс хоргүйжүүлэх ажлыг маш богино хугацаанд хийх үүрэг өгсөн. Иймд амралтын өдөр ч 07.00- 19.00 цаг хүртэл шаргуу ажилласан. Үүнийхээ хүчинд бохирдсон хөрсний 85 хувийг дахин ашиглаж чадлаа” гэжээ. Энэ нь аливаа хог хаягдлыг зүгээр нэг хамж аваад хогийн цэг дээр булах биш, харин дахин ашиглаж болдгийг дэлхий нийтэд харуулж байна.

• Ирээдүйн Олимпийн паркийн талбай дээр буй хэдэн зуун км үргэлжлэх 65 метр хүртэлх өндөртэй 52 өндөр хүчдэлийн шугамыг хаашаа зөөвөрлөх вэ гэсэн томоохон асуудалтай тулгарсан. Үүнийг шийдэх мэргэн арга сүвэгчилсэн нь газар доогуур тус бүр зургаан км үргэлжилсэн хоёр хонгил барих ажил байлаа. Нийт дөрвөн жилийн хугацаанд бүтээн байгуулах ажлыг хоёрхон жилийн дотор гүйцэтгэж, эрчим хүчний шугам сүлжээг угсарсан нь үнэхээр гайхалтай.

• Лондоны Олимпийн төв цэнгэлдэхийн загварыг архитектор Род Шийрд гаргасан байна. Шийрд болон түүнийн багийнхан бүтэн зургаан сарын турш хэрхэн байгаль орчинд ээлтэй, Олимпийн дараа ч гэсэн ашиглаж болох цэнгэлдэх хүрээлэн бүтээх вэ гэж оюун санаагаа уралдуулсан аж. Нийт 80- 90 мянган хүнд зориулсан цэнгэлдэхийг хожуу ашиглахад хэтэрхий нүсэр болж байсан тул загварын шийдлээ зөв гаргах хэрэгтэй болсон билээ. Ингээд нэгэн өдөр тэд шинэ санаа олсон байна. Цэнгэлдэхийн доод буюу үндсэн хэсэгт нийт 25 мянган үзэгчид зориулсан бетон байгууламж хийхээр төлөвлөж. Харин үүний дээр

нь хөнгөн гангаар хийсэн 55 мянган хүнд зориулсан түр зуурын суудалтай хэсгийг нэмжээ. Олимпийн бусад барилга байгууламжийг барихад ч гэсэн аль болох бага хэмжээний ган ашиглаж, байгаль орчинд үлдээх ул мөрийг багасгах зорилготойгоор их британичууд болон бусад үндэстний тэргүүлэх мэргэжилтнүүд хамтарч ажилласан байна. Жишээ нь, дээврийн тойргийг уян хатан торон сүлжээ ашиглан унадаг дугуйн хэлбэртэй хийсэн байна. Олон улсын шилдэг уран барилгач Притцкерийн шагналтан Заха Хадид усан спортын цогцолборын загварыг өнгө үзэмж төгс бүтээсэн. Усны долгионы дүрсийг агуулсан энэхүү шилдэг загвартай байгууламжийг Олимпийн хотхонд орж ирэнгүүт харагдах газар босгожээ.

• Олимпийн хотхоныг барихад ихээхэн хэмжээний барилгын материал тээвэрлэсэн. Тоосго, бетон зуурмаг, барилгын хог хаягдлын 50 хүртэлх хувийг тогтвортой аргаар зөөжээ. Стратфорд дүүрэг төмөр замын сүлжээний дагуу оршдог тул нийт барилгын материалын 57 хувийг галт тэргээр тээвэрлэсэн байна. Логистикийн менежер Петер Каммингс галт тэрэг тус бүр 75 ачааны машины ачаатай тэнцэхүйц хэмжээний материал тээвэрлэсэн гэж дурдав. Түүнчлэн 1950-иад оноос хойш ашиглахаа байсан усан сувгаар дамжуулж барилгын хог хаягдал тээвэрлэсэн нь мөн л тогтвортой тээврийн шийдэл байсан.

• Олимпийн хотхоны цэцэрлэгт хүрээлэнг байгуулах ажлыг ландшафтын уран барилгач Жон Хопкинс хүлээсэн билээ. Тэрбээр паркын загварын сэдлээ 1845 онд хатан хаан Викториягийн зарлигаар нийтэд зориулсан паркаас олж авчээ. Гэхдээ тэр үеийн түүхэн цэцэрлэгт хүрээлэнгээс арай ялгаатай. Байгаль орчинд ээлтэй бодлогыг шингээсэн, британичуудын цэцэрлэгт хүрээлэнгийн уламжлалыг сэргээсэн ногоон байгууламж бүтээжээ. Төрөл бүрийн бут, анхилам цэцэгс, таримал модтой энэхүү паркыг Олимпийн тоглолтод зориулсан ч британичуудын түүхэнд үлдэх бүтээл юм. Сонирхуулахад, Стратфордоос баруун урагш 130 км орших Хэмпширын мод үржүүлгийн талбайгаас хоёр мянга гаруй 20 настай суулгац тус хүрээлэнд авчирч тарьсан байна. Цэцэрлэгч Мартин Хиллер “Бидний энэ ажил ирээдүйд чиглэсэн бөгөөд хойч үедээ үлдээх бүтээлд хувь нэмэр оруулж буйд баяртай байна” гэж өгүүлсэн.

Лондон хотын эдийн засгийн хөгжил сул энэхүү дүүрэг өнөөдөр дэлхийд танигдахын сацуу британичуудын тогтвортой байдал, ногоон хөгжлийг хэрхэн бүтээж чадсаныг өгүүлэх хамгийн тод жишээ болж байна. ■

ХӨГЖИЛ

МӨНХ НОГООН

...Хүн төрөлхтөн өнгөрсөн түүхийнхээ хугацаанд олон шинэ бүтээл, амжилт ололт, техник технологийн дэвшил, хурдацтай хөгжилд хүрсэн боловч өдгөө байгаль дэлхий, хөрс, ургамлаа хайрлан хамгаалах, эргээд унаган байгаль руу тэмүүлэх болсон нь хүний төрөлхийн зөн, хүн байгальтайгаа хүйн холбоотой гэдгийн илрэл билээ...

“Номин констракшн” ХХК-ийн Маркетинг, худалдаа эрхэлсэн захирал Б.Хүрэлхүүтэй “River Garden” хотхоны онцлогийн талаар ярилцлаа.

-Танай компани “Ever green” гэсэн уриатайгаар өөрийн төслүүдийг хэрэгжүүлж байгаа юм байна. Энэ нь ямар учиртай юм бэ?

-Тийм ээ, “Номин коснтракшн” компани “Ever green” уриан дор “River garden” хотхоныг бүтээн байгуулж байгаа бөгөөд дараа дараагийн төслийн хувьд ч мөн энэ уриаг эрхэмлэнэ. “Ever green” гэдэг нь бидний амьдралын салшгүй хэсэг болсон байгаль, тэр дундаа нийслэлчүүдэд дутагдаж байдаг ногоон орчныг бий болгох зорилготой. Тиймээс хүний эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бэлэглэх “мөнх ногоон” орчныг билгэдсэн уриа юм.

Бид өөрсдийн хэрэгжүүлж буй төсөл бүхэнд ногоон байгууламжийг чухалчилж улмаар бусад ижил төрлийн хотхонуудаас ялгарна. Нэг үгээр хэлбэл, “Номин констракшн” компани ногоон хотхонуудыг бий болгох замаар улс орныхоо хөгжилд



ногоон ирээдүйг бий болгоход хувь нэмрээ оруулахаар зорин ажиллаж байна.

-Та манайх хотхондоо ногоон байгууламжийг байж болох дээд хэмжээнд нь бий болгоно гэлээ. "River garden"-ы нийт талбайн хэдэн хувь нь ногоон болох вэ?

-Хүн төрөлхтөн өнгөрсөн түүхийнхээ хугацаанд олон шинэ бүтээл, амжилт ололт, техник технологийн дэвшил, хурдацтай хөгжилд хүрсэн. Гэвч өдгөө байгаль дэлхий, хөрс, ургамлаа хайрлан хамгаалах, эргээд унаган байгаль руу тэмүүлэх болсон нь хүний төрөлхийн зөн, хүн байгальтайгаа хүйн холбоотой гэдгийн илрэл билээ. Тиймээс ч бид "Ever green" уриаг сонгосон юм. Энэ зорилтын хүрээнд бий болж байгаа эхний хотхон бол "River garden" юм. Уг хотхоныг ногоон хотхон гэж нэрлэсний учир нь нийт эзэмшил газрынхаа 80 орчим хувьд нь төрөл бүрийн мод, бут, сөөг, зүлэг бүхий ногоон орчин бий болгоно. Хотхоны оршин суугчид гэрээсээ гараад л ойн төгөлд зугаалж, ногоон зүлгэн дээр явж, нуурын эрэг дагуу амарч, өдөр бүр онгон, зэрлэг байгальд байгаа мэт таашаалыг мэдрэх боломжтой. Уг орчныг бүрдүүлэхийн тулд одоогоор бид 17 мянган мод, бут, сөөгийг хотхоны ойр орчимд тариад байна. Дээрээс нь дэлхий нийт ногоон хөгжлийг чухалчилж байгаа өнөө үед бид ч ялгаагүй эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг, дулаан алдалт хамгийн багатай цонх гээд аль болох эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхийг зорьж байна. Түүнчлэн ногоон байгууламж нь утааг багасгаад зогсохгүй тоосжилтыг дарах нэг арга юм. Мөн бид өөрсдийн хийж байгаа ажлаараа бусад ижил төрлийн төсөл хэрэгжүүлэгчдийг "ногоон" болоосой гэж уриалж байна.

-"River garden" хотхоны байршил, ерөнхий бүтэц зохион байгуулалт, төлөвлөлтийн давуу тал юу вэ?

-"River garden" хотхон нь нийтдээ 6.5 га эзэмшил газар бүхий "Town house", "Penthouse", "Duplex", "Apartment" гэсэн төрөл бүхий 380 орчим айлын тансаг зэрэглэлийн хотхон бөгөөд Богдхан уулын өвөрт, Хатан Туул голын хөвөөнөө дээр хэлсэн ногоон орчноос гадна хүрхрээ бүхий хоёр ч нуур, хотхоны урд хэсгээр модон дундуур хэрсэн явган зам, гүйлтийн болон унадаг дугуйн зам, мөн амралтын талбай, хүүхдийн тоглоомын болон хөлбөмбөг, гар бөмбөг, сагсан бөмбөг, софт теннис, скейт гулгуурын талбай зэрэг хотхоны гадна өнгө төрхийг чимэх зүйл олон бий. Харин хотхоны төв хэсэгт үйлчилгээний төв байрлах ба уг төвд "Номин супермаркет", өөр өөрийн өвөрмөц онцлог бүхий ресторан, pub, Coffee shop, VIP Lounge, boutique shop, банкны салбар гээд бүх төрлийн үйлчилгээ явуулах төв байрлана. Мөн 25 метрийн урттай гурван зам бүхий усан бассейн, аэробек, фитнесс клуб, хөгжмийн дугуйлан, иог, бүжгийн танхим, массаж, Spa салон зэрэг эрүүл мэндийн үйлчилгээнүүд багтсан байгаа. Энэ утгаараа манай хотхоны оршин суугчид хотхон дотроо цагийг зугаатай, үр бүтээлтэй өнгөрүүлэх хэрэгцээт бүхий л үйлчилгээг нэг дороос авах бололцоотой юм. Орчин үеийн завгүй хүмүүс зөв амьдралын хэв маягийг эндээс мэдрэх болно.

-Байршлын хувьд ямар давуу талтай вэ?

-Байршлын хувьд хотын төв цэгээс ердөө гурван км-т байрлах бөгөөд Хүүхдийн парк, Их тэнгэрийн ам, Зайсан толгой, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Гольфын талбай, "Sky Resort" зэрэг амралт зугаалгын газруудтай ойрхон байрлаж байгаагаараа давуу. Түүнчлэн "American school", "International School" ч мөн дэргэд нь бий.

Хотхоны төлөвлөлтийн хувьд авч үзвэл зүүн хэсэгтээ таун хаусууд, хотхоны төв хэсэгт дороо үйлчилгээний төв бүхий хотхоны гол цэг болох 14 давхар "River tower, баруун хэсэгтээ баруун тийш, урагшаа хойшоо харах боломж бүхий нэг нь нөгөөгөөсөө ялгагдах онцлогтой, байрлал бүхэн нь өөрийн давтагдахгүй шинж төрхтэй сууцууд төлөвлөгдсөн байгаа. Орчны харагдах байдлыг нарийн бодолцож хийсэнд төлөвлөлтийн гол давуу тал оршино.

-Төсөлд олон орны компани оролцож байгаа гэж сонссон. Энэ талаар сонирхуулахгүй юу?

-"River garden" төсөлд Монгол, Итали, Герман, Япон, Солонгос зэрэг олон орны компани, зураг төслийн болон инженер техникийн ажилтнууд оролцож байна. Тухайлбал, архитектурын зураг төсөл, интерьерийн шийдлийг Монгол, Итали, Солонгос архитектур, дизайнерууд хамтран гүйцэтгэсэн. Орчны болон нуурын орчмын тохижилтыг байгалийн маягаар Японы туршлагатай баг гүйцэтгэж байна. Барилгын гүйцэтгэлийг Монгол болон Герман, Солонгосын компаниуд хийж байгаа. ■

ОЮУТОЛГОЙ

ИРЭЭДҮЙН ХАДГАЛАМЖ

Б.АЛТАЙ

...Азийн хөгжлийн банкны ахлах эдийн засагч Яан Ханзен “Дэлхийн эдийн засгийн уналтаас үл хамааран, Оюутолгой төслийн үйлдвэрлэл төлөвлөгөөний дагуу эхэлбэл Монгол улсын ДНБ-ий хэмжээ энэ онд 11, ирэх онд 12 хувиар өснө” гэж тэмдэглэсэн юм...

ХХ зууны бүтээн байгуулалтаар уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийг цоллодог. Онцлох шалтгаан нь Монголын эдийн засгийг улсын төсөвтэй нь, хүн ардыг нь хөгжил дэвшилтэй нь энэ зуунд хөтөлж ирсэн зүтгүүр учраас тэр. Тиймээс Монгол улсын төсөв өнгөрсөн хугацаанд тус үйлдвэрээс, үйлдвэр нь дэлхийн зах зээлд буй зэсийн үнээс ихээхэн хамааралтай явж ирсэнийг хүн бүхэн мэднэ. Харин Оюутолгой төслийн өгөөжийг өнөөдөр зөвхөн тааж, таамаглах байдлаар төсөөлж байна. Түүнээс шууд тэдэн хувийн ашигтай гэх барьцтай тооцоо алга байгааг УИХ-ын нэр бүхий гишүүд анх гаргаж ирсэн. Түүний мөрөөр хөрөнгө оруулалтын гэрээний 34 хувийг нэмэх зарчим Уул уурхайн яамнаас Засгийн газрын түвшинд хүрч, гурван ч удаа төслийн талтай албан бичиг солилцож, хэд хэдэн удаа уулзалт зохион байгуулсан гэж салбарын сайд Д.Ганхуяг мэдэгдлээ. Үүнээс гадна ирэх оны төсөвт “Оюутолгой” төслийн хөрөнгө оруулалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар 445.8 тэрбум төгрөгийн нэмэлт орлого төвлөрүүлэхээр тооцжээ. Монголын эдийн засагт Оюутолгойн орд ямархан жинтэй болохыг мэдэрсэн өдөр хоног шувтарч, шинэ он ойртсоор. Монголын нийгэм, эдийн засгийн мөнхийн сэдэв нь тус төсөл болох шинжтэй.

Харин XXI зууны Монголын бүтээн байгуулалтаас эдийн засагт томоохон түшиц болох, дэлхийд жагсах зэрэглэлээр нь Оюутолгой төслийг нэрлэх боллоо. Дээрх хуучин, шинэ хоёр зууны бүтээн байгуулалтын аль аль нь Монголыг дэлхийд, дэлхийг Монголд нээн таниулсан “аж үйлдвэрийн хэл”. Өнөөдрийн байдлаар Оюутолгой төсөл олборлолтын үйл ажиллагааны эхний үе шат болох ил уурхайгаас хүдрээ олборлож эхлээд байна. Баяжуулах үйлдвэрээ нээгээгүй ч бараг л бэлэн болсон аж. “Үйлдвэрлэл эхлэхэд ойролцоогоор 50 хоног дутуу байна” хэмээн тус компанийн Ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал Камерон МакРей хэлсэн юм. Тэрбээр Нэгдүгээрт, Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг хамгаалах шаардлага байна. Хөрөнгө оруулалтын гэрээ бол Монголын эдийн засгийн сүүлийн гурван жилийн өсөлтийн суурь болж ирсэн. Энэ гэрээ дотоодын олон хүнд бизнес эхлүүлэх гүүр болсон. Хоёрдугаарт, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд анхаарах хэрэгтэй байна. Одоо бидэнд тодорхой хууль алга. Гурав дахь асуудал нь Монголд маш тодорхой, хөрөнгө оруулагчдыг татахуйц уул уурхайн хууль хэрэгтэй байна” гэв.

Азийн хөгжлийн банкны ахлах эдийн засагч Яан Ханзен “ Дэлхийн эдийн засгийн уналтаас үл хамааран, Оюутолгой төслийн үйлдвэрлэл төлөвлөгөөний дагуу эхэлбэл Монгол улсын ДНБ-ий хэмжээ энэ онд 11, ирэх онд 12 хувиар тус тус өснө” гэж тэмдэглэсэн юм. Гурван жилийн өмнө Монгол улсын Ерөнхий сайд асан С.Баяр “Оюутолгой төсөл дор хаяж 50 жилийн хугацаанд хэрэгжих төсөл” хэмээн гэрээнд гарын үсэг зурах ёслолын үеэр хэлж байв. Гэтэл ОУВС Оюутолгой ордоос монголчуудын хүртэх ашгийг 30 жилийн хугацаатайгаар тооцсон. Түүнээс хойш хөрөнгө оруулалтын гэрээ гурван төрийн нүүр үзэж байна. Энэ хугацаанд Засгийн газар гурвантаа солигдож, шинэ төр төвхнөөд байна.

Монголын эдийн засагт эргэлдэж буй гурван төгрөг тутмын нэг нь Оюутолгойнх гэгддэг. Өөрөөр хэлбэл, Оюутолгой төслийн нийт мөнгөн урсгалын 55-70 хувь нь Монгол улсад үлдэнэ гэх. Эдийн засгийн хөгжлийн яамнаас танилцуулсан “Монгол улсын эдийн засгийн 2013 оны төсөөлөл”-д ирэх онд Оюутолгой төслийн олборлолт эхэлж, 556 мянган тонн зэсийн баяжмал экспортлох таамаг ч бий. Дэлхийд алт, зэс, мөнгө, молибдений нөөцөөрөө эхний гуравт багтах уг ордоос монголчууд 70 хүртэлх хувийн ашиг хүртэнэ гэж ОУВС-гийнхан төсөөлсөн. Мөн 2020 оноос 34 хувийн ногдол ашиг хүртэх учиртай. Мэдээж, »

ногдол ашгийг өгөх хугацаа нь наана цаана байхыг үгүйсгэх аргагүй гэж Камерон МакРей учирласан юм. Гүний уурхай ашиглалтад ороход хамгийн наанадаж л найман жилийн хугацаа шаардлагатай аж. Тиймээс ирэх 2020 оноос бус түүнээс цааших хугацаанд Оюутолгойн ногдол ашиг өгөөжөө өгч таарах нь. Нэг үгээр хэлбэл, 34 хувийн ногдол ашиг нь урт хугацаатай Монгол улсын ирээдүйн хадгаламж гэж хэлж болно.

Монголын уул уурхайг "хоёр хөлтэй" гэж үзвэл, нэг нь гажиж байгааг хөрөнгө оруулагч талынхан учирласан. Энэ нь зөвхөн Өмнийн говьд буй Оюутолгойг бус Монголын уул уурхайн салбарыг нийтэд нь эрсдэлд оруулж байгааг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийнхан учирлалаа. Үүнээс улбаалан хөрөнгө оруулагчид Монголоос зайгаа барьж эхэлжээ. Олон улсын хөрөнгийн биржид буй Монголоор "овоглосон" уул уурхайн компаниудын хувьцааны ханш уруудаж, нэр хүндээ алдах болов. Урт хугацааны томоохон мөнгөний хэрхэн халгаатай болохыг гадарлаж л байлтай, УИХ-ын зарим гишүүн. Гараанаас барианы зүг эргэсэн хурдан морьдын тоосонд монголчууд даруулж хийморь лундаагаа сэргээдэг. Түүнээс эргэсэн морьдын хойноос шороо цацаж, чулуу шидэх хэлтгий заншил үгүй. Гэтэл эдийн засагт өгөөжтэй, улс орны хөгжилд амин чухал уурхайн хөрөнгө оруулалтын гэрээгээр оролдох нь хэр үр дүнтэй байх бол.

Ашигт малтмалын газрын тооцсон таамгаар ордын нийт ашгийн 68



Оюутолгой. Тэгвэл, эдийн засгийн асуудлыг "түлхүүрдэх" хөшүүрэг нь тус ордоос хүлээж буй уурхайн өгөөж болохыг учир мэдэх хүмүүс өгүүлсээр байна. Гэтэл улс төрчид учрыг мэдэж, хужрыг нь тунгаах бус төслийн хөрөнгө оруулалтын гэрээгээр улс төр хийх нь дэлхийн соёлтой нийцсэнгүй, түүнээс урсгал ч алсрах тийш аядав. Хүлээж буй хөгжил, тооцож буй төсвийн орлого ч сох дутах шинжтэй болж байна.

Гараанаас эргэчихсэн хурдан морьдыг зогсоож чаддаггүйтэй адил нэгэнтээ баталсан гэрээний хойноос чангааж зүүгдэх нь Монголын эдийн засагт, бидэнд ойртон буй хөгжилд хувийг Монголын төр, монголчууд хүртэх юм байна. Харин Оюутолгой компанийн өөрийн судалж байгаагаар монголчууд нийт ашгийн 74 хувийг хүртэнэ гэсэн өндөр тоо бий. Товчхондоо, манайх төслийн бүтээн байгуулалтад ямар ч хөрөнгө, хүч зарахгүйгээр уурхайн нийт ашгийн дийлэнх хувийг хүртэж байгаа нь

бодох л асуудал. Төсөл дагасан нийт мөнгөн урсгалын 71 хувь нь Монголын эдийн засагт шингэж байгааг дахин тэмдэглэе. Үүний хүчээр Монголын эдийн засаг өнгөрсөн хугацаанд 17 хувийн өсөлт далласан. Ирэх онд эдийн засаг 12-14 хувиар өснө гэсэн таамгийг Монголбанкнаас дэвшүүлээд байна. Дэлхийн банкнаас ч Монголын эдийн засгийг тун өндөрөөр төсөөлөх аж. Тус банкны Монголыг хариуцсан менежер Корали Геверс "Монгол ашигт малтмалын баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулж эхэлснээр эдийн засагт томоохон тэлэлт бий болж эхэллээ. Оюутолгойн зэс, алтны ордын бүтээн байгуулалттай холбоотой ДНБ-ий өсөлт өнгөрсөн онд 17 хувьд хүрсэн. Харин энэ оны өсөлт саарсан ч 10-хувиас дээш хувьтай байна. Монголын эдийн засаг урт болон дунд хугацаандаа өөдрөг байна" гэж онцлов.

Өнөөдрийн байдлаар Оюутолгойд 11.956 монгол хүн ажиллаж байна. Тэд ажилтай, орлоготой, аж амьдралаа авч явж байна. Мөн өнгөрсөн хугацаанд Оюутолгой төслөөс 837 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг Монголын компаниудад нийлүүлжээ. Үүний дүнд ханган нийлүүлэлт, туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагааны цар хүрээ ч өргөжин тэлсээр. Дэлхийн хэмжээний хөрөнгө оруулалтын төслөөс хамаарсан үйлдвэрлэл тэлж, бүс нутгийн хөгжил өнгө төрхөө 36 сарын дотор 180 градус хувиргав. Монголын Засгийн газарт гуравхан жилийн дотор 803 сая ам.долларыг зөвхөн татварын орлогоор өгсөн нь хөрөнгө оруулалтын гэрээний үр өгөөжийг тоогоор илэрхийлэх том хариулт болж байна. 803 сая ам.доллар гэдэг нь зургаан жилийн хугацаанд Монголын хүүхэд бүрт сард 20 мянган төгрөг олгох хэмжээний мөнгө.

Монголын эдийн засагт 6.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг авчирсан Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ гурван нас хүрлээ. Хөгжилд хөтөлж, хамтдаа бүтээсэн 36 сард төслийн бүтээн байгуулалт жигдэрч, уурхайн бүтээн байгуулалт шуударч явна. Дэлхийд тамгатай тус ордоос дэвжин дээшлэх ирээдүйг хүн бүхэн хүсэн хүлээж буй. ■

АШИГТ МАЛТМАЛ-97

"МАЛГАЙ" ХУУЛИЙН ЭРС ШИНЭЧЛЭЛ

Б.АЛТАЙ

...Монгол улс Ашигт малтмалын тухай хуулиа хэлэлцэх гэж байна. Уул уурхайн арвин нөөц баялагтай, Азийн ирээдүйн "бар" гэгдэх Монгол улс "малгай" хуулиндаа дахиад л "мэс засал" хийхээр түгшиж сууна...

Уул уурхайн салбарыг зангидах "малгай" хуулийн төслийг тун удахгүй хэлэлцэх гэж байна. Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Уул уурхайн яамнаас хамтран шинэ хуулийн төслийн нээлттэй сонсголыг энэ сард "Иргэний танхим"-д зохион байгуулах аж. Өөрөөр хэлбэл, 20 жилийн хугацаанд дөрвөн удаа төрөл арилжсан Ашигт малтмалын тухай хууль энэ онтой зэрэгцэн хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг болохоор гарааны зүг хөдөллөө. Ирэх оны төсвийн төслийг УИХ батлах үе шаттай зэрэгцэн Ашигт малтмалын тухай хуулийн хэлэлцүүлэг "Иргэний танхим"-аас УИХ-ын чуулганы танхимд өрнөх нь. Уул уурхайгаар улс төр нь "өвчилж", эдийн засаг нь "баялгийн хараал"-ын шинж тэмдэгтэй болоод буй гэх Монгол улс эдийн засгийн тэргүүлэх салбартаа хэмжээ хязгаарыг нь тогтоох, хуулийг ийн хэлэлцэх нь ээ. Нийгэм ч тогтвортой, тодорхой, стандарт бүхий шинэ хуулийг нэхсээр өдийг хүрлээ.

Цаг үеийн шаардлага, хөгжлийн төлөөс, нийгмийн захиалга, улс орны эдийн засгийн эрх ашгийн төлөө Ашигт малтмалын тухай хууль шинэчлэгдэх гэж байгаа нь энэ. Геологи, хайгуул, нөхөн сэргээлт, олборлолт, үйлдвэрлэл гээд уул уурхай гэсэн "багц" нэрийн дор Монгол улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчинг шинэ давалгаа түрэх нь. Алт, зэс, нүүрсээ хэрхэн нээн олж, хэчнээн хувийг нь төр болон хөрөнгө оруулагч эзэмших, хэд орчим хувийг татварт авах гээд бүрхэг асуудал бүхэн тунгалагших үгүйг одоогоор хэлж таашгүй. Тиймээс долоо хэмжиж нэг огтлох Ашигт малтмалын тухай хуулийн эрс шинэчлэл түүхэндээ шинэчлэлийн Засгийн газраар, түүнийг тэргүүлэгч Н.Алтанхуягаар "овог" хийж амьдарна гэсэн үг. 1996 оны М.Энхсайханы Засгийн газрын туг болсон бүтээл болох 1997 оны Ашигт малтмалын тухай хуультай агаар нэг юм.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт геологи уул уурхайн салбарын ирэх дөрвөн жилийн зорилтоос сонирхуулъя. Эрдэс, баялгийн салбарын эскпортыг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэх, бичил уурхайгаас ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах, газрын тосны



үйлдвэр барих, Тавантолгойн ордыг төрийн мэдэлд тогтоон барих гээд Уул уурхайн яамны ирэх дөрвөн жилийн баримжааг харж болох нь. Гадаадын хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллах, уул уурхай, эрчим хүч, газрын тосны салбарт өмнө нь байгуулсан Тогтвортой байдал, хөрөнгө оруулалт, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг дахин судалж, холбогдох өөрчлөлтийг ч хөрөнгө оруулагч талтай харилцан тохиролцохоор шинэчлэлийн Засгийн газар ажиллах аж. Өнөөдрийн байдлаар манайд Тогтвортой байдлын дөрвөн гэрээ, хөрөнгө оруулалтын нэг гэрээ / Оюутолгой төсөл/, бүтээгдэхүүн хуваах 15 гэрээ үйлчилж байгаа аж. Энэхүү Засгийн газрын зорилт хэрэгжих үндэс нь шинээр хэлэлцэн батлах Ашигт малтмалын тухай хуулиас ихээхэн хамаарах юм. Нэг үгээр хэлбэл, уул уурхайн салбарыг хэрхэн хариуцлагатай, ухаантай хөгжүүлэх нь тус хуулиас шууд шалтгаална гэж хэлж болно.

Ашигт малтмалын тухай хуулийг 1988, 1994, 1997, 2006 онд шинэчлэн найруулсан. Уул уурхайн яамны дэд сайд О.Эрдэнэбулганаар ахлуулсан ажлын хэсэг Ашигт малтмалын тухай хуульд оруулах яам, агентлагийн саналыг нэгтгээд Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхэд бэлэн болоод байгаа аж. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан “Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга” нь геологи, уул уурхайн салбарын тулгуур учраас нэлээд чамбай хандаж байгаагаа салбарын сайд нь “Ил тод уул уурхай” уулзалтын үеэр тэмдэглэсэн юм. “Бид урагш итгэлтэй алхахын тулд “цоорхой” хуульгүй, тов тодорхой, нээлттэй эрх зүйн орчинтой байх ёстой” хэмээн Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн тэргүүн Д.Дамба тэмдэглэсэн удаатай. Ирэх өдрүүдэд Ашигт малтмалын тухай хуулиас гадна Газрын тосын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар Уул уурхайн яамнаас ажлын хэсэг бүрдэжээ.

Ашигт малтмалтын хуулийн талаар хуульч Д.Инжинаш “Төрийн бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомж, стандартыг боловсруулах, холбогдох судалгааг хийх, салбар салбараар хэлэлцүүлэх, батлах, төрийн бодлогод нийцээгүй хууль тогтоомж батлахгүй байх, хэрэгжилтийг хангах, бодлого тогтвортой баримтлах, хянах, үнэлэх, боловсронгуй болгох шаардлагатай” хэмээн тайлбарласан юм. Манайх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үед геологи, уул уурхайн салбарын эрх зүйн орчныг 1988 оны Газрын хэвлийн тухай хуулиар голлон зохицуулж байсан. Харин ардчилалтай золгосон 1990-ээд оноос 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн тунхаг заалтаар өнөөдрийн Монголын эдийн засаг бэхжсэн болохыг тус салбарынхан онцлох аж.

Ашигт малтмалын тухай хууль нь Газрын хэвлийн тухай хууль гэж нэрээ өөрчилж магадгүй бололтой. Учир нь шинэ хуулийн төслийг хоёр нэрээр УИХ-д болон Иргэний танхимд хэлэлцүүлэх аж. Тиймээс шинэ, хуучны заагт Ашигт малтмалын тухай хуулийг хэлэлцэх юм байна. Тус хууль нь зөвхөн нэрээ өөрчлөхөөс гадна утга, агуулгын хувьд ч нэлээд өөрчлөгдсөн болохыг тус хуулийн төсөлтэй танилцсан хүмүүс хэлж байв. Өнөөдрийн байдлаар манай улсад төрийн өмнөөс үүрэг гүйцэтгэх Монгол улсын бие даасан 494 хууль, 1193 УИХ-ын тогтоол, Монгол улсын олон улсын гэрээ 137, 142 Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр үйлчилж байна. Гурван жилийн өмнө /2009 он/ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг түр зогсоох тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэж байв. Тэгвэл өнөөдөр уул уурхайн салбарын “малгай” хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар зүтгүүлэх гэж байна. Залхтал хүлээсэн гэж хэлж болох Ашигт малтмалын тухай хууль улсын хөгжилд хэр ээлтэй, амьдралд хэрхэн нийцтэй хууль болохыг цаг хугацаа тод харуулах нь лавтай. Монгол улс Ашигт малтмалын тухай хуулиа хэлэлцэх гэж байна. Уул уурхайн арвин нөөц баялагтай, Азийн ирээдүйн “бар” гэгдэх Монгол улс “малгай” хуулиндаа дахиад л “мэс засал” хийхээр түгшиж сууна. ■

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

БИД МИКРОФОНОО НЭЭЛТТЭЙ ТАВЬДАГ



...Матт Юки нь Өмнөд Америкт арав гаруй жил ажилласан туршлагатай сэтгүүлч бөгөөд эдийн засгийн чиглэлээр бичиж нийтэлж байжээ. Өдгөө тэрбээр Канадад төвтэй “Майнинг Лидерс” хэмээх уул уурхайн цуврал номын редактораар ажилладаг. Тус номыг уул уурхай хөгжиж байгаа орнуудаар тусгайлан гаргадаг. Тиймээс “Mining Leaders 2013” Монголд зориулсан номыг өнгөрсөн сарын 29-нд Хонконгд болсон “Монголын хөрөнгө оруулалтын дээд хэмжээний уулзалт”-ын үеэр тараасан билээ...

-Номынхоо онцлогын талаар товчхон танилцуулахгүй юу?

“Майнинг Лидерс” нь уул уурхайн салбарын хувьд хөгжиж буй зах зээлтэй орнуудад анхаарлаа голчлон хандуулдаг, жил тутмын ном юм. Номын тухайд уул уурхай, санхүү зэрэг тухайн улсын эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч салбарын удирдах албан тушаалтнуудын санаа бодлыг тусгахын зэрэгцээ ярилцлага, анализ, дүн шинжилгээг оруулж өгсөн 130-140 хуудас бүхий бүтээл байгаа. Бид өнгөрсөн гурван жилийн туршид Өмнөд Америк тэр дундаа Колумба, Бразил, Перу, Мексик зэрэг оронд гол анхаарлаа тавьж ирсэн бөгөөд саяхнаас шинэ зах зээл рүү хараагаа чиглүүлж эхлээд байна. Монгол бол бидний номоо бэлтгэж байгаа тав дахь улс ч Азидаа анхны улс нь юм.

-Монголд сүүлийн үед гаднын хэвлэлүүд олон гарах болсон. Танай өрсөлдөгчдөөсөө ялгарах онцлог юу вэ?

-Товчхон хариулахад, бидний номыг хүмүүс хэрхэн хүлээж авахыг л харъя гэж бодож байна. Бусад бүтээлийн хувьд ерөнхий эдийн засгийн хүрээг хамардаг. “Нью Йорк Таймс”, “Блүүмберг” зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл сар, өдөр минутаар нь тухайн улсын мэдээллийг хүргэж байдаг.

Харин бидний хувьд аливаа улс орон тэр дундаа уул уурхайн салбарт хөрөнгө оруулахыг хүсэгчдэд тухайн улсын зах зээлийн голлох тоглогчид хэн болох, ямар томоохон төслүүд байгаа талаар ул суурьтай мэдээлэл өгөх буюу нэгдүгээр эх сурвалж байхыг зорьдог. Бид уулзаж ярилцсан хүмүүсийнхээ зургийг оруулдаг учир аливаа хурал цуглаанд оролцох үед хэн нь хэн бэ гэдгийг шууд хараад таних боломжийг олгодог. Олон улсын уул уурхайн салбарынхан болон хууль эрх зүй, санхүүгийн салбарынхны зах зээлийн талаарх санал бодлыг харуулдгаараа нэг ёсны форумын үүрэг гүйцэтгэхийг хичээдэг.

Зарим хэвлэлд монголчууд өгсөн мэдээллээ эргэн хянаж засахыг оролдох хандлага байдаг талаар бичдэг. Бидний хувьд тухайн салбарыг олон талаас нь харуулах үүднээс бусад салбарын хүмүүст ч тэр микрофоноо нээлттэй тавьж өгөхийн сацуу өөрсдийн дүн шинжилгээг оруулдаг. Мөн бидний анхаарал биеэ даасан төслүүд дээр ихээхэн төвлөрдөг. Түүнчлэн олон эх сурвалжаас бүрдсэн статистик үзүүлэлт, график, газрын зураг зэрэг тоон мэдээлэл ч орсон байгаа. Бид номоо хөрөнгө оруулахад туслах чухал хэрэгсэл, тэр дундаа уул уурхайн салбарын лавлах байх зорилгоор гаргадаг гэж хэлж болно. Энэ төрлийн тусгайлсан мэдээллийн

эх сурвалж байгаагүй тул өнгөрсөн хугацаанд Колумб, Перу зэрэг улсаас өндөр үнэлгээ авсан л даа.

-Энэ жил шинэ зах зээл буюу Монгол улсад тулгуурлан ном бэлтгэх болсны учир юу вэ?

-Энэ шийдвэрийг нэлээд эрт гаргачихсан байсан. Томоохон гүрнүүдээс ч илүү эдийн засгийн өсөлттэй явж байгааг бид бүгд харж байна. Энэ улс бол уул уурхайн огцом өсөлтөөр эдийн засаг нь цэнэглэгдэж яваа орон. Эрэл хайгуул төдийлэн далайцтай хийгдээгүй энэ оронд дэлхийн хэмжээний Тавантолгой, Оюутолгойн орд газар байна. Мөн тийм хэмжээний нөөлтүүдийг цаашид ч хийх асар их боломж байна. Энэ нь манай номын хувьд уул уурхайн салбар дахь гадаад, дотоодын хуучин тоглогчид болон шинээр орж ирж буй компаниуд мөн Монголын алслагдмал хэсгүүдэд эрэл хайгуул явуулж буй хайгуулынхан зэргийг багтаасан олон талын мэдээлэл өгөх сайхан боломж гэж харж байгаа.

-Та уул уурхайн чиглэлээр цөөнгүй оронд ажиллаж байсан туршлагатай сэтгүүлчийн хувьд Монголын хурдацтай өсөлтийг хэрхэн харж байна вэ?

-Миний өмнө нь очиж байсан газруудтай Улаанбаатарыг харьцуулахад их өөр байсан. Асар өөрчлөн байгуулалт явагдаж байгааг анх хараад л ойлгосон. Хотын энд тэндгүй үл хөдлөх хөрөнгө сүндэрлэж, хаашаа л харна хөл хөдөлгөөнийг ажиглаж байв. Говь нутаг руу жолоо залахад, замд тааралдсан гэрүүд гаднаа нарны таваг, салхин сэнстэй байх жишээтэй. Хөгжиж буй эдийн засагтай орны хувьд маш их боломж байна. Нүүрсний нөөцөөрөө Саудын Араб эсвэл Төв Азийн Кувейт гэж Монголыг нэрлэх нь бий. 1970,1980-аад оноос эхлэлтэй Катар эсвэл Абу Даби зэрэг орны эдийн засгийн өсөлтийг бид мэднэ. Тэднийг эргэж нэг шинжээд, Монгол руу харвал ялгаа нь тод байна. Танай улс ашигтай байршил дээр оршдог. Нэг үндэстэн давамгайлсан, бичиг үсэг тайлагдсан байдлаараа өндөр түвшинд юм. Түүнчлэн энэ улсад ямар ч үндэстэн, бүс нутаг гэх мэт хэсэг бүлгийн хоорон дахь хурцадмал зөрчил алга. Хамгийн чухал нь та бүхэнд Ардчилал бий. Гэвч миний ирснээсээ хойш ажиглаж байгаагаар улс төр л голлох хүчин зүйл нь байна даа.

-Өмнө нь танай номонд орж байсан орнуудтай харьцуулахад Монгол ямар талаараа хөрөнгө оруулагчдад илүү бас дутуу санагдаж байгаа бол.

-Улс орон бүхэн уул уурхайн голлох орон байж чаддаггүй. Тухайлбал, Колумб улсын хувьд дотоодын үймээн самуун ихтэй бөгөөд одоо л намжиж эхэлж байна шүү дээ.Тус улс бол Монгол шиг харьцангуй бага судлагдсан орон. Харин Бразил улсын хувьд уул уурхайн хөгжил нь харьцангуй өндөр түвшинд хүрсэн ч өргөн уудам газар нутаг нь асуудал дагуулдаг. Тус улсад эрэл хайгуулын ажил одоо ч хийгдсээр байна.

Монголын хувьд дэлхийн хэмжээний томоохон ордууд байна. Тэгвэл Бразил улсын хувьд хэдий судлагдаагүй газар олонтой ч ашигт малтмалын нөөц тухайлбал, алт нэг хэсгээс нь олдлоо гэхэд хүн амын нягтаршил ихтэй. Эсвэл Африк-Колумбийн уугуул иргэд олноороо амьдардаг бүс нутаг байх жишээтэй. Нийгмийн зүгээс энэ асуудалд ихээхэн эсэргүүцэл үзүүлдэг талтай. Харин Монголын хувьд хүн ам нь сийрэг улмаар таруу суурьшсан тул нийгмийн хандлага нь ч арай өөр юм. Харин баялгийн төлөөх үндсэрхэг үзэл нэг талаар ихээхэн анхаарал татсан асуудал.

-Хөрөнгө оруулалт болоод Ашигт малтмалын хөгжилд хууль дүрэм ойлгомжтой, тодорхой байх чухал. Энэ талаар юу олж харсан бэ?

-Колумб Ашигт малтмалын тухай хуулиа дахин боловсруулж, зөвшөөрөл болон эзэмшлийн эрхийг шалгах шинэ агентлаг бий болголоо. Тэдний хувьд газар нутгийн тал дээр Монголтой ижил төрлийн асуудалтай байсан юм. Энд Перу улсыг мөн жишээ татаж болно. Тус улс 1980,1990-ээд оны үед уул уурхайд ихээхэн ээлтэй хууль гаргасан байдаг. Одоо уул уурхайн тэсрэлт болж таваарын ханш өсөж эхлэнгүүт Засгийн газар Гэнэтийн ашгийн татвар нэрийдлээр уул уурхайн компаниудын татварыг нэмэгдүүлэхийг оролдож байна. Бразил өнөөдөр ашигт малтмал ашигласны төлөөх төлбөр ногдуулах зарчим, уул уурхай ашиглахтай холбогдсон хуулиа өөрчлөхөөр бэлтгэж байна. Перу тэргүүлэгч уул уурхайн компаниудтайгаа хамтран Гэнэтийн ашгийн татварын талаар нээлттэй хэлэлцсэн. Тус орны хувьд зэс, алтны өндөр ханшаас хангалттай ашиг хүртэхгүй байна хэмээн бодож байв. Гэвч хэлэлцээрийн үр дүнд Засгийн газар нэг тэрбум ам.долларын нэмэлт орлогыг бүрдүүлж чадсан. Энэ бүхэн уул уурхайн компаниуд болон хувийн хэвшлийнхний хэлэлцүүлгийн дүнд шийдэгдсэн байдаг.

Харин Монголын хувьд асуудал тэр бүр хэлэлцүүлэг, зөвлөлгөөний түвшинд орж ирдэггүй юм шиг санагдсан. Би сэтгүүлч хүний нүдээр харахдаа Монголыг хууль баталчихаад дараа нь тухайн хуулийнхаа суурин дахь ан цавыг анзаарч эхэлдэг юм уу гэж анзаарсан. /Энд Урт нэртэй хуулийг хэлж болно/. Эсвэл гэрээ хэлэлцээр хийчихээд жил ч болоогүй байхад эргэн сөхөж эхлэх жишээтэй. Жинтэй хөрөнгө оруулалт л биш бол олон төсөл эргэлтэд орохгүй хэвтсээр байдаг. Хөрөнгө оруулагчдын зүгээс эдгээр асуудалд ихээхэн шүүмжлэлтэй ханддаг.

-Монгол орноор дахин дугаар гаргах төлөвлөгөө бий юү?

-Бид шинэ зах зээл рүү нэвтрэх тоолондоо дараагийн жил нь дахин номоо гаргадаг. Энэ нь тухайн зах зээлдээ байр сууриа улам бататгахын зэрэгцээ цаг хугацааны явц дахь өөрчлөлтийг ажиж, илүү нэгдсэн ойлголттой болж, хөгжих боломж байдаг. Бусад оронд гаргаж байсан хоёр болон гурав дахь дугаартаа эрхлэгчийн зүгээс олж харсан шинэ онцлогуудыг тусгаж өгсөн байгаа. Монгол улсаар гаргасан эхний дугаартаа тэгж чадаагүй ээ. Гэхдээ ирэх жилүүдэд номоо утга агуулгын хүрээнд улам баяжуулна гэдэгт итгэлтэй байна.

ТЭРБУМТНЫ ТҮҮХ

ТЭРБЭЭР БИЗНЕСИЙГ УРАН БАРИЛГАТАЙ ЗҮЙРЛЭДЭГ

Х.АНАНД

...Түүний үндсэн хөрөнгө 2.3 тэрбум ам.доллар. Улсын “халаасанд” оруулсан татвар хийгээд дансан дахь мөнгөнийхөө хэмжээгээр Монголдоо тэргүүлэгч. Зарим нь түүнийг маш завгүй, үргэлж л шинийг эрэлхийлж, нэгээс нөгөө бизнесийг “ургуулахаар” гүйж явдаг хэмээн үнэлдэг. Харин зарим нь “Эх орноо хятадуудад худалдсан. Одоо эзэмшиж байгаа MCS группынх нь 75 хувь нь Хятадын мэдлийнх” гэдэг...



Фотог Ү.Одбаяр

Хүн бүр амжилтад хүрч, баян тансаг, их мөнгөтэй болохыг хүсдэг. Гэхдээ хүн төрөлхтний цөөхөн хувь нь л энэ мөрөөдлөө биелүүлж чаддаг. Өдгөө дэлхий дээр тэрбум ам.долларааар хэмжигдэх хөрөнгөтэй 2160 хүн байгаа гэсэн тоо бий. Гаднын тэрбумтнуудын хувьд цөөнгүй нь их хэмжээний өв хөрөнгөө уламжлах болон олон зуун жилийн хөдөлмөрийн үр шимээ хүртэгсэд. Харин Монголд жил ирэх тусам олуулаа болж буй үндэсний хөрөнгөтөн, тэрбумтнууд бол ардчилал гарснаас хойших цөөхөн жилд мэндэлсэн бизнесмэнүүд. Тэд гэнэтийн аз, ид шидээр энэ амжилтад хүрээгүй нь лавтай. Тиймээс бид Монголын тэрбумтан буюу эх орныхоо хөгжлийн зүтгүүр болсон үндэсний хөрөнгөтнүүдийг танилцуулж байна. Манай сэтгүүл “Тэрбумтнуудын түүх” булангаа MCS группын ерөнхийлөгч С.Оджаргалаар эхлүүлж байна.

Түүний үндсэн хөрөнгө 2.3 тэрбум ам.доллар. Улсын “халаасанд” оруулсан татвар хийгээд дансан дахь мөнгөнийхөө хэмжээгээр Монголдоо тэргүүлэгч. Зарим нь түүнийг маш завгүй, үргэлж л шинийг эрэлхийлж, нэгээс нөгөө бизнесийг “ургуулахаар” гүйж явдаг хэмээн үнэлдэг. Харин зарим нь “Эх орноо хятадуудад зарсан. Одоо ээмшиж байгаа MCS группынх нь 75 хувь нь Хятадын мэдлийнх” гэдэг. Аль нь байх нь хамаагүй, тэр ямар ч байсан хөрөнгө хийгээд бүтээн байгуулалтаараа Монголдоо тэргүүлэгч. Мянга мянган хүнийг ажлын байраар хангаж, эх орныхоо өнцөг булан бүрт бүтээн байгуулалт хийж яваа нэгэн. Түүнийг Жамбалжамцын Оджаргал гэдэг. Айлын дунд хүү болж, 1965 онд Баянхонгор аймагт мэндэлсэн тэрбээр нийслэлийн III хороололд хүүхэд насаа өнгөрүүлж, 33 дугаар дунд сургуулийг онц дүнтэй төгссөн байдаг.

Ээж, аавгүй хүүхэд нас

Амжилтад хүрч, хүсэл мөрөөдлийнхөө оргилд гарсан агуу бизнесмэн, алдарт зохиолч, суут хүмүүсийн зарим нь өмөөрөх эцэг, эхгүй өнчин, ядуу тарчиг амьдрал дунд хүүхэд насаа өнгөрүүлсэн байдаг. Магадгүй хүүхэд насных нь энэ дутуу бүхэн ирээдүйн бүтэн, дүүрэн амьдралын эхлэл болж, зорилго, тэмүүллийнхээ төлөө тууштай, шантралгүй зүтгэх хүч болдог ч байж мэднэ. Оджаргалыг дунд сургуульд байхад аав, ээж нь өвчний улмаас таалал төгссөн аж. Эцэг, эхээ өдөр шөнөгүй нэхэх таван нялх хүүхэд эмээгийнхээ гар дээр үлдсэн байна. Ээж, аавын хайр энхрийлэл, тэврэлт үнсэлтийг санаж, бэтгэрсэн ч онц сурч эмээгээ баярлуулахын төлөө ах дүү тав хичээдэг байсан хэмээн Оджаргал нэгэнтээ дурссан. Тиймээс ч дунд сургуулиа онц дүнтэй төгссөн тэрбээр ОХУ-ын Киевийн политехникийн дээд сургуульд элсэж, 1989 онд төгсчээ.

Амжилтын гараа буюу таван саяын төсөл

Сургуулиа төгсөж ирээд, Төвийн эрчим хүчний системд автоматикийн инженерээр хоёр жил ажилласан байна. Улмаар 1991 онд Эгийн голын усан цахилгаан станцын төсөлд инженерээр орж, тус станцын ТЭЗҮ-ийг гаргахаар болж, Швейцарын Цюрих хотноо “Электроват” компанид гурван сарын туршлага судлах дадлага хийжээ. Энд ажиллаж байхдаа эрчим хүчний консалтинг чиглэлээр судалгаа, зөвлөгөөний ажил эрхлэх бизнесийн санаа олж, 1993 онд гурван найзынхаа хамт MCS буюу “Mongolian consulting service” компанийг байгуулж байхдаа өнөөдрийн амжилтад хүрнэ чинээ зүүдлээ ч үгүй биз. Тэд тухайн үед эрчим хүчний чиглэлээр орон нутагт зөвлөгөө өгөх, тооцоо судалгаа хийж, хажуугаар нь оргилуун дарсны худалдаа эрхэлж байв. Энэ үед Дэлхийн банкнаас тэдэнд хамтран ажиллаж, судалгаа хийлгэх санал тавьсан байна. Тухайн үед ажлын тохилог байр битгий хэл, бичгийн ширээ сандал ч үгүй байсан Оджаргал Үндэсний статистикийн газарт ажилладаг найзаасаа “Өрөөнд чинь хүнтэй 20 минут уулзаадахъя” гэж гуйсан гэдэг. Тийнхүү бизнесийн анхны хэлэлцээрээ найзынхаа өрөөнд амжилттай хийж, 5000 ам.долларын төсөл хэрэгжүүлэхээр болсон нь түүний MCS хэмээх вант улс бий болохын эхлэл байв.

Тамхины цаас борлуулагчаас тив дамнасан корпорацитай болсон түүх

Тэрбээр нэгэн сонинд өгсөн ярилцлагадаа “Миний амьдралдаа хийсэн хамгийн ашигтай наймаа бол Орососс авчирч, зарсан бичгийн машины цаас. Тамхины цаас болгож зарсан уг наймаа надад 58 копейкийг 30 мянган төгрөг болгож өгсөн. Дахиж би тийм ашигтай наймаа өнөөдрийг хүртэл хийгээгүй явна” хэмээн ярьсан удаатай. Тэрхүү одтой наймаа түүний амьдралд бизнесийн оч гэрэлтүүлэхээс гадна хуримаа хийж, хувийн амьдралаа тэгшитгэх зам мөр болсон гэдэг. Тэрбээр гурван хүүхэд, эхнэрийнхээ хамт амьдардаг.

Оджаргал бизнесийг уран барилгатай зүйрлэх дуртай гэсэн. Анхны төслөө амжилттай дуусгасан тэрбээр өөрт хэрэгтэй зүйлээ бусдад ч дутагдаж буйг анзаарч, Сингапураас албан тасалгааны тавилга, компьютер зэргийг оруулж ирж, одоогийн “Анун” төвийг нээж байжээ. Удалгүй дэлхийд алдартай Packard Bell, Procter&Gamble зэрэг брэндийн гоо сайхны бараа, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэв. Мөн хэвлэлийн үйлдвэрийн тоног, төхөөрөмж оруулж ирэн “Интерпресс” нэртэй хэвлэлийн компани байгуулсан нь өдгөө энэ салбартаа томоохонд тооцогддог. Түүний бизнес тэлсээр өдгөө бизнесийн салбарын сул чөлөөтэй орон зай бүхэнд MCS-ийн охин компаниуд од болон гялалзаж байна. Өдгөө түүний мэдэлд мэдээлэл-харилцаа холбооны технологи, хүнс, ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай гэсэн таван үндсэн салбарт 54 охин компаниас бүрдэх М-Си-Эс групп бий. Тодруулбал, MCS группийн эгнээнд өдгөө “Спирт бал бурам”, “Тайгер” шар айрагны үйлдвэр, “Кока Кола” ундааны үйлдвэр, “Гоёо” брэнд, “Орчлон” дунд сургууль, “Анун” мебелийн үйлдвэр, “Анунгоо”, “Юнител” корпораци, “Интерпресс” хэвлэлийн компани, “Сэнтрал Тауэр” цамхаг, үндэстнүүдийн хувь нийлүүлсэн “Энержи ресурс” групп гээд Монголын хөгжлийн нүүр царайг

илтгэх компаниуд бий. Үүний дотор стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжүүд ч харьяалагдах жишээтэй. Түүний удирдаж буй энэ бүх бизнес үндэстэн дамнасан корпораци болохын төлөө урагшилж буйг Оджаргал онцлох дуртай. Түүний хөрөнгийн хэмжээг 2.3 тэрбум ам.доллар хэмээн зарлаж буй ч энэ нь баттай тоо биш юм. Учир нь минут, секунт тутамд түүний данс руу хэдэн сая төгрөг бус ам.доллар урсан ордог болохоор үүнээс ч их байх боломжтой гэгддэг.

Түүний талаарх муу мэдээ

Н.Энхбаярыг Монгол дахь авлигын загалмайлсан эцэг гэдэг бол Ж.Оджаргалыг авлигын төрсөн эцэг гэх хүмүүс байдаг. Учир нь тэр их хотын төв талбайд тэнгэр баганадсан өндөр барилга барьж, Хүүхдийн паркын талбайг тохижуулах нэрээр “хулгайлж”, гольф тоглох дуртай учраас өөртөө зориулсан гольфийн талбай байгуулж, нийслэлийн А зэрэглэлийн бараг бүх газрыг хувьдаа авсан талаар хэвлэлүүдэд хангалттай бичдэг. Ухаа худгийн нүүрс боловсруулах үйлдвэрийн 45 хувийн хувьцааг эзэмшиж байгаа нь монголчуудын зургаан жилийн төсөвтэй тэнцэх хэмжээний мөнгө гэгддэг. Түүнчлэн түүнийг төрийн тендерээр бизнес хийдэг цорын ганц чадварлаг “мэргэжилтэн” гэж зарим хүн шүүмжлэх нь бий. 2000 оноос хойш төрөөс зарласан 2334 тендерийн талаас илүүг нь буюу 1882-ыг нь MCS авсан. Үндсэндээ төрөөс зарласан тендерийн ихэнхийг Оджаргалын мэдлийн компаниуд л хувааж авдаг гэсэн мэдээлэл хэвлэлээр нэг бус удаа гардаг. Хамгийн сүүлчийн бусдад өгөөгүй “булаасан” тендер нь Улаанбаатар хотын утааг бууруулахаар хэрэгжүүлж буй “Утаагүй зуух” төсөл.

MCS-ээс олон сайн үйлс, хандив, тусламжийн аян, хөтөлбөр, тэтгэлэг зэргийг зохион байгуулж, мянга мянган иргэнд халуун гараа сунгадагийг энд дурдахгүй өнгөрч болохгүй. Гэхдээ түүний халаасанд МАН-ынхан төдийгүй томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн эрхлэгчид хэдийнэ орсон гэгддэг бараан мэдээлэл бас дагадаг. Хууль дүрэм батлагч, тогтоогчид хийгээд хянаж, шалгагчид ч түүний үгээр байдаг гэх. Энэ нь Монголын хөл дээрээ бүрэн тогтож чадаагүй эдийн засаг хийгээд эрүүл биш хууль эрх зүйн орчинтой холбоотой гэдгийг учир мэдэх хүмүүс хэлдэг. Хэдийгээр татвар төлөлтөөрөө улсдаа сүүлийн арван жил эхний гурван байрт яваа ч түүнийгээ хэд дахин нугалсан ашгийг улс төрийнхний оролцоотойгоор “халаасладаг”. Түүнийг Монголын эдийн засгийн алуурчдын тоонд зүй ёсоор орох ёстой хүн хэмээн зарим хэвлэлд бичсэн байдаг. Гэхдээ л Оджаргал хэмээх энэ эрхэм

БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

ШИНЭЭР БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН ГАРГАДАГ НИЙТЛЭГ 8 АЛДАА

Х.БУЛГАН

Хөрөнгө оруулагчийг үргээх үгс гэж бий

Аливаа алдаанаас эмээх хэрэггүй. Бизнесийн хөгжилд эерэгээр нөлөөлж болох алдаа мадаг байхад, зайлсхийх ёстой алдаа ч гэж бий. Шинээр бизнес эрхлэгчид хөрөнгө оруулагчидтай ярилцахдаа буруу ярих нь бий. IE Business School-ын профессор Питер Брайнт хөрөнгө оруулагчдад зарлах хэрэггүй зарим зөвлөгөөг хүргэж байна.

“Бидэнд өрсөлдөгч байхгүй”

Арваад жилийн өмнө бидэн дээр хэдэн бизнес эрхлэгч ирлээ. Тэд төлбөр тооцоог цахим хэлбэрээр хийдэг болгох шийдэл санал болгов. Тэгээд “Хэн ч бидний бизнесийг одоогоор эрхлээгүй байгаа. Бидэнд ямар ч өрсөлдөгч байхгүй” гэж хэлсэн билээ. Бид харин “Яагаад өрсөлдөгч байхгүй гэж” хэмээн эргэцүүлэн бодлоо. Хүмүүс төлбөр, тооцоогоо интернэтээр хийдэг болохын тулд эхлээд интернэтэд дасаж, компаниуд гүйлгээгээ цахим орчин руу шилжүүлж, технологи илүү найдвартай болох шаардлагатай байлаа. Өөрөөр хэлбэл, зах зээл энэхүү үйлчилгээг авахад бэлэн бус байв. Тиймээс бид хөрөнгө оруулаагүй юм. Өөр нэгэн компани харин тус салбарт хөрөнгө оруулсаны эцэст мөнгөө алдаж, дампуурсан аж. Өрсөлдөгч байхгүй гэдэг нь чухал зүйлийг өгүүлж байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, таны бүтээгдэхүүн зах зээлд хэрэггүй гэдгийг.

“Бид найзуудынхаа дунд судалгаа явуулсан”

“Манай бүтээгдэхүүн гайхалтай сайн. Зарим хүнд их таалагдсан тул, худалдан авагч гарцаагүй гарч ирнэ!” Ийм үг сонсохоор би “Баталгаа нь хаана байна вэ? Та энэ талаар хэнтэй ярилцаж байсан бэ?” гэж асуумаар санагддаг. Учир нь бизнес эрхлэгчид төдийлэн сайн дүн шинжилгээ хийгээгүй байдаг. Эцсийн хэрэглэгчдээ сайтар судал, тэдний эрэлтэд соргог ханд. Хэрэглэгчдэд чухам юу хэрэгтэй байна. Тэд танай бүтээгдэхүүний тухай ямар

Монголын бизнесийн салбарын түүхэнд зүй ёсоор бичигдэх нэгэн үзэгдэл билээ. Тэр энэ салбарт хүч үзээд ердөө 17-хон жил болж байна. Түүний ахархан хугацаанд гаргасан энэ их амжилт хүнээр бол дөнгөж нас биед хүрч буй идэрхэн залуу юм. Тэрбээр өдгөө Зайсан толгойг Улаанбаатар хотын төвтэй холбох агаарын дүүжин лифтийг байгуулах тал дээр судалгаа, тооцоо хийж байгаа гэсэн. Иймэрхүү нарийн ажиллагаа шаардсан, өндөр зардалтай бүтээн байгуулалтын ажилд дотоодын тэрбумтнууд хөрөнгөө чиглүүлэх нь бусдад хүндлэгдэхийн илрэл.

Аливаа зүйл сайн, муу хоёр талтай байдаг хойно бид ч үндэсний тэрбумтнуудын талаар бичихдээ дан ганц гэгээлэг мэдээллийг чухалчилж туйлшрахыг хүссэнгүй. Үндэсний хөрөнгөтнүүд олшрох нь Монголд хэрэгтэй. Тэднээр бахархах учиртай.

бодолтой байна. Бизнесээ эхэлж буй хүмүүс зорилтот бүлгээсээ ганцхан асуулт асууж байгаа тохиолдолтой би таарч байсан. Тэд “Бид Танд ийм шинэ бүтээгдэхүүн сана болговол худалдаж авах уу?” гэж лавладаг. Гэтэл ганц ийм асуулт хангалгүй. Үүний оронд харин нэгээс арав хүртэлх оноогоор үнэлүүлбэл танай бүтээгдэхүүнд хандах хандлага нь илрэх магадлал илүү их юм.

“Бид зах зээлийн нэг хувийг эзэлж, их мөнгө олно”

Энэ үгийг хэлдэг хүмүүс хэт хуучинсаг үзэлтэй бөгөөд эрсдэлд дургүй байдаг. Та томоохон зах зээлийн зөвхөн ганцхан хувийг л эзлэхийг хүсэж байгаа бол зах зээлээ сайн ойлгохгүй байгаагийн шинж.

Миний анзаарснаар бол, ийм зорилго дэвшүүлсэн компаниуд тогтвортой бус. Хөрөнгө оруулагч дээр ирж байгаа бизнес эрхлэгчид “Бид зах зээлийн 25 хувийг эзлэх хүсэлтэй. Энэ нь жижиг зах зээл байж болзошгүй ч хэрэглэгчдээ сайн судалсан” хэмээдэг байгаасай гэж би боддог.

“Ашгаа хуваарилж эхлэхээс өмнө бид хөрөнгөө босгочихно”

Гарааны бизнес эрхлэгчид хөрөнгө оруулагчдаас хэдэн сая ам.доллар босгочихвол ямар ч асуудалгүй болчихно гэсэн ойлголттой байдаг. Танд ихээхэн хэмжээний хөрөнгө байвал Та мэдээж түүнийгээ ирээдүйтэй бизнест л зарцуулахыг хүснэ. Хэтэрхий их хэмжээний хөрөнгө босговоос, үрэгдэх болон дампуурах аюултай. Хүмүүс өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ улам сайжруулахын оронд хаанаас ч хамаагүй хөрөнгө оруулагчтай л болохыг хүсдэг нь хамгийн том алдаа. Ийм компаниуд худалдан авагчдаасаа ашиг орлого олохгүй, ирээдүйгүй гэж нэрлэж болно.

“Манай маркетингийн стратеги бол цахим хуудас”

Шинээр бизнес эрхлэгчид, оюутнуудаас маркетингийн стратегийг нь асуухад “Манайх цахим хуудастай болно” гэж хариулдаг. Бүтээгдэхүүнээ борлуулах нь мэдээж маш чухал. Гэхдээ бид хэрэглэгчдээ хэрхэн мэддэг вэ гэдэг асуудал руу буцаж оръё. Таны хэрэглэгч хэн бэ? Тэдэнд юу хэрэгтэй байна? Өөрийн худалдан авагч, үйлчлүүлэгчээ сайн ойлгох нь компанийн маркетингийн стратегийг хөгжүүлэхэд тустай. Харин цахим хуудастай болно гэдэг нь маркетингийн стратеги биш юм. Түүний нэгээхэн хэсэг байж болох ч жинхэнэ стратеги бол өөр.

“Зах зээлд дүн шинжилгээ хийхэд бидэнд илүү цаг хэрэгтэй”

Ихэнх бизнес эрхлэгчид зах зээлээ сайтар дүгнэсэн шинжилгээ хийх нөөц бололцоо, мэдээлэл дутмаг байдаг. Гэтэл зах зээл хурдацтай хөгждөг. Иймээс илүү сайн мэдээлэл цуглуулж, эсхүл хурдан сэтгэх хэрэгтэй. Хамгийн муу шийд бол ямар ч шийд гаргаагүй байх явдал. Аливаа нөхцөл байдал хурдан өөрчлөгддөг. Иймд хурдтай сэтгэж, үйлдэл хийх нь хамгийн чухал.

“Бид дөрвөн жилийн дараа компаниа Google-д зарна”

Бид бизнесээ хөл дээр нь зогсоож, дараа нь Google юм уу өөр мэдээлэл, технологийн компанид зарах стратегитэй гэж хүмүүс хэлдэг. Та тэгвэл Google-ийн төлөөлөгчтэй уулзсан уу? Тэд дөрвөн жилийн дараа юу хийхийг нь мэдэх юм уу? Ингэж хэлдэг хүмүүс бизнес ойлгодоггүйгээ харуулж байдаг. Ирээдүйн өсөлтөө тооцоолоогүй байж болохгүй. Google-д бизнесээ зарна гэж найдах сайн ч гарааны бизнест сайтар тунгааж бодсон стратеги л хэрэгтэй.

“Бид алдаа гаргахгүй”

Алдаа гаргадаггүй бизнес гэж байхгүй. Хүмүүс алдаанаасаа суралцахын оронд байнга л хэн нэгнийг буруутгахыг оролддог. “Манай бүтээгдэхүүн худалдан авагчид заавал таалагдана. Хэрвээ таалагдахгүй бол тэд тэнэг” ч гэх юм уу, иймэрхүү бодол байдаг. Гэтэл зорилтот хэрэглэгч биш, Та өөрөө алдаа гаргаж байна. Бизнес эрхлэгч төлөвлөгөөгөө өөрчилж чаддаг байх ёстой. Таны амжилтын түлхүүр бол үйлчлүүлэгч, худалдан авагчдын хүсэлтээр бизнесээ хөрвөх чадвартай байлгах юм.

СУРВАЛЖЛАГА

БИЗНЕСИЙНХНИЙ ЧӨЛӨӨТ ИНДЭР ТАВАН НАС ХҮРЛЭЭ

Энэ үдэш МБЗ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Петер Морроу болон дэд дарга Лувсандэндэвийн Сумати нар халаагаа өгч байгаагаа зарласан юм.



Монголын санхүү, эдийн засаг, бизнесийн салбарынхны нээлттэй талбар, гүүр болсон Монголын бизнесийн зөвлөл энэ сарын 5-нд таван жилийн ойн баяраа тэмдэглэн өнгөрүүллээ. Худалдаа, бизнесийн харилцааг дэмжин хөгжүүлэх улмаар Монголын эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзлэл дүүрэн Монголын бизнесийн зөвлөлийнхөн ирэх таван жилд илүү ихийг хийж, бүтээхээ ойн баярын хурлын үеэр тэмдэглэн хэлж байлаа. Энэ үеэр “Худалдаа хөгжил”-ийн банк, “Оюутолгой”, “Пийбоди Энержи” зэрэг компанийн удирдлагууд сонирхолтой илтгэл тавьсан. Тухайлбал, “Оюутолгой” ХХК-ийн Хэвлэл мэдээлэл, Олон нийтийн харилцаа хариуцсан дэд ерөнхийлөгч Хьюстон Спенсэр энэ мөчид удтал яригдсан Оюутолгойн эрчим хүчийг БНХАУ-ын Хөх хотоос авах асуудал шийдэгдсэн тухай дуулгаж, Монголын эдийн засгийн чухал нөлөөтэй шинэ мэдээний эхний сонсогчид нь Монголын бизнесийн зөвлөлийн гишүүд байв. Мөн “Пийбоди Энержи” компанийн Монгол ба Энэтхэг дахь үйл ажиллагаа хариуцсан ерөнхийлөгч Аршад Сайед илтгэлийнхээ төгсгөлд “Пийбоди Энержи” компани Монгол улсын хөгжлийн урт хугацааны түнш байх болно. Монголыг эрчим хүч нийлүүлэгч орон болоход бид дэмжин туслана” хэмээлээ.

Монгол улсын эдийн засаг хөгжихийн хэрээр Монгол дахь бизнесийг төлөөлж байгаа байгууллагуудын үүрэг оролцоо ч нэмэгдэх болсон. Тэгвэл Монголын бизнесийн зөвлөл өнгөрсөн хугацаанд 250 орчим дотоод, гадаадын хөрөнгө оруулагч, бизнесийнхнийг эгнээндээ нэгтгэж чаджээ. Сар тутам гишүүдийнхээ дунд зохион байгуулдаг уулзалтыг нь бизнесийнхэн шинэ түнш олж авах, туршлага солилцох сайхан боломж байдаг гэж дүгнэдэг. Түүнчлэн тус уулзалтын үеэр Засгийн газрын төлөөллүүд бизнесийнхэнд сонирхолтой мэдээлэл хийх нь ч бий.

Мөн тус зөвлөлөөс долоо хоног бүр гишүүддээ Монголын болон гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэгдсэн Монголын улс төр, эдийн засагтай холбогдсон мэдээллийг багцлан хүргэдэг Newswire буюу цахим мэдээ нь завгүй хүмүүсийн цагийг хэмнэж, тойм мэдээлэл өгдгөөрөө өндөр ач холбогдолтой юм.

Энэ үдэш МБЗ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Петер Морроу болон дэд дарга Лувсандэндэвийн Сумати нар халаагаа өгч байгаагаа зарласан юм. ТУЗ-ийн шинэ даргаар “Ньюком” группын гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, дэд даргаар “Си »

Пи Эс Ай” компаний гүйцэтгэх захирал Тим О’нейл томилогдсон юм. 2007 онд Монгол улсад бизнесийн үйл ажиллагаа явуулж буй бизнесмэнүүдийн төлөөлөл уулзаж, Монголын бизнесийн зөвлөлийг байгуулж байжээ. Тус байгууллагын ТУЗ-ийн гишүүд бизнес, эдийн засгийн тулгуур салбаруудын төлөөллөөс бүрддэг. Өнгөрсөн оны арванхоёрдугаар сард шинээр гурван гишүүн нэмснээр ТУЗ-ийн гишүүдийн тоо нь 31 болсон байна.

Тэдний заримаас гишүүдийн заримаас дурдахад, “Пийбоди Энержи” компанийн Монгол ба Энэтхэг дахь үйл ажиллагааг хариуцсан ерөнхийлөгч Аршад Сайед, “Голдстрим Монголиа” компанийн захирал Б.Болд, “Бороо гоулд” компанийн Санхүү, захиргаа хариуцсан захирал Дуглас Кран, “Эм Ай Эйч” группын гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан, “Хас” банкны гүйцэтгэх захирал Д.Бат-Очир, “Таван богд” группын дэд ерөнхийлөгч Д.Хулан гэх мэт гадаад, дотоодын бизнесийн төлөөлөл багтдаг.

“Mongolian economy” сэтгүүл шилдгээр шалгарлаа

Монголын бизнесийн зөвлөл таван жилийн ойн баяраараа таван номинациар шилдгүүдээ шалгаруулсан бөгөөд Хэвлэл мэдээллийн оны шилдэг байгууллагаар “Mongolian Economy” сэтгүүл тодорсон билээ. Түүнчлэн Олон улсын шилдэг компаниар “Прайсватерхаускооперс”, Дотоодын шилдэг компаниар “Мандал даатгал”, Засгийн газарт ээлтэй хүнээр Эдийн засгийн хөгжлийн яамны Инноваци, өндөр технологийн хэлтсийн дарга Б.Ганбат, Шилдэг ажлын хэсгээр Махони Лайотта хуулийн фирм тус тус шалгарсан юм. Монголын бизнесийн зөвлөлийн ирэх он жилүүдийн ажил нь гялалзсан амжилтаар дүүрэн байг ээ. ■

MONGOLIAN ECONOMY СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

-Монголын бизнесийн зөвлөлийн талаар Та юу хэлэх вэ?

Камерон МакРей /”Оюутолгой” ХХК-ийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал/

-Монголын бизнесийн зөвлөлийн асар богино хугацаанд өсөн дэвжсэн амжилтаар бид бахархаж байна. Энэ бол тус байгууллагын манлайлал, оролцогч талуудын тасралтгүй хүчин чармайлтаар бий болсон амжилт юм. Гишүүдийнхээ ашиг сонирхлыг дээдэлж, амин чухал асуудалд анхаарч ажилладаг Монголын бизнесийн зөвлөлийнхөнд таван жилийн ойн баярын мэнд хүргэж, ажлын амжилт хүсье.

А.Цэмбэл/ “Спешиал Карьер консалтинг”компанийн захирал/

-Дөнгөж 20 жилийн өмнөөс зах зээлийн нийгэмд шилжсэн ч дэлхийн хурдацтай хөгжиж буй орон болсон Монголын хувьд Монголын бизнесийн зөвлөл шиг байгууллага зайлшгүй хэрэгтэй юм. Эдний үйл ажиллагаа салбар салбарын үйдвэр гаргагчид, төлөөлөгчид хамтран суугаад, бизнесийн цаг үеийн асуудал болон ирээдүйн бололцооны талаар ярилцах таатай боломжийг олгож байдаг.

Ж.Петер Морроу / “Ньюком” группын дэд захирал/

-Монголын бизнесийн зөвлөлийн үйл ажиллагаа ийм өндөр түвшин, ололт амжилтад хүрнэ гэдгийг анх үүсгэн байгуулж байх 2007 онд бид урьдчилан харж чадахгүй байсан.
Энэ байгууллага өдгөө амжилт арвинтай бизнесийн холбоо болсон байна.

Норихико Като/ХААН банкны гүйцэтгэх захирал/

-МБЗ нь өөрийн гишүүд болон Засгийн газрын төлөөлөл үзэл бодлоо чөлөөтэй солилцох талбар болох замаар Монгол дахь бизнес, хөрөнгө оруулалтын тулгамдсан асуудлуудыг олонтаа шийдэж ирсэн билээ. Бид цаашид хамтран Монголд бизнесийн таатай орчин бүрдүүлэхийн төлөө ажиллахыг хүсэж байна.

Б.Дамдиндорж/”Европю Азия” компанийн ерөнхий захирал/

-Тус зөвлөлийн гишүүн байх нь бидний эрсдэлгүй үйл ажиллагаанд том дэмжлэг болдог. Бидний цаашдын хамтын ажиллагаа улам өргөжин тэлнэ гэдэгт итгэлтэй байна.

Кэролин Кларк /“Прайсватерхаускооперс” компанийн захирал

-Монголын бизнесийн зөвлөл бизнесийн ертөнцөд мэргэжлийн удирдах байгууллага болон үүсгэн байгуулагдсан юм. Энэ явцдаа маргаантай асуудлаар ярилцаж хэлэлцэх замаар гишүүдийнхээ үр дүнтэй хамтын ажиллагааг хангаж, улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна. Мэргэжлийн удирдлагын хувьд тус байгууллага олон гишүүдийг эгнээндээ багтаасан аудит, татвар болон зөвлөгөө өгөх үйлчилгээгээр хангаж байдаг.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

АШИГ, НЭР ХҮНД, ҮНЭ ЦЭНЭ

Б.УУГАНБАЯР

...Компанийн хувь эзэмшигчид, удирдах зөвлөлийн гишүүд сайн засаглалын үр шимийг ойлгож үйл ажиллагаандаа нэвтүүлэх эсэхээс л бүх зүйл хамаарч байна. Өнөөдөр манайд зах зээлээ мэдэрдэг компаниуд нь засаглалаа сайжруулж, хөрөнгө оруулалт татаж, ашиг орлогоо нэмэгдүүлж чадаж байна...



Компанийн засаглалд онцгой анхаарал хандуулж, хөгжүүлэх нь эдийн засгийн хямралыг хохирол багатай даван туулах сэлүүр болох билээ. Тиймээс "Mongolian Economy" сэтгүүлийн зүгээс компанийн засаглалын хөгжлийг дэмжихээр Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Компанийн засаглалын үндэсний зөвлөлтэй хамтарч ажиллах санамж бичиг үзэглэсэн юм. Манай сэтгүүлээс уншигч Та 14 хоног тутам компаниудын санхүүгийн гол үзүүлэлтүүд, тус салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, сайн засаглалын дотоод, гадаад туршлагын талаар сонирхолтой нийтлэл, сурвалжлага уншиж байх болно. Энэ удаа Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн даргын ярилцлага, АПУ компанийн ашиг, орлого, тус компанийн гүйцэтгэх захирлын талаарх товч мэдээллийг хүргэж байна.

Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга Д.Ганбаяртай Монголд компанийн засаглалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал хийгээд боломжийн талаар товч ярилцлаа.

-Өнгөрсөн онд Засгийн газраас Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөрийн хүрээнд хийх гол ажлууд болон хүлээж буй үр дүн юу байна вэ?

- Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон Компанийн засаглалын үндэсний зөвлөл байгуулсан. Компанийн засаглал хөгжсөнөөр компаниудын үр ашиг өсөж, хөрөнгийн зах зээл хөгжиж, хөрөнгө оруулагчид нэмэгдэнэ. Засаглал нь хувь нийлүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирлага гэсэн хэсгээс бүрддэг. Тэгвэл өнөөдөр манайд удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын хоорондын харилцаа, итгэлцэл дутагдалтай байгаагаас бизнесээ амжилттай явуулж чадахгүй байна. Шалтгаан нь манай гүйцэтгэх шатны удирдлагуудын мэдлэг боловсрол, засаглалын талаарх ойлголт дулимаг байгаатай холбоотой юм. Тиймээс манай үндэсний зөвлөл компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулдаг байгууллагуудтай хамтарч гүйцэтгэх удирдлагуудад засаглалын талаарх ойлголт өгдөг юм. Түүнчлэн компаниудын засаглалд үнэлгээ хийж, засаглал муутай компанид тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, зөвлөнө. Мөн МҮХАҮТ-тай хамтарч, хувьцаат компаниудын засаглалд үнэлгээ хийж, сайн засаглалын үлгэр жишээ болсон компаниудын туршлагыг олон нийтэд танилцуулж, шагнаж урамшуулна.Төрийн өмчийн хороотой хамтарч төрийн өмчит компаниудын чадавхыг сайжруулах чиглэлд ч ажиллана.

-Компанийн засаглалын хөгжилд чөдөр тушаа болж буй зүйл нь юу байна вэ?

-Компанийн хувь эзэмшигчид, Удирдах зөвлөлийн гишүүд сайн засаглалын үр шимийг ойлгож, үйл ажиллагаандаа нэвтүүлэх эсэхээс л бүх зүйл хамаардаг. Зах зээлээ мэдэрдэг компаниуд нь засаглалаа сайжруулж, хөрөнгө оруулалт татаж, ашиг орлогоо нэмэгдүүлж чадаж байна. Тухайлбал, ХААН, Голомт банк, АПУ компанийг дурдаж болно. Миний харж буйгаар Монголын компаниудыг нийтэд нь аваад үзвэл дөнгөж 10 хувь нь засаглалын үнэ цэнэ, хэрэгцээ шаардлагыг ойлгосон, үлдсэн 90 хувь нь үүнийг ойлгож, хүлээж авахгүй байна. Засаглалыг компанийн нүдэнд баригдаж, гарт баригдах ашгаас гадна компанийн нэр хүнд, хөрөнгө оруулагчдын итгэлийг татах үнэ цэнэ гэж ойлгох хэрэгтэй. Хэрэв компаниуд урт хугацаандаа ашиг орлого өндөр, үйл ажиллагаагаа амжилттай явуулахыг хүсвэл компанийн нэр хүнд, үнэлэмжээ өсгөх шаардлагатай.

-Дэлхий нийтэд засаглалын чиг хандлага ямар байна вэ?

-Саяхан бид Тайваньд болсон Компанийн засаглалын форумд оролцоод ирлээ. Тус форумаар хөндсөн гол асуудал нь компаниудыг засаглалаа хөгжүүл гэж шахахаасаа илүү, хөгжүүлэх арга зам, боломж бололцоог нь гаргаж өгөх хэрэгтэй юм байна. Сайн засаглалын буухиаг төрийн байгууллагууд биш, хувийн компаниуд хэрэгжүүлж эхэлдэг жишигтэй юм билээ. Азийн компанийн засаглалын холбоо гэж байдаг. Тэд улс тус бүр дээр компанийн засаглалын үнэлгээ гаргаж, зөвлөмж өгдөг. Бид манайд үнэлгээ хийж өгөхийг хүссэн.

Олон улсын түвшинд засаглалын ил тод байдал, үнэ цэнийг орон бүр ойлгож, анхаарч эхэлсэн. Муугаар бодоход эдийн засгийн хямрал боллоо гэхэд үндэсний компаниуд эдийн засгаа аврах “дэнлүү” болж өгөх учиртай. ■

САЙН ТУРШЛАГА

АПУ-ГИЙН ЗАСАГЛАЛТАЙ ТАНИЛЦ

Удирдах зөвлөлийн гишүүд:
Ес (үүнээс гурав нь хараат бус гишүүн бөгөөд хоёр нь гадаадын зөвлөх)

Гүйцэтгэх захирал:
Ц. Эрдэнэбилэг



Ажлын туршлага:
-1995-2000 онд “Говь” ХК-д инженер, худалдааны менежер, ахлах менежер
-2000-2006 онд “Эрдэнэт хивс” ХК-д гүйцэтгэх захирлаар
-2007-2008 онд АПУ Хувьцаат компанид дэд захирлаар
-2008 оноос тус компанид гүйцэтгэх захирлын албыг хашиж байна

Гол бизнес, эрхэлдэг үйл ажиллагаа:
Архи, пиво, ус, ундаа, сүү, жүүс үйлдвэрлэх

Санхүүгийн товч тайлан

Он	Нийт хөрөнгө	Цэвэр ашиг	Нийт хөрөнгө оруулалт	Ногдол ашиг
	тэрбум төгрөгөөр			
2010	96.5	19.7	21.3	2.9
2011	126.4	20.0	14.5	4.4

Хувьцаа эзэмшигчдийн тоо:
3500 орчим

Хувь нийлүүлэгчид болон ТУЗ хуралдуулах зарчим:
Хуульд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаа жилд нэг удаа хуралдуулж, компанийн тухайн жилийн хөрөнгө оруулалт, ирэх жилийнхээ үйл ажиллагаа, чиглэл, томоохон төслүүдийг танилцуулдаг. Мөн хувь нийлүүлэгчиддээ ногдол ашиг тараадаг. Харин ТУЗ-ийн хурлаа улиралд нэг удаа хийдэг. Томоохон хөрөнгө оруулалт, цаг үеийн асуудал хэлэлцэх шаардлага гарвал ээлжит бус хурлыг цахим хэлбэрээр хийдэг.

Компанийн засаглалын чиглэлээр хийж буй шинэчлэл:
Дотооддоо засаглалаа сайжруулахаар олон улсын хоёр том стандартыг 2010 оноос нэвтрүүлээд байна. Эхнийх нь ISO 2021 буюу хүнсний аюулгүй байдлын стандартын тогтолцоо. Дараагийнх нь, ISO 14001 буюу байгаль орчинд ээлтэй удирдлагын тогтолцооны олон улсын стандарт юм. Энэ хүрээнд Германы цахилгаан болон уурын хэрэглээг багасгаж, хог хаягдал бага гаргадаг хамгийн сүүлийн үеийн техник, технологийг үйлдвэртээ суурилуулсан. Мөн хатуу хог хаягдлыг дахин боловсруулах, гэрэл цахилгаанаа хэмнэх, усыг дахин боловсруулах чиглэлээр анхаарч байна.

Засаглалаа сайжруулах ирээдүйн стратеги:
Компанийнхаа дотоод, гадаад засаглалыг улам бэхжүүлэн, бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэн ажиллаж байна. Мөн хувь нийлүүлэгчиддээ онцгой анхаарч, компанийнхаа өсөлтийг олон талаас хангаж ажиллах болно.



ХБНГУ-ын Дармштат хотын Техникийн их сургуульд хийсэн “Кластерийн менежмент”-ийн сургалтын үеэр “Хессенметалл” кластерийн санаачилгын гүйцэтгэх захирал Симон Алигтай ярилцсанаа хүргэж байна.

Симон Алиг цахилгааны инженер, бизнесийн удирдлагын мэргэжлээр 2009 онд Дармштат хотын Техникийн их сургуулийг онцсайн дүнтэй дуургэсэн. Тэрбээр Брюссель дахь “Женерал Электрик”, түүнчлэн “Б.Браун Мелсунген” ХХК болон “Роланд Бергер стратеги” зөвлөх компанид ажиллаж байсан туршлагатай.

КЛАСТЕР

ХАМТЫН ХҮЧ

Х.ХУЛАН

> ...Кластерийн дотор хэдий чинээ итгэлцэл байна, төдий чинээ шударга, хамтач туршлага солилцоо бий болдог. Кластерийн гишүүн компаниуд нь бүх оролцогч судалгааны байгууллагын хамтарч цуглуулсан мэдлэг, мэдээллийн ачаар үр дүнд хүрдэг гэдгийг аяндаа ойлгодог...



Симон Алиг

-“Хессенметалл” кластер ямар бүтээгдэхүүн зах зээлд гаргадаг вэ. Кластерын гол дүрмээс танилцуулахгүй юу?

-“Хессенметалл” кластерийн санаачилгыг 2006 онд Хессен мужийн металл ба цахилгааны чиглэлийн компаниудын нийгэмлэг болон Дармштатын Техникийн их сургууль (ТИС) хамтарч байгуулсан. Одоогийн байдлаар дөрвөн кластерийн

байгууллагатай хамтарч ажилладаг. Тэдгээр нь автомашин, нисэх хүчин, мехатроник болон хуванцрын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Борлуулалт, худалдан авалт, хүний нөөц, судалгаа шинжилгээний ажлыг хамтарч хийдэг. Ялангуяа техникийн чиглэлийн судалгааны байгууллагуудтай байнгын холбоотой байдаг. Тэдгээр нь кластерийн гишүүдэд судалгааны ажлынхаа үр дүнгээ хуваалцдаг. Кластерийн төслийн ажлаас гадна хоорондоо туршлага солилцох нь ихээхэн ач холбогдолтой юм. Кластерийн дотор хэдий чинээ итгэлцэл байна, төдий чинээ шударга, хамтач туршлага солилцоо бий болдог. Кластерийн гишүүн компаниуд нь бүх оролцогч тал судалгааны байгууллагын хамтарч цуглуулсан мэдлэг, мэдээллийн ачаар үр дүнд хүрдгийг аяндаа ойлгодог. Дармштатын ТИС-ийн "Кластер, нэмүү өртгийн менежмент"-ийн тэнхмийн судалгааны албаныхан кластеруудыг удирддаг.

-Хессен мужийн металлын аж үйлдвэрийн салбар ямар онцлогтой вэ? Танай кластерт хэдэн гишүүн компани нэгдсэн бэ?

-Хессен мужийн металл, электроникийн үйлдвэрүүд гол төлөв жижиг, дунд бизнес эрхэлдэг. Тус салбарын нийт 600-гаад компани нь 30 мянган ажилтантай. Манай дөрвөн кластерт 50 компани гишүүн болж нэгдсэн.

-Кластерийн хамтын ажиллагааг өндөр бүтээмжтэй байлгах үүднээс судалгааны байгууллага, орон нутгийн засаг захиргаатайгаа хэрхэн хамтарч ажилладаг вэ?

-Манай хуванцарын кластерт технологийн скаут ажилладаг. Тэрхүү скаут нь Касселийн их сургуулийн ажилтан. Тэрбээр кластерийн технологийн төслүүдээ тодорхойлдог. Ингэхийн тулд кластерийн гишүүдтэйгээ хамтарч, шинэ санаа санаачилгыг хэлэлцдэг. Үүний дараа тухайн төслөө удирдан хэрэгжүүлдэг. Их, дээд сургуулийн судалгаа, мэдлэгийг кластерийн менежментэд ашиглах нь зүйтэй юм. Үүнийг манайх технологийн скаутаараа дамжуулан хийж байна.

-Металлын аж үйлдвэр нэмүү өртгийн процесст хэрхэн хувь нэмрээ оруулж болох вэ?

-Германы аж үйлдвэрийн нэмүү өртгийг бүрдүүлдэг нэгэн чухал хэсэг нь металл болон электроникийн салбар. Энэ нь аж үйлдвэрийн цөм салбар юм. Тийм ч учраас тус аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадвар ихээхэн ач холбогдолтой.

-Сургалтаар Та "Коопетишн" (Cooperation: competition, cooperation гэсэн хоёр үгнээс бүтсэн нийлмэл үг) гэдэг ухагдахууныг танилцууллаа. Энэ нь зах зээлийн талбар дээр өрсөлддөг компаниуд, кластерийн хүрээндээ үр ашигтай хамтын ажиллагааг өрнүүлж болно гэж байна. Энэ талаар тодорхой жишээн дээр ярьж өгнө үү?

-Компаниуд үйлчлүүлэгчээ олж авах гэж хоорондоо өрсөлддөг. Гэтэл компаниудад шинэ технологи, инновацийг нэвтрүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт шаарддаг. Энэхүү инновацид оруулах хөрөнгө оруулалтыг нэг компани гаргах нь эрсдэлтэй. Олон компани хамтарч өөрсдийн нөөц боломж, чадавхиа нэгтгэх нь үр дүнтэй байдаг. Жишээ нь, автомашины "Даймлер", "Рено" компаниуд электрон машины чиглэл дээрээ хамтарч ажилладаг. Бусад салбарт харин өрсөлдөгч.

-Кластерийн санаачилга бизнест ямар үр ашиг авчирдаг вэ?

-Аливаа кластер тухайн компанийн мэдлэгийн баазыг өргөжүүлж, нэмэгдүүлэх ёстой. Компаниуд бусад аж ахуйн нэгжийн чадавхийг хэсэгчлэн судалж, зөвхөн кластерийн хүрээнд л хэрэгжүүлэх боломжтой шинэ төсөл, хөтөлбөрийн санаа олж авдаг.

-Кластерийн санаачилгыг анх үүсгэн байгуулахад ямар бэрхшээл тулгардаг вэ?

-Хамгийн асуудалтай зүйл бол компаниудыг кластерт нэгдэн орохыг уриалах байдаг. Ингэхийн талд Та юуны өмнө стратегиэ танилцуулж, яг ямар үр ашиг гарах вэ гэдгийг тодорхой жишээгээр үзүүлэх хэрэгтэй.

-Кластер хэрэгжүүлэхийг сонирхсон Монголын бизнес, судалгааны байгууллага, төр, хувийн хэвшлийн удирдлагуудад Та ямар зөвлөгөө өгөх вэ?

-Эхний ээлжинд 15-20 жилийн нэгдмэл зорилго, хэтийн төлөв боловсруулахыг зөвлөж байна. Үүндээ тулгуурлаад ямар чиглэлийн кластер гаргаж болохоо тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, кластерийг эхлүүлэхээс өмнө чиглэл, санаачилгаа сайтар судалж, тодруулах ёстой. Зорилгоо зөв тодорхойлж, чиглэлээ гаргасан байхад таны ажил сайн явах болно. ■

ТЕХНОЛОГИ

УХААЛАГ ХЭРЭГЛЭЭ

2011 онд
109.386
хүн ухаалаг гар утас хэрэглэж байсан бол

Энэ онд
254085
хүн ухаалаг гар утас хэрэглэж байна.

2015 онд монгол хүн бүр ухаалаг гар утас утас хэрэглэнэ гэсэн судалгаа бий.

Ухаантай утас

Дэлхийн ухаалаг гар утасны зах зээл дээр “Blackberry”, “Windows” , “Symbian OS”, “Iphone iOS”, “Android” системтэй утаснууд секунт тутам маркетинг, технологийн дэвшил, үнэ зэргээр өрсөлдөж байна. Программ зохиогчид эдгээр гар утсанд зориулж хэрэглээний программ, тоглоом зохиож, худалдаанд гаргадаг нь ухаалаг утсыг улам ухаалаг болгож түүний нэр хүндийг зарим үед компьютероос ч өндөрт өргөж байна.

Өнгөрөгч оны эхээр монгол программистуудын ухаалаг утсанд зориулж бүтээсэн аппликэйшн, тоглоом ердөө 100 ч хүрэхгүй байсан билээ. Харин өнөөдрийн байдлаар 300 хол давжээ. Түүнчлэн Б.Батчулуун хэмээх залуу “Android”-д тулгуурлан ухаалаг гар утасны программ зохиосон нь эдүгээ дэлхий даяар таван сая гаруй хувь борлуулагдаад байна. Тэгэхээр Монголын ухаалаг гар утас хөгжүүлэгчдийн түвшин хэр хурдацтай явж байгаа нь бидний нүдэнд ил байна. Түүнчлэн монгол залуус дотоодын зах зээлд зориулан хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, мэдээлэл дамжуулах зорилготой аппликэйшн зохиож байна. Тэгвэл аппликэйшн гэж юу вэ?

Аппликэйшн гэдэг нь ихэнх тохиолдолд хэрэглээний программ гэх утгыг агуулж байдаг. Ингэхдээ гар утсанд зориулагдсан хэрэглээний программыг “аппс” гэх ба энэ нь харагдах байдал болоод хэрэглээний программыг гар утсанд зориулсан жижигрүүлсэн хувилбар юм. Нэг үгээр, хүн ухаалаг гар утас хоёрын ойлголцол юм.

Түүнчлэн аппликэйшн нь өөр өөрийн гэсэн үүрэг зорилготой бүтээгддэг. Нэг сонирхолтой жишээ дурдахад Apple компани католик сүсэг бишрэлтэй хүмүүст зориулж, iPhone смартфонын аппликэйшнийг ашиглан нүглээ наминчлах боломжтойгоор бүтээжээ. Нүглээ наминчлахын тулд заавал сүмд очих шаардлагагүй болсон нь хэрэглэгчдийн таашаалыг хүлээгээд байгаа аж. Аппликэйшн нь энэ мэт хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, хэрэгцээг хангах үүднээс бүтээгддэг. Харин Улаанбаатар хотын хувьд тулгамдаад байгаа асуудлын нэг бол яах аргагүй хот төлөвлөлтийн замбараагүй байдал билээ. Үүнтэй холбоотой иргэдийн дунд аливаа албан байгууллагын хаяг байршлыг олж тогтооход хүндрэлтэй байдаг. Тэгвэл энэ байдлыг цэгцлэх үүднээс “Флай бүүк” компани Улаанбаатар хөтөч систем /Ulaanbaatar guide system/ UGS-ыг бүтээжээ.

Монгол аппликэйшн

UGS нь Монгол улсад мэдээлэлжсэн нийгмийг бий болгох зорилгоор бүтээсэн. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага болон хувиараа бизнес эрхлэгчдийн цахим мэдээллийн санг бүрдүүлж үнэн бодит мэдээллийг нийгэмд хүргэх зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Өдгөө аливаа хүн байгаа газраасаа өөрийн хүссэн мэдээллээ үнэ төлбөргүй авахыг хүсэх болжээ. Харин энэ байдал Монгол улсын хэмжээнд болоод Улаанбаатар хотод боломжгүй зүйл юм. Тухайлбал, та хүүхдээ цэцэрлэгт шинээр өгөх гэж байгаа бол ойр хавьдаа ямар цэцэрлэг байгааг мэдэхэд тун хэцүү, олоход ч амаргүй байдаг. Хаа нэг газраас мэдээлэл авах бол заавал аль нэг лавлах ашиглаж, мөнгө, цаг хугацаагаа алддаг. Харин цахим мэдээллийг хэрэгжүүлж чадсан тохиолдолд ямар нэгэн лавлах болоод танилцуулга номын хуудас эргүүлэх шаардлагагүй болох юм.

“ФЛАЙ БҮҮК” ХХК-ийн “Улаанбаатар хөтөч” систем нь Монгол улсын хамгийн анхны гар утас болон вэб сайт хосолсон цахим хөтөч юм.

Манай цахим мэдээллийн систем нь нийгмийн хэрэгцээнд доорх байдлаар ашигтай. Үүнд:

- Ухаалаг гар утастай хүн бүр үнэ төлбөргүйгээр цахим хөтчийг татаж авах боломжтой
- Хөтчийг гар утсандаа суулгаснаас хойш хэрэглэгчээс интернэт орчин, нэгж, төлбөр шаардахгүй
- Өдөр тутмын мэдээллийн шинэчлэлтийг хүссэн үедээ авах боломжтой
- Хэрэглэгч хаана ч, хэзээ ч ямар ч орчинд Улаанбаатар хоттой холбоотой лавлах мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой
- Мэдээллийг тэгш, хүртээмжтэй авах боломжтой. /жижиг, дунд бизнес эрхлэгчдийн мэдээлэл. Үүнд: хүнсний дэлгүүр, автобусны буудал, гуталчин, хувцас захиалга гэх мэт бүх төрлийн хаяг, байршлын мэдээлэл багтах болно/ ■

ULAANBAATAR GUIDE SYSTEM

ОЛОЛТ АМЖИЛТЫГ ОЙРТУУЛАХ ХӨТӨЧ

МОНГОЛД АНХ УДАА



- АТМ хаяг байршил
- Нийтийн тээвэр
- Дүүрэг хороо
- Үзвэр үйлчилгээ
- Бүх төрлийн байгууллагууд
- Шатахуун түгээх станц
- Эмийн сан

100%

ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ

ТАТАН АВАЛТ

www.ubguide.mn
android market
appstore

АЖИЛЛАХ СИСТЕМ

- Android
- iOS
- Win / Mac

АЖИЛЛАХ ГОРИМ

- online
- offline

11-330960, 8804-5864, 8800-6388 FACEBOOK.COM/UBGUIDE WWW.UBGUIDE.MN

ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨГ НЭВТРҮҮЛСЭНЭЭР

- QMS ISO 9001:2008-Чанарын удирдлагын тогтолцоо
- EMS ISO 14001:2004-Байгаль орчны удирдлагын тогтолцоо
- FSMS ISO 22000:2005-Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо
- OHSAS 18001:2007-ХАБЭА -ын тогтолцоо
- HACCP-Эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо

M.R C&C





M.R C&C Co.,Ltd

- ☑ Тогтолцооны сургалт
- ☑ Чиглүүлэх сургалт
- ☑ Дотоод аудитын сургалт
- ☑ Дотоод аудит хийх зөвлөгөө

Add: №505, Kyokushu tower building
Bayangol district, Ulaanbaatar
Mongolia
Tel: 9910-4027 7013-3090
E-mail: mrcc3090@yahoo.com

M.R C&C



НОГООН

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ